



# АЮУЛ ДУНДАХ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОН ЗАЙ ХУМИГДАЖ БАЙНА

**ЗОРИГТОН**

**ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ**



**Эмнести Интернэшнл нь 7 сая гаруй дэмжигчидтэй даян дэлхийн хөдөлгөөн бөгөөд бид хүн бүр эрхээ эдэлсэн дэлхий ертөнцийг бүтээхийн тулд кампанит ажлууд зохион байгуулдаг.**

**Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад хүний эрхийн баримт бичгээр баталгаажсан бүх эрхийг хүн бүрт эдлүүлэхийг бид хүсдэг.**

**Бид аливаа Засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг, шашны үзлээс хараат бус бөгөөд гишүүнчлэл болон олон нийтийн хандиваар санхүүждэг.**

© Amnesty International 2017  
Except where otherwise noted, content in this document is licensed under a Creative Commons (attribution, non-commercial, no derivatives, international 4.0) licence.  
<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>  
For more information please visit the permissions page on our website: [www.amnesty.org](http://www.amnesty.org)  
Where material is attributed to a copyright owner other than Amnesty International this material is not subject to the Creative Commons licence.  
First published in 2017  
by Amnesty International Ltd  
Peter Benenson House, 1 Easton Street  
London WC1X 0DW, UK

Index: ACT 30/6011/2017  
Original language: English

[amnesty.org](http://amnesty.org)



**Cover photo:** Lenca indigenous women protest the murder of Honduran environmentalist Berta Cáceres in front of the Public Ministry in Tegucigalpa. She was shot on 2 March 2016 after years spent campaigning against the construction of a hydroelectric dam, 5 April 2016  
Credit: © ORLANDO SIERRA/AFP/Getty Images

**ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ**



# АГУУЛГА

<b>ӨМНӨТГӨЛ</b>	<b>4</b>
<b>1. ОРШИЛ</b>	<b>6</b>
<b>2. ХУВЬ ХҮНД ХАЛДАХ</b>	<b>8</b>
2.1 АЛЛАГА БА ХҮЧЭЭР СУРАГГҮЙ БОЛГОХ	8
2.2 ХУУЛЬ ШҮҮХЭЭР ДАРАМТЛАХ	11
2.3 ГУТААН ДОРОМЖЛОХ	14
2.4 ТРОЛЛУУД	15
2.5 НУХЧИН ДАРАХ АЖИЛЛАГАА	17
<b>3. ХАРИЛЦАА ХОЛБООНД НЬ ХАЛДАХ</b>	<b>19</b>
3.1 МӨШГИН ХЯНАЛТ	19
3.2 ИНТЕРНЭТИЙН ХЯНАЛТ	21
<b>4. ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХУМИГДАЖ БУЙ ОРОН ЗАЙ</b>	<b>24</b>
4.1 ТАЙВАН ЗАМААР ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХЭД ХАЛДАХ	24
4.2 ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХЭД СААД УЧРУУЛАХ	26
4.2.1 ГАДААДЫН САНХҮҮЖИЛТЭД ТАВЬСАН ХЯЗГААРЛАЛТ	26
4.2.2 БҮРТГЭЛИЙН ХЯЗГААРЛАЛТ	28
4.3 ЧӨЛӨӨТЭЙ ЗОРЧИХ ЭРХ ЧӨЛӨӨНД ХЯЗГААРЛАЛТ ТАВИХ	29
<b>5. ТӨР БУС ТОГЛОГЧДЫН ӨДҮҮЛСЭН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ</b>	<b>31</b>
5.1 БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГУУД	31
5.2 ЗЭВСЭГТ БҮЛЭГЛЭЛҮҮД	33
5.3 ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРГИЙН БҮЛЭГЛЭЛҮҮД	34
<b>6. ДАВХАР АЛАГЧЛАЛЫН НӨЛӨӨ</b>	<b>36</b>
6.1 ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД	36
6.2 ЛГБТИ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД	38
6.3 ЗАЛУУ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧИД	40
<b>7. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЭРХ</b>	<b>41</b>
<b>8. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b>	<b>44</b>

# ӨМНӨТГӨЛ

Бид айдас, талцал, өөрсдөөсөө бусдыг ад зэтгэр гэж үздэг эрин үед амьдарч байна. Дэлхий даяар “тэдний эсрэг бид” гэсэн хорт үг яриа бүлэг хүмүүсийг нийгэм, улс төрийн бүтэлгүйтэлд буруутган зэмлэхэд хэрэглэгдэж байна.

Хүний эрхийн төлөө тэмцэхээр зориглосон хүмүүс хаа сайгүй, өргөн хүрээнд халдлага, дарамт шахалт, сүрдүүлэг, гүтгэлэг, зүй бус харьцаа, хууль бус баривчилгаанд өртөх боллоо. Тэр ч байтугай амь насыг нь хөнөөж байна.

Өнөөдөр бид Засгийн газар, зэвсэгт бүлэглэл, корпораци, бусад этгээд хүний эрхийг хамгаалах эрхийн эсрэг өргөн фронтоор дайрч байгааг мэдэрч байна. 2016 онд дор хаяж 22 улсад хүмүүс тайван жагсаал цуглаанд оролцсоныхоо төлөө амь насаа алдаж, 63 оронд худал гүтгэлэгт өртөж, 68 улсад ажлаа хийснийхээ төлөө баривчлагдаж, хоригдлоо. 94 оронд айлган сүрдүүлж, биед нь халджээ.

Хүний эрхийн хамгаалагчид нийгмийн бүхий л давхаргыг төлөөлдөг. Тэдний дунд оюутан, орон нутгийн удирдагч, сэтгүүлч, хуульч, хүний эрхийн зөрчлийн хохирогчид, гэр бүлийнхэн нь, эмнэлгийн ажилтан, багш, үйлдвэрчний эвлэлийн гишүүн, шүгэл үлээгч, фермер, байгаль хамгаалагч, бусад хүмүүс байдаг.

Тэд Засгийн газар, корпорациуд эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж байгааг эсэргүүцэж, хүрээлэн буй орчин, цөөнхийг хамгаалж, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эрхийн талаарх уламжлалт саад тотгорууд, хөдөлмөрийн мөлжлөгийн эсрэг тэмцдэг. Мөн шударга бус явдал, ялгаварлан гадуурхалт, хүний эрхийн зөрчил, бусдыг ад зэтгэр гэж буруутгах үзэлтэй үл эвлэрдэгээс өнөөдөр тэдний үг хэлэх эрхэд халдаж байна. Энэхүү аюул ихээхэн ноцтой юм. Жагсаал цуглаан хийх тогтолцоо бүхэлдээ хэврэгшиж, жагсаал цуглаан хийх эрхийг үгүйсгэн, мөшгин хянаж, шууд онилох буюу дарамт, заналхийлэл, бие махбодод халдахаас хамгаалж чадахгүй байгаа зэрэг нь Засгийн газрууд хүний эрхийн хамгаалагчдын “хүчилтөрөгчийн хангамж”-ийг тасалж байгаа хэрэг мөн.

1998 онд олон улсын хамтын нийгэмлэг НҮБ-аас “Хүний эрхийн хамгаалагчид болон иргэний нийгмийг хамгаалах тухай тунхаглал”-ыг зөвшилцөн баталж, хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэх өөрчлөлтийн төлөөлөгчид хэмээн хүлээн зөвшөөрснөөс хойш бараг 20 жил өнгөрлөө. Засгийн газрууд уг тунхаглалыг батлахдаа хүний эрхийн хамгаалагчдыг дэмжиж, ажлаа аливаа саад тогтгор, айдасгүйгээр явуулах боломжоор хангана гэж амалсан. Гэвч өнөөдөр уг тунхаглалын үзэл санаа, заалт илт зөрчигдөх боллоо.

Олон Засгийн газрууд хүний эрхийн хамгаалагчдад илүү эрсдэлтэй, хууль тогтоомж, бодлого батлах болжээ. Тайван жагсаал цуглаан хийгчдийн эсрэг хүч хэрэглэх, нийтээр нь мөшгин хянахыг зөвшөөрөх, гадаадаас санхүүжилт авахыг хориглох, байгууллага бүртгүүлэхэд тавих шаардлагыг чангатгаснаар хүний эрхийн төлөө тэмцэх орон зайг хумиж байна.

Түүнчлэн, хүний эрхийн хамгаалагчдыг гэмт хэрэгтэн, зохисгүй этгээд, “ад зэтгэрийг хамгаалагч” хэмээн ил тодоор шүүмжлэх явдал ихэсчээ. Тэднийг “Гадаадын агент”, “үндэстнийхээ эсрэг ажиллагсад”, “террористууд” хэмээн нэрлэж байна. Бас аюулгүй байдал, хөгжил цэцэглэлт, уламжлалт эрхэм зүйлст хөнөөл учруулагчид хэмээн цоллож байна. Хүний эрхийн хамгаалагчдын хувьд өөрчлөлт авчрахад хэрэгтэй мэдээлэл, сүлжээ арга хэрэгсэл улам багасахын зэрэгцээ тулгарч буй халдлагуудын эсрэг зохих хамгаалалт авах боломж сул халдлага үйлдэгчдэд

хариуцлага тооцох явдал ховор байна. Хүний эрхийн хамгаалагчдыг илүү аюулгүй, шударга дэлхий ертөнцийг бүтээх үйлсийн амин чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэх улс төрийн хүсэл зориг бага хэвээр.

Дэлхий даяар тайван жагсаал цуглааны эсрэг дайрч байгаа ч хүмүүс зүгээр бууж өгч, шударга бус явдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Шударга ёсны төлөөх бидний зүрх сэтгэл хүчтэй бөгөөд юунд ч нугарахгүй. Чухам ийм учраас Эмнести Интернэшнл хүний эрхийн хамгаалагчдыг хүлээн зөвшөөрүүлэх, хамгаалах, илүү аюулгүй орчинд ажиллах боломж олгохыг уриалсан даян дэлхийн кампанит ажил эхлүүлж байна.

Энэхүү кампанит ажлын нэр “Зоригтон” юм.

Шударга бус явдлын эсрэг, хөгжил цэцэглэл, аюулгүй байдал авчрах хоосон амлалтаар хүний эрхийг арилжиж байгаа этгээдүүдтэй зоригтой тэмцэж чадах хүмүүс юу юунаас илүү эрхэм.

Бид бүхэнд хорт яриаг таслан зогсоож, шударга бус явдлын эсрэг тэмцэх хүч чадал бий.

Хамтдаа бид өөрчлөлт авчирч чадна. Эр зоригийг дэмжиж, эр зоригт нэгдэж, эр зоригийг хамгаалж, эр зоригтой байцгаая.



Ерөнхий нарийн бичгийн дарга  
Салил Шетти

# 1. ОРШИЛ

**«... Миний бие хүний төрөлхтний эрхэм зүйлсийн талаар зөвшилцөлд хүрсэн үнэхээр чухал ач холбогдолтой түүхэн үйл явдалд оролцож байна гэж ойлгож байна... Энэ бол гачигдал, дарангуйллаас ангид, хувь хүний мөн чанарыг бүрэн дүүрэн хөгжүүлэх салшгүй эрхийг хүлээн зөвшөөрсөн хэрэг юм. Их танхимд... дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүсийн дунд жинхэнэ эв санааны нэгдэл, ахан дүүсийн уур амьсгал бүрдсэн байв...»**

“Хүний эрхийн түгээмэл тунхаглал” (ХЭТТ)-ын төслийг боловсруулах дэд хорооны гишүүн Хернан Санта Круз, НҮБ, 1948 оны 9-р сар.

70 жилийн өмнө дэлхийн II дайн дууссаны дараа “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” (ХЭТТ)-ыг хэлэлцэх үеийн уур амьсгал өнөөдрийнхөөс маш өөр, хүн төрөлхтөнд ХЭТТ-д заасан эрх чөлөө, шударга ёс, энх тайвны зарчим авчрах үзэл санаа, дэмжлэг хүчтэй байсан.<sup>1</sup> Өнөөдөр эдгээр зарчим алдагджээ.

1998 онд ХЭТТ батлагдсанаас хойш 50 жилийн дараа НҮБ-ын Ерөнхий ассемблей “Хувь хүмүүс, бүлгүүд, нийгмийн бүрэлдэхүүн хэсгийн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн “хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах эрх, үүргийн тухай НҮБ-ын тунхаглал”-ыг (цаашид “Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглал” гэх)<sup>2</sup> зөвшилцлөөр баталсан нь эрх чөлөө, шударга ёсны зарчмыг дахин нотолсон хэрэг юм. Уг тунхаглал хүний эрхийн зарчмыг хамгаалахад иргэний нийгмийн байр суурь чухал болохыг хүлээн зөвшөөрч уг тунхаглалын бүх заалтыг дагаж мөрдөх, нэн ялангуяа хүний эрхийн хамгаалагчид ажлынхаа улмаас хор хөнөөлд өртөхөөс хамгаалах үүргийг улс орнуудад хүлээлгэсэн билээ.

Гэвч өнөөдөр хүний эрхийн хамгаалагчид, тэдний орон зайг ХЭХ-ын тунхаглалд заасан шаардлагад нийцүүлэн дэмжиж, хамгаалахын оронд халдаж байна. Ашиг сонирхолд нь хүний эрх аюул учруулж байна хэмээн үздэг Засгийн газар, зэвсэгт бүлэглэл, компаниуд, бусад эрх мэдэлтэй этгээд хүний эрхийн хамгаалагчдыг дуугүй болгох, нухчин дарах өргөн хүрээтэй тактик, арга хэрэглэж байна.

<sup>1</sup> The Universal Declaration of Human Rights (UDHR) was drafted by representatives from each region of the world, and proclaimed by the UN General Assembly in Paris on 10 December 1948 (General Assembly resolution 217 A), available at [www.un.org/en/universal-declaration-human-rights/index.html](http://www.un.org/en/universal-declaration-human-rights/index.html)

<sup>2</sup> Declaration on the Right and Responsibility of Individuals, Groups and Organs of Society to Promote and Protect Universally Recognized Human Rights and Fundamental Freedoms, 1998, available at [www.ohchr.org/EN/Issues/SRHRDefenders/Pages/Declaration.aspx](http://www.ohchr.org/EN/Issues/SRHRDefenders/Pages/Declaration.aspx)

Энэхүү тайланд хүний эрхийн хамгаалагчдыг дуугүй болгоход хэрэглэдэг арга хэмжээг авч үзлээ. Тэдгээр нь хувь хүнийг заналхийлэх, зодох, амь насыг нь хөнөөхөөс авахуулаад хүний эрхтэй холбоотой үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох хууль тогтоомж хэрэглэн мөшгин хянаж, харилцаа холбоо тогтоох, тайван замаар эвлэлдэн нэгдэх, чөлөөтэй зорчих эрхийг нь хязгаарлах зэрэг юм. Эдгээрийн бүрэлдэхүүн хэсэг нь хүний эрхийн хамгаалагчдын ажлыг нь гутаан доромжлох, хууль бус болгох оролдлого юм.

Уг тайланд хүний эрхийн эмэгтэй хамгаалагчдад бусад хамгаалагчдад учирдаг хадлагаас гадна хүйстэй нь холбоотойгоор бэлгийн хүчирхийлэл, заналхийлэл, дарамт, нэр төрийг нь гутаах явдал нэмж учирдаг талаар онцлон дурдлаа.

Тайлангийн төгсгөлд хүний эрхийн хамгаалагчид, иргэний нийгмийн үйл ажиллагаа явуулах орчныг хумих гэсэн оролдлогын эсрэг төр, хувийн хэвшил, бүс нутгийн ба олон улсын байгууллагуудын зүгээс нэн даруй авч хэрэгжүүлбэл зохих хэд хэдэн зөвлөмжийг тодорхойлсон болно.

#### **ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧ ГЭЖ ХЭН БЭ?**

Эмнести Интернэшнл 1998 онд батлагдсан «Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглал», бусад олон улсын хэм хэмжээнд заасанчлан «Хүний эрхийн хамгаалагч гэдэг нь өөрөө буюу бусадтай хамтран орон нутгийн, үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд үзэн ядалт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг ашиглах буюу сурталчлахгүйгээр хүний эрхийг хамгаалах буюу хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа явуулж байгаа этгээд» хэмээн үздэг.

Хүний эрхийн хамгаалагчид нийгмийн бүхий л давхаргыг төлөөлдөг бөгөөд сэтгүүлч, хуульч, эмнэлгийн ажилтнууд, багш нар, үйлдвэрчний эвлэлийн гишүүд, шүгэл үлээгчид, фермерүүд, хүний эрхийн зөрчлийн хохирогчид болоод хохирогчдын хамаатнууд нь багтдаг. Хүний эрхийг хамгаалах нь мэргэжлийн үүрэг багтдаг эсхүл сайн дурын, цалин хөлсгүй байж ч болно.

Хүний эрхийн эмэгтэй хамгаалагчид хэмээх нэр томъёо нь хүний эрхийн хамгаалагч эмэгтэйчүүд (хүний эрхийн аливаа асуудлаар ажилладаг) болон эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар буюу жендэртэй холбоотой ажилладаг хүний эрхийн хамгаалагчдын (заавал эмэгтэй байх албагүй) аль алиныг хэлнэ.

# 2. ХУВЬ ХҮНД ХАЛДАХ

Хүний эрхийн хамгаалагчдыг ажлаа явуулахад нь саад учруулах зорилгоор Засгийн газрууд, төрийн бус тоглогчдын зүгээс дайрах, халдах явдал түгээмэл. Тийм халдлага нь заналхийлэх, зодох, хүчээр сураггүй болгох, амь насыг нь хөнөөх, гүтгэлгийн кампанит ажил өрнүүлэх, хувь хүнийх нь хувьд болон хийж буй ажлыг нь гутаан доромжлох, зохиомол хэргээр мөрдөн шалгах зэрэг өргөн хүрээг хамардаг. Хэн үйлдсэнээс эс хамаараад дээрх үйлдэл нь хүний эрхийн үйл ажиллагааг зогсоох, бусад хүмүүст хүний эрхийг хамгаалахаас татгалзахыг сануулсан дохио мөн.

## 2.1 АЛЛАГА БА ХҮЧЭЭР СУРАГГҮЙ БОЛГОХ

Хүний эрхийн хамгаалагчдын эсрэг халдлага гарахгүй өдөр гэж бараг байхгүй. Эрсдэлд буй хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах зорилгоор байгуулагдсан Front Line Human Rights Defenders (Тэргүүн шугамын хүний эрхийн хамгаалагчид) ТББ-ын тооцоогоор 2015 онд 156, 2016 онд 281 хүний эрхийн хамгаалагч амь насаа алджээ. 2015 онд алагдсан хүний эрхийн хамгаалагчдын талаас илүү хувь, 2016 онд амь насаа алдагсдын 3/4 илүү хувь Латин Америкийн бүс нутагт ногдож байна. 2016 онд алагдсан хүний эрхийн хамгаалагчдын 49% газар нутаг, хүрээлэн буй орчны асуудлаар ажиллаж байсан бөгөөд тэдний дунд уугуул иргэдийн эрхийг хамгаалагчид олон байсан юм.<sup>3</sup>

### ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН ДҮРСГАЛД: ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛСНЫХАА ТӨЛӨӨ АМИА АЛДСАН ХҮМҮҮСИЙГ ДҮРСАХ НЬ

1998 онд «Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглал» батлагдсанаас хойш 3,500 гаруй хүний эрхийн хамгаалагчид тайван замаар хүний эрхийг хамгаалсныхаа төлөө амь насаа алдаад байна. 2016 оны 11-р сард үндэсний болон олон улсын хүний эрхийн байгууллагуудын эвсэл, Эмнести Интернэшнл 1998 оноос хойш ажлынхаа улмаас төрийн болон улс бус тоглогчдын гарт амь насаа алдсан хүний эрхийн хамгаалагчдын дүрсгалд зориулсан цахим хуудас нээжээ. Дийлэнх тохиолдолд буруутай этгээдийг шалгах буюу, ял оноогогүй.

([www.humanrightsdefendermemorial.org](http://www.humanrightsdefendermemorial.org))

Хүний эрхийн хамгаалагч халдлагад өртөх, амь насаа алдах нь санамсаргүй тохиолдол байх нь ховор бөгөөд ихэнхдээ удаан үргэлжилсэн заналхийлэл, сүрдүүлгийн үр дүн юм. Олон оронд эрх баригчид сүрдүүлгийг мөрдөн шалгадаггүй, ял шийтгэл оногдуулдаггүй, зохих арга хэмжээ авах нь ховор байдаг. Энэхүү эс үйлдэл нь гэмт буруутай этгээдүүд ял завших боломж олгож, заналхийлэл, халдлагаа үргэлжлүүлэхийг зөвшөөрдөг.

2016 оны 3-р сард үл мэдэгдэх этгээдүүд хүний эрхийн хамгаалагч **Абдул Басит Абу-Дахабыг Ливи** улсын Дерна хотод автомашинд бөмбөг дэлбэлэн амийг нь хөнөөжээ.<sup>4</sup> 2016 оны 7-р сарын 1-нд нүүрсний уурхайн өргөтгөлийн эсрэг тэмцэгч, байгаль орчны нэртэй идэвхтэн **Глориа Капитаныг Филиппин** улсын Маривелес хот дахь гэрт нь буудан хороов. Тэрээр орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, амьжиргаанд заналхийлсэн нүүрс хадгалах байгууламж, нүүрсээр ажилладаг цахилгаан станцыг өргөтгөхийн эсрэг тэмцэж байсан юм.

<sup>3</sup> Front Line Defenders, *Annual Report 2016*, available at [www.frontlinedefenders.org/en/resource-publication/annual-report-human-rights-defenders-risk-2016](http://www.frontlinedefenders.org/en/resource-publication/annual-report-human-rights-defenders-risk-2016); Amnesty International, *Indigenous Peoples*, available at [www.amnesty.org/en/what-we-do/indigenous-peoples/](http://www.amnesty.org/en/what-we-do/indigenous-peoples/)

<sup>4</sup> Amnesty International, *Report 2016/2017: The State of the World's Human Rights* (Index: POL 10/4800/2017)



Өнөөдрийг хүртэл Капитаны амийг хөнөөсөн хэрэгт хэн нэгэнд хариуцлага хүлээлгээгүй байна.<sup>5</sup>

**Бүгд Найрамдах Ардчилсан Конго** улсын хүний эрхийн хамгаалагч **Марсел Тенгенеза**<sup>6</sup> 2016 оны 12-р сард цэргийн дүрэмт хувцастай хоёр үл танигдах этгээд буудан хөнөөв. Тэрээр Хөгжлийн асуудлаарх ТББ-уудын Бүс нутгийн зөвлөлд ажилладаг байв. Түүнийг НҮБ-ын ивээл дор Ахмадуудын зөвлөлийн зохион байгуулсан семинарт оролцсоных нь улмаас амийг нь хөнөөсөн хэмээн хамт ажиллагсад нь үзэж, гэр бүл нь уг аллагын талаар иж бүрэн мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг шаардсаар байна. 2017 оны 1-р сард нөхрийнхөө хэргийн талаар Канябаёонга дахь Цэргийн прокурорын албан тушаалтнуудтай уулзахаар оролцсоных нь дараа эхнэрийг нь бага насны хүүхдүүдийнх нь хамтаар 2 цаг саатуулах камерт өөр хоёр хоригдолтой хамт хорьжээ.

Зөвхөн 2017 оны 1-р сард гэхэд **Колумби** улсад хүний эрхийн 10 хамгаалагчийг хөнөөсөн нь 2016 оны сарын дунджаас бараг хоёр дахин нэмэгдсэн үзүүлэлт юм. 2017 оны 1-р сард хүний эрхийн хамгаалагч **Емилсен Манёма**<sup>7</sup>, **Жоэ Хавьер Родаллега** нарын цогцсыг Валле дел Каука мужийн Буенавентурагаас олов. Емилсен Манёма Бахо нь нийгмийн болон хүрээлэн буй орчны шударга ёсны төлөөх уугуул, тариачин иргэдийн эрхийг хамгаалах Калима дахь Энх тайвныг цогцлоох орон нутгийн сүлжээний удирдагч байсан юм.

Хүний эрхийн байгууллагууд, амь насаа алдсан хүмүүсийн гэр бүлийнхэн олон жилийн турш гэмт хэрэгтнүүдэд хариуцлага хүлээлгэхийг шаардаж ирсэн бөгөөд шударга ёс тогтоох, үгүй ядаж аллагын талаар үнэнийг олох гэсэн хүчин чармайлт өөрсдийг нь төдийгүй бусад хүмүүсийг аюулд оруулж, өөр заналхийлэлд өртөж, амь насаа алдахад хүргэдэг.

## ГОНДУРАСЫН ИРГЭН БЕРТА КАСЕРЕС



Berta Cáceres © Goldman  
Environmental Prize

2016 оны 3-р сарын 2-нд байгаль орчны хүний эрхийн хамгаалагч Берта Касерес гэрт нь дайрч орж ирсэн зэвсэгт этгээдүүдийн гарт буудуулж нас барсан бөгөөд үүнийг нь ажилтай нь холбоотой гэж үзэж байна. Энэ хэрэг Гондурас улсад байгаль орчны эрх болон газартай холбоотой эрхийг хамгаалагчдад тулгардаг томоохон бэрхшээлийг харуулж байна. Берта Касерес 1993 онд Гондурасын Ард түмний ба уугуул иргэдийн байгууллагуудын зөвлөл (COPINH)-ийг үүсгэн байгуулагч, уугуул Ленка хүмүүсийн эрхийн төлөө цуцашгүй тэмцэгч байжээ.

2013-2015 оны хооронд COPINH-ийн гишүүд Desarrollos Energéticos S.A. (DESA) компаний хэрэгжүүлж байсан Agua Zarca усан цахилгаан станц барих төслийг эсэргүүцжээ. Берта Касерес, COPINH-ийн хамтран зүтгэгчид бизнесийн ашиг сонирхолд нь аюул учирлаа гэж үзсэн эрх баригчид, бусад улс төрийн бус тоглогчдын зүгээс олон халдлага, заналхийлэлд өртөж байв.

2009 онд Америк хоорондын Хүний эрхийн комисс Берта Касересын амь насыг хамгаалах арга хэмжээ авах шийдвэр гаргасан ч Гондурасын эрх баригчид үр дүнтэй хэрэгжүүлж чадаагүй. Түүнийг 2015 оны 11-р сард COPINH-ийн машинтай явахад нь гурван ч удаа буудаж байв.

<sup>5</sup> Amnesty International, *Report 2016/2017: The State of the World's Human Rights* (Index: POL 10/4800/2017)

<sup>6</sup> HRD Memorial, Marcel Tengeneza, available at [www.hrdmemorial.org/hrdrecord/marcel-tengeneza/](http://www.hrdmemorial.org/hrdrecord/marcel-tengeneza/)

<sup>7</sup> Amnesty International, Colombia: Spike in killings as activists targeted amid peace process (News story, 7 February 2017)

Тэрээр мөшгин хяналт, барьцаалах, сураггүй алга болгох заналхийлэл, халдлага, түүнийг болон хамтран зүтгэгчдийг нь дуугүй болгох, ажилд нь саад учруулах зорилгоор ажлын байранд нь хүч хэрэглэн орох, ажлыг нь гэмт хэрэгт тооцох зэрэгт олонтоо өртжээ.

Түүний хамгаалдаг уугуул иргэдийг айлган сүрдүүлэх явдал Берта Касересын аллагаар дуусаагүй. 2016 оны 3-р сарын 3-12-нд гэр бүлийнхнийг нь, мөн COPINH-ийн гишүүдийг дарамтлаж, айлган сүрдүүлсэн байна. 4-р сарын 15-нд Уугуул ард түмний олон улсын хурлын үеэр гэр бүл, хамт ажиллагсад, үндэсний болон олон улсын байгууллагууд руу зэвсэглэсэн этгээдүүд халдсан ч цагдаагийнхан юу ч хийгээгүй. Олон улсын төлөөлөгчид арга хэмжээ авахыг ятгасны эцэст цагдаа COPINH, бусад байгууллагыг тухайн газраас хамгаалан гаргажээ.

Берта Касересын аллагыг мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж ч уг аллага хүний эрхийн үйл ажиллагаатай холбоотой байж болохыг харгалзан үзсэнгүй. Энэхүү боломжийг шалгахгүй байгаа нь үр дүнтэй, цогц мөрдөн шалгалт хийлгэх эрхийг үгүйсгэсэн юм. Түүнийг алагдсанаас хойш 1 сарын дараа эрх баригчид мөрдөн шалгах ажиллагааг бүх чиглэлээр, хүний эрхийн үйл ажиллагаатай холбогдуулан хийх болно гэж мэдэгдсэн.

Берта Касересын аллагад сэжиглэн 8 хүн хорьсны дотор DESA-гийн менежер, Agua Zarca төслийн хамгаалалт хариуцаж байсан цэргийн офицер нар багтжээ. Берта Касересийн гэр бүл хавтаст хэрэгтэй танилцаж, мөрдөн шалгах ажиллагаанд зохих ёсоор оролцоход ихээхэн бэрхшээлтэйг мэдэгдсэн юм.

Берта Касерес, бусад хүний эрхийн хамгаалагчдын эсрэг зохион байгуулалттай халдлагууд орон нутгийн иргэд болон иргэний нийгмийн зүгээс хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үйл хэргээ зогсоохоос аргагүйд хүрч байна.

Зарим улсад хүмүүсийг хулгайлах, хүчээр сураггүй болгох хэлбэрээр халдлага үйлдэж байна.

**Зимбабве** улсад Засгийн газрыг шүүмжлэгчдийг хүчээр сураггүй болгох явдал түгээмэл хэвээр. 2015 оны 3-р сард сэтгүүлч, ардчиллын төлөө идэвхтэн **Итай Замараг** 5 үл таних этгээд нийслэл Харарре хотын захаас хулгайлжээ. Хулгайлагдахаасаа хоёр хоногийн өмнө тэрээр нэгэн цуглаанд оролцоходоо Зимбабве улсын эдийн засгийн нөхцөл муудаж байгаагийн эсрэг нийтийг хамарсан арга хэмжээ авахыг уриалжээ. Өнөөдрийг хүртэл хувь заяа нь хэрхсэн, чухам хаана байгаа нь тодорхойгүй, эрх баригчид түүнийг хүчээр сураггүй болгосон хэргийг бодитой мөрдөн шалгаж эхлээгүй.<sup>8</sup>

**Бурунди** улсын сэтгүүлч **Жан Бигираманга** 2016 оны 7-р сард Бурунди улсын Үндэсний тагнуулын албаны гишүүд байж болзошгүй хүмүүс авч явснаас хойш сураггүй байна. Ерөнхийлөгч Пьер Нкурунзиза гурав дахь удаагаа сонгуульд өрсөлдөхөөр шийдвэрлэсэн нь тус улсын Үндсэн хууль, арван жил үргэлжилсэн иргэний дайныг төгсгөх Арушагийн гэрээг зөрчсөн хэрэг хэмээн олон хүн үзсэн бөгөөд түүний улмаас 2015 оны 5-р сарын төрийн эргэлт бүтэлгүйтсэнээс хойш хараат бус сэтгүүлчид халдлагад өртөх явдал гарсаар байна.<sup>9</sup>

Крымын төв хэсгийн Бахчисарай орчмын Крымын татар үндэстэн **Эрвин Ибрагимовыг** хамгийн сүүлд 2016 оны 5-р сарын 24-нд харжээ. Хэд хоногийн өмнө хүмүүс мөшгөөд байна хэмээн найзууддаа гомдоллож байжээ. Түүнийг алга болсон өдрийн хяналтын камерт бүлэг хүмүүс хэн нэгнийг хүчээр микробуст оруулсан нь бичигдэж үлджээ. Эрвин Ибрагимов нь 2014 онд Крымын хойгийг **Орос** улс эзлэн авч, хууль бусаар өөртөө нэгтгэсэнээс хойш байгуулагдсан Крымийн Татаруудын эрх болон соёлын өв уламжлалыг хөхиүлэн дэмждэг байгууллага Крымийн Татаруудын Дэлхийн Конгрессын гишүүн байжээ. 2014 оноос хойш Крымын татаруудыг хүчээр сураггүй болгосон хэд хэдэн тохиолдол гарсан.<sup>10</sup>

2017 оны 1-р сарын эхээр **Пакистан** улсад хүний эрхийн 4 хамгаалагчийг хүчний байгууллагынхан хүчээр сураггүй болгосноос хойш өнөөг хүртэл олдоогүй. Эрдэмтэн, яруу найрагч **Салман Хайдер**, блогчид **Асим Саид**, **Ахмад Раза Насир**, **Вакас Горая** нар хулгайлагдсанаасаа хойш 3 долоо хоногийн дараа гэр бүлийнхэнтэйгээ эргэн уулзсан. Тэдний гэр бүлийнхэн хуулиар хориглосон зэвсэгт бүлэглэл Ласкар-э-Жхангвийн зүгээс амь насанд нь заналхийлсэн сүрдүүлэг сонсчээ.

<sup>8</sup> Amnesty International, *Report 2015/2016: The State of the World's Human Rights* (Index: POL 10/2552/2016)

<sup>9</sup> Amnesty International, *Burundian journalist is still missing* (Index: AFR 16/4832/2016)

<sup>10</sup> Amnesty International, *Crimean Tatar activist forcibly disappeared* (Index EUR 50/4121/2016)

Тав дахь идэвхтэн Пакистаны Иргэний дэвшлийн нийгэмлэгийн тэргүүн, Карачи хотод амьдардаг **Самар Аббас** 1-р сарын 7-нд Исламабад хотод ажиллах үедээ сураггүй алга болж өнөөг хүртэл хувь заяа нь хэрхсэн хийгээд хаана байгаа нь мэдэгдэхгүй хэвээр. Эдгээр 5 хүн фэйсбүүк зэрэг цахим сүлжээг ашиглан Пакистан улс дахь хүний эрхийн асуудлын талаар үзэл бодлоо түгээж, шашны цэрэгжилт, цэргийн байгууллагын талаар шүүмжлэлтэй ханддаг байв. Алга болсны дараа Пакистаны зарим хэвлэл мэдээллийн байгууллага тэднийг “төрийн эсрэг” үйл ажиллагаанд буруутгаж, ‘Bhensa’ хэмээх Исламын шашныг гутаан доромжилсон фэйсбүүк хуудастай холбохын зэрэгцээ зарим тохиолдолд хүчирхийллийг дэвэргэсэн хэмээн хилсдүүлжээ.<sup>11</sup>

## 2.2 ХУУЛЬ ШҮҮХЭЭР ДАРАМТЛАХ

Дэлхий даяар эрх баригчид хүний эрхийн хамгаалагчдыг хуулиар далайлгах, хүний эрхийн үйл ажиллагааг хязгаарлах, тэр бүү хэл саад тотгор учруулах зорилгоор дарамтлахад эрүү, иргэний захиргааны хууль ашиглах явдал өслөө.

Хүний эрхийн хамгаалагчдад үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэх явдал түгээмэл. Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих тэдний чадварт саад учруулах үүднээс дур зоргоор баривчлах, шударгаар шүүлгэх эрхийг хасах бусад аргыг хэрэглэдэг.

Эрүүгийн хэрэг үүсгэх нь гэм буруутай нь тогтоогдсон эсэхээс үл хамаараад хүний эрхийн хамгаалагчдад ихээхэн сөрөг нөлөө үзүүлж, эрч хүч, нөөц боломжийг нь шавхдаг.

2016 оны 2-р сард Палестины хуульч Фарид аль-Атраш, залуу идэвхтэн Исса Амро<sup>12</sup> нарыг Израйлийн эрх баригчид Хеброны Баруун эргийн хуучин хотын зарим хэсгийг хааж, Палестинчуудын зорчих эрхэд ялгаварлан гадуурхсан хязгаарлалт тогтоосны 22 жилийн ойг тэмдэглэх тайван жагсаалын үеэр Израйлийн цэргүүд баривчилж, удалгүй сулласан ч дараа нь хууль бус жагсаалд оролцсон, цэргүүдийн биед халдсан хэрэг тулгасан юм. Тэдний хэргийг цэргийн шүүхээр хэлэлцэж байгаа бөгөөд хэрэв гэм буруутай нь тогтоогдвол хорих ялаар шийтгэнэ. Баривчилгааны дүрс бичлэгээс харахад тэрээр баривчлагдахаасаа өмнө Израйлийн цэргүүдийн өмнө тайвнаар самбар барьж зогссон гэсэн Фарид аль-Атрашийн мэдүүлэг үнэн болох нь батлагджээ.

2014 оны 3-р сард Шри Ланкийн эрх баригчид Засгийн газрын “Сэргээн засах төв”-д өөрийнх нь сураггүй алга болсон байж магадгүй хүүхдийн зургийг харсныхаа дараа шударга үнэнийг тогтоохыг шаардан олон нийтийн кампанит ажил өрнүүлсэн Балендран Жеякумари хэмээх Тамил ээжийг баривчлан бараг бүтэн жил үндэслэлгүй хорьсны эцэст 2015 оны 3-р сард тодорхой нөхцлөөр сулласан ч оргодол босуул орогнуулж байсан хэрэгт холбогдуулан мөрдөн шалгасан. Жеякумариг 2015 оны 9-р сард мина илрүүлэгч хулгайлсан хэрэгт оролцсон хэмээнд ахин баривчилж, долоо хоног хорьжээ. Түүнээс хойш Балендран Жеякумараг цагдаа хэд хэдэн удаа байцаажээ.<sup>13</sup>

Терроризм, хар тамхины наймаа, үндэсний аюулгүй байдал, хэт даврагсдын эсрэг өргөн хүрээтэй, бүрхэг заалттай хууль тогтоомжийн дагуу хүний эрхийн хамгаалагчдад хэрэг тулгадаг. Мөрдөн шалгах ажиллагаа явагдах үеэр дансыг нь царцааж, технологийн материалыг хураан авдаг. Зарим тохиолдолд хөдөлгөөнд оролцох буюу хүний эрхийн байгууллагын гишүүн байх нь мөрдөн мөшгилтөд өртөх шалтгаан болдог.

---

<sup>11</sup> Amnesty International, *Activists reunite with families; one still missing* (Index: ASA 33/5603/2017)

<sup>12</sup> Amnesty International, *Israel/OPT: Two Palestinian human rights defenders on trial: Faris Al-Atrash and Issa Amro* (Index: MDE 15/5294/2016)

<sup>13</sup> Amnesty International, “Only justice can heal our wounds” - Listening to the demands of families of the disappeared in Sri Lanka (Index: ASA 37/5853/2017)

## АНУ-ЫН ИРГЭН ЭДВАРД СНОУДЕН



Edward Snowden, former US intelligence officer and whistle-blower, in Moscow, Russia, 16 October 2016  
© Amnesty International

Шүгэл үлээгч Эдвард Сноуденд олон нийтийн ашиг сонирхолд чухал ач холбогдолтой мэдээлэл задалсан хэргээр АНУ-ын шоронд 30 жил хорих ял тулгаад байна. Үндэсний аюулгүй байдлын агентлагийн гэрээт ажилтан асан Сноуден 2013 оны 6-р сард АНУ-ын тагнуулын баримт материалыг сэтгүүлчдэд өгсөн нь АНУ, Их Британий Засгийн газруудын Австрали, Канад, Шинэ Зеландын оролцоотой дэлхий даяарх нийтийг хамарсан хяналт аюулын харанга дэлдэхүйц асар өргөн цар хүрээг хамарч байгааг илчилсэн билээ.

Задалсан мэдээлэл нь Засгийн газрууд хувь хүний харилцаа холбоо, хувийн цахим шуудан, утасны байршил, вэбийн түүх, бусад асар их мэдээллийг нууцаар цуглуулдаг болохыг харуулжээ. Түүний үйлдэл нь хувь хүний нууцыг илүү сайн хамгаалахад туслах заалтыг хууль тогтоомжид оруулах дэлхий нийтийн хэлэлцүүлгийг эхлүүлсэн юм.

Эдвард Сноуден “олон нийтэд тэдний нэрийн өмнөөс, өөрсдийнх нь эсрэг хийж байгаа зүйлсийн талаар мэдээлэл өгөх” зорилготой гэж мэдэгдсэний хариуд АНУ-ын Засгийн газар “урвагч” гэж цолложээ. Тэд түүнийг 1917 оны Тагнуулын тухай хуулиар ОХУ-аас шилжүүлэн авахыг эрмэлзэж байна. Сноуден 2013 оны 6-р сард Оросод дүрвэн гарч тэр цагаас хойш тус улсад амьдарч байгаа юм.

АНУ-ын өндөр албан тушаалтнууд шүүх хурал хийлгүйгээр буруутгаж, шүүхийн шийдвэр гарах хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхийг нь зөрчсөн. Түүний хэргийг АНУ-д шударгаар шүүх эсэх нь асуудлыг ноцтой болгож байгаа бөгөөд олон нийтийн эрх ашгийг хамгаалсан түүнийг үйлдлийг өмгөөлөх боломжгүй болгож магадгүй юм. Түүнчлэн тэрээр АНУ-д буцаж очвол хүний эрхийн бусад зөрчилд өртөх эрсдэлтэй.

АНУ-ын эрх баригчид паспортыг нь хүчингүй болгосноороо чөлөөтэй зорчих, орогнол хүсэх эрхэд нь халдаж, орогнол олгосон улс орнууд руу зорчих боломжгүй хэвээр байна.

Түүний хэрэг засгийн газрууд хуулийг гуйвуулан ашиглаж, хүний эрхийн зөрчлийг илчилсэн, өөрсдийнх нь нуухыг хүссэн мэдээллийг задалсан хүмүүст хэрэг үүсгэж, мөрдөн шалгаж, олон нийтийн эрх ашигт нийцсэн бусад мэдээллийг задлахаас айж эмээдэг уур амьсгалыг бий болгож байна.

Сүүлийн жилүүдэд хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох, дуугүй болгох зорилготой харгис, хязгаарласан шинжтэй шинэ хууль тогтоомж олноор батлагдах болсон төдийгүй олон улсын хүний эрх зүй, хэм хэмжээнд нийцээгүй хууль тогтоомжууддаа өөрчлөлт оруулахгүй байна. Тайван жагсаал цуглаан зохион байгуулах, оролцож байхдаа хүчирхийлэлд уриалсан гэх хэргийг хүний эрхийн хамгаалагчдын эсрэг түгээмэл хэрэглэдэг.

**Свазиланд** улс 1938 оны Өдөөн хатгах ба хорлон сүйтгэх ажиллагааны тухай хууль, 2008 оны Терроризмыг устгах тухай хуулийг ялангуяа тогтворгүй байдал даамжирсан үед Засгийн газрыг шүүмжлэгчдийг дуугүй болгох үүднээс хэрэглэж заншчээ. 2016 оны 9-р сард Дээд шүүхээс холбогдох хуулийн зарим заалт Үндсэн хуульд харшилж байна гэсэн шийдвэр гаргасан ч засгийн газар давж заалдаад байна.<sup>14</sup>

<sup>14</sup> Amnesty International, *Report 2016/2017: The State of the World's Human Rights* (Index: POL 10/4800/2017)

2016 оны 8-р сард **Бангладеш** улс 22 настай **Дилип Рой** хэмээх оюутныг фэйсбүүкээр Ерөнхий сайд болон эрх баригч нам дэлхийн хамгийн том халуун орны ойн дэргэд нүүрсээр ажилладаг цахилгаан станц барих гэж байгааг шүүмжилснийх нь төлөө 2013 онд батлагдсан Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн тухай хуулийн дагуу баривчилжээ. Уг хуулийг тус улс Засгийн газрыг шүүмжлэгчид, хүний эрхийн хамгаалагчид, шашны цөөнхийн эсрэг ашигладаг. Түүнийг 3 сарын дараа батлан даалтаар сулласан ч албан ёсоор огт хэрэг үүсгэлгүй, мөрдөн шалгаж байгаа бөгөөд хэрэв гэм буруутай нь тогтоогдвол 14 хүртэл жил хорьж магадгүй юм.

**Малайз** улс өргөн хүрээтэй, харгис хууль тогтоомжийг хүний эрхийн хамгаалагчид, Засгийн газрыг шүүмжлэгчдийг мөрдөн шалгаж, хэрэг үүсгэхэд ашиглаж байна. 2016 оны 11-р сард хүний эрхийн хамгаалагч **Мария Чин Абдуллаг** сонгуулийн шинэчлэл, сайн засаглалын төлөө олон мянган хүн оролцсон жагсаал удирдсаных нь төлөө баривчлах зөвшөөрөлгүйгээр Аюулгүй байдлын гэмт хэрэг (Тусгай арга хэмжээ)-ийн тухай хуулийн дагуу 11 хоногийн турш ганцаарчлан хорьжээ.<sup>15</sup> Сүүлийн жилүүдэд Мария Чин Абдулла бусад хүний эрхийн идэвхтнүүдийг иймэрхүү жагсаал цуглаан зохион байгуулсан буюу оролцсоных нь төлөө “Тайван жагсаал цуглааны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу мөрдөн шалгах, хэрэг үүсгэх явдал давтагдах” боллоо.

**Казакстаны** 2016 оны Эрүүгийн хуульд нийгмийн болон бусад “зөрчил”-ийг дэвэргэх гэсэн маш бүрхэг томъёололтой заалт хэвээр үлддэг.<sup>16</sup>

**Хятад** улсад 2015 оноос хойш батлагдсан олон шинэ хуулиуд үндэсний аюулгүй байдалд гол анхаарлаа хандуулж, үг хэлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх зэрэг өмнөх хуулиудаар ч хязгаарладаг эрх, эрх чөлөөг улам хумихаар заналхийлж байна.<sup>17</sup> Түүнчлэн Өмнөд **Солонгост** 2015 онд Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн үйлчлэх хүрээг өргөтгөж, улс төрчдийг багтаах болсон нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах боломж олгосон юм.<sup>18</sup>

**Этиоп** улсад “гадаадын” байгууллагуудад хүний эрхийн үйл ажиллагаа (болон бусад үйл ажиллагаа) явуулахыг хориглон хүний эрхийн хамгаалагчдыг терроризмын гэмт хэрэгт холбогдуулан хорьдог.<sup>19</sup> 2015 онд Камбож улс эвлэлдэн нэгдэх эрхэд заналхийлсэн ТББ-уудын тухай хууль батлан гаргажээ.<sup>20</sup>

**Алжир**<sup>21</sup>, **Марокко**<sup>22</sup> улсын эрх баригчид “гутаан доромжилсон” буюу нэр төрд халдсан агуулгатай харилцаа холбоог гэмт хэрэгт тооцох ерөнхий заалттай хууль тогтоомж хэрэглэдэг Засгийн газрыг шүүмжлэгчдийг цагдан хорих боломж олгож байгаа юм.

**Йордан** улсад зөвхөн 2016 онд гэхэд Эзэн хаан болон Засгийн газрыг шүүмжлэхийг хориглосон Эрүүгийн хуулийн заалт, 2014 онд нэмэлт өөрчлөлт оруулсан, гадаадын удирдагчид, гадаад улсыг шүүмжлэхийг гэмт хэрэгт тооцдог Терроризмын эсрэг хуулийн дагуу олон арван этгүүлчид, идэвхтнүүдийг мөрдөн шалгаж байна.<sup>23</sup> 2014 онд **Саудын Араб** улсад хүний эрхийн хамгаалагч, хуульч **Валид Абу аль-Хайрыг** мөн онд батлагдсан Терроризмын эсрэг хуулиар олон гэмт хэрэг, түүний дотор “удирдагчийн үгнээс зөрсөн”, “зөвшөөрөлгүй байгууллага [Саудын Арабын хүний эрхийн хяналт] байгуулсан” зэрэг хэрэгт буруутган 15 жил хорих ял оноож, 15 жил гадаад руу зорчих эрхийг нь хоригложээ. Тэрээр тайван замаар тэмцэгч олон идэвхтнүүд, шоронд хоригдож байгаа блогчин **Райф Бадави** нарыг өмгөөлж байсан бөгөөд Саудын Арабын хүний эрхийн нөхцлийг хурцаар шүүмжилдэг байлаа.<sup>24</sup>

**Мавритани** улсад боолчлолын эсрэг хүний эрхийн хамгаалагчид мөрдөн шалгалтын дарамт шахалт олон жилийн турш амсч байна. Боолчлолын эсрэг хөдөлгөөний удирдагч **Бирам Дах Абейдад** зохиомол хэрэг тулган 2010-2016 оны хооронд 3 удаа шоронд хорив.

<sup>15</sup> Amnesty International, Malaysia: Drop travel ban on Zunar and other government critics (Index: ASA 28/5013/2016)

<sup>16</sup> Amnesty International, Report 2016/2017: The State of the World's Human Rights (Index: POL 10/4800/2017)

<sup>17</sup> Amnesty International, Report 2016/2017: The State of the World's Human Rights (Index: POL 10/4800/2017)

<sup>18</sup> Amnesty International, South Korea: National security law continues to restrict freedom of expression (Index: ASA 25/001/2015)

<sup>19</sup> Amnesty International, Stifling human rights work: The impact of civil society legislation in Ethiopia (Index: AFR 25/002/2012)

<sup>20</sup> Amnesty International, Cambodia: Withdraw draft law on association and non-governmental organizations (Index: ASA 23/1909/2015)

<sup>21</sup> Amnesty International, Algeria – Impunity past and present: Amnesty International submission for the UN Universal Periodic Review 27th Session (Index: MDE 28/5468/2016)

<sup>22</sup> Amnesty International, Morocco: Submission to the United Nations Human Rights Committee 118th session, 17 October-14 November 2016 (Index: MDE 29/4858/2016)

<sup>23</sup> National Center for Human Rights, Statement, July 2016, available at [www.nchr.org.jo/english/DataCenter/News/tabid/96/newsid445/74](http://www.nchr.org.jo/english/DataCenter/News/tabid/96/newsid445/74)

<sup>24</sup> Amnesty International, New anti-terror law used to imprison Saudi Arabian human rights activist (Press release, 7 July 2014)

Боолчлолын эсрэг хүний эрхийн бусад олон хамгаалагчдыг нийслэл Нуакчот дахь Буамату хэмээх ядуусын хорооллын газрыг албадан чөлөөлөхийн эсрэг жагсаал болсны дараа хэдийгээр хэн нь ч уг үйл явдалд ямар нэг байдлаар оролцоогүй, очоогүй ч баривчлан бослого гаргасан, хүчирхийлэл үйлдсэн, цагдаад халдсан, зөвшөөрөлгүй байгууллагад элссэн зэрэг хэрэг тулгажээ. Тэдний хоёр нь буюу **Абдаллах Мааталла Сек, Мусса Билал Бирам** нар 2017 оны 3-р сарын байдлаар хууль бусаар хоригдсон хэвээр.<sup>25</sup>

**Нигериа** улсад муж, холбооны эрх баригчид хууль тогтоомжийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг нухчин дарахад ашиглаж байна. Тухайлбал, Лагос хотод хүний эрхийн хамгаалагч **Раймонд Гольд** Integrated Oil and Gas компанийг газрын тос боловсруулах үйлдвэр барихаар бэлтгэж буй газрынхаа байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхийг шаардсанаа төлөө гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байна. Тус компаний Аюулгүй байдал хариуцсан захирал Лагос мужийн Засгийн газрын агентлагаар дамжуулан түүнд заналхийлж байв.

## 2.3 ГУТААН ДОРМЖЛОХ

Хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор гутаан доромжлох, нэр төрийг нь гутаах явдал түгээмэл, эрх баригчид, бусад эрх мэдэлтнүүд харлуулсан мэдэгдэл хийдэг. Хүний эрхийн хамгаалагчдыг зохиомол, түүний дотор терроризмын (ерөнхий томъёолсон хуулиар) хэрэгт холбогдуулан шалгаж, гэмт хэрэгтэн, эх оронч бус, авлигачин, “гадаадын агент”, нууц бүлгэмийн тагнуул, “төрийн дайсан”, “хэрүүл маргаан өдөөж, гай тарьдаг”, үндэсний болон ёс суртахууны эрхэм зүйлсийг эсэргүүцэгч хэмээн буруутгадаг.

Хуваагдмал, нийгэмд гутаан доромжлох үйлдэл нь Засгийн газрын дэмжигчдийг хүний эрхийн хамгаалагчдын эсрэг турхирч, тэр ч байтугай засгийн газрыг дэмждэг зэвсэгт бүлэглэлүүд, бусад төрийн бус тоглогчдын зүгээс бие махбод, амь насанд халдах эрсдлийг өсгөдөг.

**Венесуэл** улсад хүний эрхийн хамгаалагчдад эрх баригчдын зүгээс халдах явдал түгээмэл. Дээд албан тушаалтнууд хүний эрхийн хамгаалагчдыг үгүйсгэхийн тулд байнга шүүмжилдэг, хувь хүмүүс, иргэний нийгмийн байгууллагуудын нэр төрийг гутаахын тулд худал цуу яриа тараадаг.

**Пакистан** улсад үзэл бодлоо нээлттэй илэрхийлдэг хүмүүс хэвлэл мэдээллээр нэр төрийг нь гутаах кампанит ажлын байр болох нь олонтаа. Тухайлбал, Бол телевизийн *Aisay Nahi Chalay Ga* шоу нэвтрүүлгийг хүний эрхийн хамгаалагчид, сэтгүүлчид, иргэний нийгмийн идэвхтнүүд, блогчдыг “Аллахыг доромжлогчид”, “Пакистаны төрийн эсрэг”, Пакистан улсын тагнуулын алба, армийн эсрэг үзэлтнүүд” хэмээн харуулахад ашиглажээ. Түүний улмаас уг шоу нэвтрүүлэг дурдагдсан хэд хэдэн хүн амь насанд нь заналхийлсэн сүрдүүлэг хүлээн авсан юм. Сүүлийн жилүүдэд Аллахыг доромжилсон хэмээн гүтгэх, нэр хүндийг гутаах кампанит ажлын улмаас сэтгүүлчид, идэвхтнүүд, халдлагад өртсөнөөс гадна амь насаа алдсан тохиолдол ч гарсан.<sup>26</sup>



### БЕЛАРУСИЙН ИРГЭН ЛЕАНИД СУДАЛЕНКА

Беларусийн Зүүн өмнөд нутгийн Хомел хотын хүний эрхийн хамгаалагч Леанид Судаленкаг цахим шуудангаа хакердуулсных нь дараа садар самуун сурталчилсан материал тараасан хэмээх хуурамч хэрэг тулгажээ. Тэрээр материалыг өөрийн компьютерээс илгээгээгүй гэдгээ батлаж чадахгүй аваас 2-4 жил хорих ял оноох аюул тулгараад байгаа юм.

2015 оны 4-р сард Леанид Судаленкаг Швед улсад олон улсын хүний эрхийн бага хуралд оролцох хойгуур нь садар самуун сурталчилсан материал тараахыг хориглосон хуулийн дагуу цагдаа албан өрөө, гэрийг нь нэгжиж, 8 компьютер хураан авсан байна.

Тэрээр “Энэ бүхэн нэр хүнд гутааж, хүний эрхийн үйл ажиллагааг зогсоох эрх баригчдын оролдлого” байсан гэж үзсэн. Мөрдөн байцаагчид садар самуун сурталчилсан материалыг түүний компьютерээс татварын алба, дүүргийн байцаагчид руу явуулсан байна гэж мэдэгдсэн. Цахим шуудангийн хаягийг нь хакердан тэдгээр материалыг илгээгүй гэдгээ нотолж чадсан.

<sup>25</sup> Amnesty International, *Report 2016/2017: The State of the World's Human Rights* (Index: POL 10/4800/2017)

<sup>26</sup> Amnesty International, *Pakistan: Open letter calling for greater protection of human rights defenders* (Index: ASA 33/5792/2017)

Леанид Судаленкагийн эсрэг үүсгэсэн хэргийг хаасан ч Беларусь, Шведийн нэр хүндтэй хүний эрхийн хамгаалагчид, олон улсын хүний эрхийн байгууллагуудын зүгээс асар их дэмжлэг үзүүлээгүй бол ял сонсох нь ойлгомжтой байсан гэдэгт эргэлзэхгүй байгаа юм.

Леанид Судаленкагийн хувийн нууцтай байх эрх зөрчигдсөн төдийгүй гэмт хэрэгтэн, зохисгүй этгээд хэмээн доромжлон гутаагдсан.

#### **Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид**

Хүйсийн илэрхийлэл, хүйсийн үүрэг, эмэгтэйчүүдийн нийгэм, гэр бүлдээ, орон гэртээ эзлэх байр суурийн талаар хатуу ойлголттой газарт ажилладаг эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдыг онилох явдал түгээмэл тохиолддог. Бие махбодын халдлага нь эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдыг хүйсийн уламжлалд албадан оруулахын тулд бэлгийн халдлага, хүчингийн хэлбэрээр илэрдэг.<sup>27</sup>

2017 онд НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын асуудлаарх Тусгай илтгэгч Мексикийн хүний эрхийн хамгаалагчдыг гутаан доромжлох, нэр төрд нь халдах кампанит ажил нь "...эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдын эсрэг чиглэхдээ хүйст суурилсан маш хүчтэй бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд эмэгтэйчүүдийг биеэ үнэлэгч, ёс суртахууны нандин чанаргүй хэмээсэн доромжлол багтдаг. Хүний эрхийн хамгаалагчдыг шууд бусаар дарамтлахын тулд гэр бүлийн гишүүд, айл хотлын хүмүүсийг нь онилж болох бөгөөд хамаатан саднаа хамгаалах уу, хүний эрхийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх үү гэдгээ сонгохыг хүчээр тулгадаг."<sup>28</sup> хэмээн онцлон дурдсан.

Тухайлбал, Эль Сальвадор улсад албан тушаалтнууд үр хөндөлтийг хуулиар зөвшөөрүүлэх, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн төлөө ажилладаг байгууллагуудыг "ёс суртахуунгүй", "аллагыг дэмждэг", "эмзэг эмэгтэйчүүдийг ашигладаг гэмт хэрэгтнүүд" гэсэн мэдэгдлүүдээр онилж байв.<sup>29</sup>

## **2.4 ТРОЛЛУУД**

**«Тэд чамайг алахгүй ч амьдралыг чинь сүйрүүлнэ. Троллууд байнгын айдастай уур амьсгал бүрдүүлдэг бөгөөд хүмүүсийг хэвлэж, нийтлэхээс нь татгалзуулдаг.»**

Мексикийн хүний эрхийн хамгаалагч Альберта Эскорсиа<sup>30</sup>

Зарим хүний эрхийн хамгаалагчдыг "троллууд" гэж нэрлэгддэг үл таних цахим өрсөлдөгчид гутаан доромжилж, заналхийлдэг. Идэвхтнүүд, хүний эрхийн хамгаалагчид, олон сэтгүүлчийн хувьд троллууд зүгээр нэг цахимаар залхаадаг хүмүүс биш юм. Тэд маш боловсронгуй зохион байгуулалттай сүлжээ бөгөөд зарим тохиолдолд онлайн идэвхтнүүдийг хайж олон гутаах, айлган сүрдүүлэх, амь насанд нь заналхийлэхэд нь зориулж Засгийн газрууд, хувийн компаниуд санхүүжилт олгодог.

Троллуудын сүлжээ сүүлийн үед өргөн хүрээтэй хуурамч мэдээлэл түгээх кампанит ажлыг өөрсдийн тактикт нэмэн зарим үед хүний эрхийн хамгаалагчид, сэтгүүлчдийг гутаахын тулд хүмүүсийг хөлсөлж ажиллуулдаг. Троллууд халдлагыг холбогдох нийгмийн сүлжээнд мэдээлсэн ч ор мөргүй алга болохгүй.

**Филиппин** улсын Засгийн газрын "хар тахины эсрэг дайн"-ы талаар шүүмжлэлтэй ханддаг хүний эрхийн хамгаалагчдыг байнга айлган сүрдүүлж, цахимаар дарамталдаг.<sup>31</sup>

<sup>27</sup> Women Human Rights Defenders International Coalition, *Global Report on the Situation of Women Human Rights Defenders*, 2012, p. 20, available at [www.defendingwomen-defendingrights.org/wp-content/uploads/2014/03/WHRD\\_IC\\_Global-Report\\_2012.pdf](http://www.defendingwomen-defendingrights.org/wp-content/uploads/2014/03/WHRD_IC_Global-Report_2012.pdf)

<sup>28</sup> Office for the High Commissioner for Human Rights, End of mission statement by the United Nations Special Rapporteur on the situation of HRDs, Michel Forst, on his visit to Mexico from 16 to 24 January 2017, available at [www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=21111&LangID=E](http://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=21111&LangID=E)

<sup>29</sup> Amnesty International, *Defenders under attack! Promoting sexual and reproductive rights in the Americas* (Index: AMR 01/2775/2015)

<sup>30</sup> Amnesty International, Mexico's misinformation wars: How organized troll networks attack and harass journalists and activists in Mexico, 2017, available at [www.medium.com/amnesty-insights/mexico-s-misinformation-wars-cb748ecb32e9#.n5zpb7oah](http://www.medium.com/amnesty-insights/mexico-s-misinformation-wars-cb748ecb32e9#.n5zpb7oah)

<sup>31</sup> Amnesty International, *Philippines: "If you are poor, you are killed": Extrajudicial killings in the Philippines' "war on drugs"* (Index: ASA 35/5517/2017)

Твиттер компани бусдыг дарамталсан контент, хуурамч аккаунттай холбоотой гомдлын талаар сүүлийн үеийн мэдээлэл авахад ихээхэн хүндрэлтэй **Мексик** зэрэг улсад нэлээд бэрхшээл тохиолддог хэмээн мэдэгдэж, техникийн хувьд бие биенээсээ давж гарах гэсэн төгсгөлгүй тоглоом гэж тодорхойлжээ. Учир нь твиттерийн спамаас хамгаалах баг дайралтын эсрэг авах арга хэмжээгээ сайжруулахад троллууд ч гэсэн аргаа нарийсгадаг гэх мэт.

Мексикийн хүний эрхийн хамгаалагч **Альберто Эскорсиа** “Би өдөрт дунджаар троллуудын зохиосон, хамгийн их хандалттай 2-3 сэдэв олж хардаг. Тэд өдөрт 1000-3000 удаа жиргэдэг. Олон тролл ямар нэг түүхийг нийтэд цацах эсхүл сэтгүүлчдийн нэр төрийг гутаах, дайралт хийх зорилгоор бусдаас мөнгө авсан “гэмт бүлгэмийн гишүүн байдаг.” гэж “Эмнести Интернэшнлд ярьлаа.”<sup>32</sup>



## МЕКСИК УЛСЫН ИРГЭН КАРМЕН АРИСТЕГИ

Кармен Аристеги бол Мексикийн баячууд, эрх мэдэлтнүүдийн холбогдсон хэд хэдэн авлигын хэргийг илрүүлсэн нэр хүндтэй, эр зоригтой эрэн сурвалжлагч сэтгүүлч бөгөөд Засгийн газрыг олон удаа ил тодоор шүүмжилж байсан юм.

Түүнийг үндэсний радиогоос хоёр удаа ажлаас халж 2014 онд Ерөнхийлөгч Пена Ниетогийн худалдан авсан байшингийн талаар нийтэлснийхээ улмаас нэр төр гутаасан хэргээр иргэний шүүхэд дууджээ.

Сүүлийн жилүүдэд Кармен Аристегийн тайлангууд айлган сүрдүүлж, гутаан доромжлох гэсэн өргөн хүрээг хамарсан, зохион байгуулалттай троллын халдлагын бай боллоо. 2015 онд түүнийг Мексикийн харилцаа холбооны магнат Карлос Слимээс хахууль авсан гэж буруутгасан дүрс бичлэг фэйсбүүкт тавигдсанаар тэр дороо твиттерт #LosSecretosdeAristegui (Аристегийн нууцууд) троллын довтолгоо болж хувирсан юм.

Кармен Аристеги одоогоор бие даасан онлайн мэдээллийн портал ажиллуулдаг ч троллын халдлага бүр уг порталын чадавхийг 20-50% бууруулдаг байна. Учир нь порталын ажилтнууд халдлагад хариу өгөхөөр завсар чөлөөгүй ажиллах хэрэгтэй болдог.<sup>33</sup>

Нэр төрд халдсан кампанит ажлууд хүний эрхийн хамгаалагчид, сэтгүүлчдэд ихээхэн хор хөнөөл учруулснаар нэр хүндэд нь халдсан, хийж буй ажлаас нь хөндийрүүлсэн дуулиан шуугиан болгоныг залруулах шаардлагатай тулгардаг.

<sup>32</sup> Amnesty International, Mexico's misinformation wars: How organized troll networks attack and harass journalists and activists in Mexico, 2017, available at [www.medium.com/amnesty-insights/mexico-s-misinformation-wars-cb748ecb32e9#.n5zpb7oah](http://www.medium.com/amnesty-insights/mexico-s-misinformation-wars-cb748ecb32e9#.n5zpb7oah)

<sup>33</sup> Amnesty International, Mexico's misinformation wars: How organized troll networks attack and harass journalists and activists in Mexico, 2017, available at [www.medium.com/amnesty-insights/mexico-s-misinformation-wars-cb748ecb32e9#.n5zpb7oah](http://www.medium.com/amnesty-insights/mexico-s-misinformation-wars-cb748ecb32e9#.n5zpb7oah)



## 2.5 НУХЧИН ДАРАХ АЖИЛЛАГАА

НҮБ гэх мэт олон улсын байгууллага, Европын холбоо зэрэг бүс нутгийн механизмтэй харилцаа холбоотой байх явдал хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагаанд амин чухал юм. Эдгээр байгууллагатай харилцах нь хүний эрхийн үнэтэй мэдээллийг холбогдох талуудад хүргэх боломж хүний эрхийн хамгаалагчдад олгохын зэрэгцээ иргэний нийгмийн бусад тоглогчидтой хэлхээ холбоо тогтоох орон зайг бүтээдэг. Олон улсын байгууллагуудтай харилцах эрхийн талаар “Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглал”-ын 5(с), 9(4)-р зүйлд болон бусад олон улсын гэрээ конвенцид, түүний дотор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон чөлөөтэй зорчих эрхтэй холбоотой гэрээ конвенцид заасан байдаг.<sup>34</sup>

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн (ХЭЗ) 2009 оны 12/2 тоот<sup>35</sup>, 2013 оны 24/24 тогтоолд<sup>36</sup> нухчин дарах ажиллагаа гэдгийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

«Дараах хүмүүсийн эсрэг айлган сүрдүүлэх эсхүл нухчин дарах бүх үйлдлийг ойлгоно:

(а) НҮБ, түүний хүний эрхийн салбарын төлөөлөгчид буюу механизмтай хамтран ажиллахыг эрэмэлзсэн буюу хамтран ажилласан, эсхүл тэдэнд мэдүүлэг буюу мэдээлэл өгсөн хүмүүс;

(б) НҮБ-ын ивээл дор хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах зорилгоор байлгасан дүрэм журмаар асуудлаа шийдүүлэхийг эрэмэлзсэн хүмүүс, тэрчлэн тийм зорилгоор тэдэнд эрх зүйн болон бусад туслалцаа үзүүлсэн этгээдүүд;

(с) Хүний эрхийн гэрээ конвенциор соёрхсон дүрэм журмын дагуу захидал харилцаа явуулсан болон тэрчлэн тийм зорилгоор тэдэнд эрх зүйн болон бусад туслалцаа үзүүлсэн этгээдүүд;

(д) Хүний эрхийн зөрчлийн хохирогчид, хохирогчдод эрх зүйн болон бусад туслалцаа үзүүлсэн этгээдүүдийн ар гэр, хамаатан садан»<sup>37</sup> зэрэг болно.

Хүний эрхийн зөрчлийн талаар бүс нутгийн болон олон улсын хүний эрхийн байгууллагад хандсан хүний эрхийн хамгаалагчдыг дарамтлах, айлган сүрдүүлэх, гэмт хэрэгт холбогдуулан шалгах явдал нэмэгдсээр байна. Үүнд хүний эрхийн хамгаалагчдыг хүний эрхийн арга хэмжээ, хурал чуулганд оролцохоор гадаадад зорчиход саад тотгор учруулах зорилгоор гадагш зорчих эрхийг нь хязгаарлах, визийн хатуу чанд шаардлага тавих явдал мөн багтдаг.

Түүний зэрэгцээ иргэний нийгмийн байгууллагуудын хувьд олон улсын болон бүс нутгийн байгууллагад ажилагчийн статус олж авах явдал улам бэрхшээлтэй болсоор байна.<sup>38</sup>

Хүний эрхийн хамгаалагчдын оролцоог хориглосноороо Засгийн газрууд хүний эрхийн асуудалд олон улсын анхаарлыг хандуулах, гадаад дахь хүний эрхийн байгууллагатай харилцах явдалд саад учруулж, дуу хоолойг нь хорьж, мэдээллийг дарагдуулснаараа хүний эрхийн зөрчлийн эсрэг арга хэмжээ авахгүй, тэр ч байтугай мэдээлэхгүй өнгөрөөж байна. Хүний эрхийн хамгаалагчдын үнэтэй хувь нэмэргүйгээр олон улсын болон бүс нутгийн байгууллагууд бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадвараа ихээхэн хязгаарлуулж байна.

Венесуэл улсад 2015 оны 3-р сард НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн хуралд оролцоод ирснийх нь дараа хүний эрхийн олон хамгаалагчдыг мөрдөн мөшгиж, айлган сүрдүүлжээ. Венесуэлийн хүний эрхийн хамгаалагчдыг Америк хоорондын хүний эрхийн комиссын хуралд оролцоод ирснийх нь дараа тус улсын Үндэсний ассемблейн дарга телевизээр нэрсийг нь зарласны улмаас дарамт, дайралтад өртсөн байна.<sup>39</sup>

<sup>34</sup> Optional Protocol to the Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women (CEDAW), Art. 11; Optional Protocol to the Convention against Torture and other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment (OPCAT), Art. 15; Optional Protocol to the International Covenant on Economic, Social and Cultural Rights (CESC), Art. 13

<sup>35</sup> United Nations General Assembly, Annual Report of the United Nations High Commissioner for Human Rights and Reports of the Office of the High Commissioner and the Secretary General, UN Doc. A/HRC/RES/12/2 (2009)

<sup>36</sup> United Nations General Assembly, Cooperation with the United Nations, its representatives and mechanisms in the field of human rights, Resolution adopted by the Human Rights Council, UN Doc. A/HRC/RES/24/24 (2013)

<sup>37</sup> Office of the High Commissioner for Human Rights, Acts of intimidation and reprisals for cooperation with the special procedures, available at [www.ohchr.org/EN/HRBodies/SP/Pages/Actsofintimidationandreprisal.aspx](http://www.ohchr.org/EN/HRBodies/SP/Pages/Actsofintimidationandreprisal.aspx)

<sup>38</sup> For an example of a protracted and difficult process see these articles on the initial decision to deny the Committee to Protect Journalists (CPJ) Consultative Status at the UN Economic and Social Council (ECOSOC), and the reversal of that decision a few months later: CPJ, CPJ denied ECOSOC consultative status after vote in UN NGO Committee, May 2016, available at <https://cpj.org/2016/05/cpj-denied-ecosoc-consultative-status-after-vote-1.php>; CPJ, UN committee grants CPJ accreditation, July 2016, available at <https://cpj.org/2016/07/un-committee-grants-cpj-accreditation.php>

<sup>39</sup> Amnesty International, *Report 2015/2016: The State of the World's Human Rights* (Index: POL 10/2552/2016)

Зарим үед хүний эрхийн хамгаалагчид улс орондоо НҮБ, бус нутгийн байгууллагын төлөөлөгчдийн албан ёсны айлчлалын үеэр уулзсанаа төлөө дарамт шахалтад ордог. НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын асуудлаарх Тусгай илтгэгч 2017 оны эхээр Мексик улсад албан ёсоор айлчилсанаа дараа зөвхөн түүнтэй уулзсанаа төлөө олон хүний эрхийн хамгаалагч нийгмийн сүлжээгээр заналхийлэлд өртсөн талаар сэтгэл зовниж байгаагаа илэрхийлсэн.<sup>40</sup>

## ИРАНЫ ИРГЭН НАРЖЕС МОХАММАДИ



*Narges Mohammadi in Ireland in June 2007. She is now serving a 22-year prison sentence in Iran on charges connected with her human rights work, © Amnesty International*

Наржес Мохаммади бол Ираны эмэгтэй хүний эрхийн хамгаалагч юм. Тэрээр Ираны эрх баригчид үйл ажиллагааг нь зогсоохоос өмнө Хүний эрхийн хамгаалагчдын төвийн дэд ерөнхийлөгч байв.

Ираны шүүх түүнд хүний эрхийн цаазаар авах ялын эсрэг кампанит ажил явуулж, Европын холбооны Гадаад хэргийн асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгч Катерин Аштонтой уулзсаныг төлөө 22 жил хорих ял оноосон. Хамгийн сүүлд баригдсаны дараа нь 10 настай хоёр ихэр хүү нь аавтайгаа хамт амьдрахаар Иран улсыг орхин явахаас аргагүйд хүрчээ.

Олон жилийн турш Ираны эрх баригчид Наржес Мохаммадиг хүний эрхийн тайван үйл ажиллагаа явуулсных нь төлөө дарамталсаар ирсэн юм. 2009 оноос хойш гадаадад зорчихыг нь хориглосон учраас 2010 онд “Нобелийн шагналт эмэгтэйчүүдийн санаачилга” байгууллагын зохион байгуулсан олон улсын бага хуралд оролцохоор Гватемал улс руу, 2011 онд Хүний эрхийн үйлсийн төлөө Пер Ангерийн шагналыг хүлээн авахаар Швед улс руу очиж чадаагүй.

Наржес Мохаммадид оногдуулсан хатуу шийтгэл нь Ираны эрх баригчдын зүгээс хүний эрхийн хамгаалагчдыг дуугүй болгох гэсэн эрмэлзлийн илрэл мөн

НҮБ болон бусад хүний эрхийн байгууллагуудтай харилцахад нь саад тотгор учруулах, харилцсаныг нь төлөө шийтгэл оногдуулах явдал өсөн нэмэгдэж, ноцтой шинжтэй болсон учраас 2016 оны 10-р сард НҮБ-ын ЕНБД “НҮБ-тай харилцсаны улмаас айлган сүрдүүлэлт, дарамт шахалтад өртсөн хүний эрхийн хамгаалагчид, иргэний нийгмийн тоглогчдын асуудлыг хүлээн авч, судлан үзэх, хариу өгөх” бүрэн эрхийг Туслах ЕНБД-д олгосон.<sup>41</sup> Энэхүү санаачилга хувь хүмүүсийн олон улсын түвшинд оролцох эрхийг хамгаалахад хэр үр дүнд хүрэхийг харах үлдээд байна.

Түүнчлэн олон улсын гэрээний байгууллагууд дээрх асуудлаар хүний эрхийн хамгаалагчдын эсрэг дайралт, дарамт шахалтыг авч үзэх шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд уг асуудлыг тусгайлан хариуцсан илтгэгчдийг томилон ажиллуулж байна.<sup>42</sup>

<sup>40</sup> Office for the High Commissioner for Human Rights, End of mission statement by the United Nations Special Rapporteur on the situation of HRDs, Michel Forst, on his visit to Mexico from 16 to 24 January 2017, available at [www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=21111&LangID=E](http://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=21111&LangID=E)

<sup>41</sup> United Nations, the United Nations Secretary-General Press Conference, Geneva, 2016, available at [un.org.au/2016/10/04/the-united-nations-secretary-general-press-conference-geneva-3-october-2016/2/](http://un.org.au/2016/10/04/the-united-nations-secretary-general-press-conference-geneva-3-october-2016/2/)

<sup>42</sup> Including: United Nations, Guidelines against Intimidation or Reprisals (“San José Guidelines”), HRI/MC/2015/6 and the Treaty bodies that have adopted such proceedings: Committee Against Torture, Statement of the Committee against Torture, adopted at its fifty-first session (28 October–22 November 2013), UN Doc. CAT/C/51/3 (2013); Committee on Enforced Disappearances, UN Doc. CED/C/1 (2012); Committee on the Rights of Persons with Disabilities, Guidelines on the Participation of Disabled Persons Organizations (DPOs) and Civil Society Organizations in the work of the Committee, UN Doc. CRPD/C/11/2 (2014). For more information, see the website of International Service for Human Rights (ISHR): [www.ishr.ch/sites/default/files/article/files/isshr\\_reprisals\\_handbook\\_web.pdf](http://www.ishr.ch/sites/default/files/article/files/isshr_reprisals_handbook_web.pdf)

# 3. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЭСРЭГ ХАЛДЛАГА

## 3.1 МӨШГИН ХЯНАЛТ

**«...Энэ бол яг л харанхуй өрөөнд суугаад хажууд өөр хүмүүс амьсгалж, хөдөлж, ярихыг сонсох ч хэн гэдгийг нь хэлж мэдэхгүйтэй адилхан юм. Гэв гэнэт хэн нэгэн шүдэнз зурж, гэрэл асах тэрхэн зуур бусад хүмүүсийн царайг харна.»**

*Мароккогийн хүний эрхийн хамгаалагч Хишим Алмираат, 2016 оны 12-р сар.*

Олон нийтийг мөшгиж хүний эрхийн хамгаалагчдыг онилон онлайн, офлайн орчинд хянах явдал дэлхий даяар өссөөр байна. Энэхүү хурдан өсөлтөд өмнө мөрдөгдөж байсан, шинээр батлагдсан хууль тогтоомжоор олгогдсон өргөн эрх мэдэл, шинэ технологийн хөгжил, олдоц нөлөөлжээ. Хүний эрхийн хамгаалагчид, бусад хүмүүсийн хувьд техникийн бэрхшээлээс үүдэн хяналт явагдсан гэдгийг нотлоход төвөгтэй нь олонтаа. Тийнхүү онилж байгааг нотлох боломжгүй тохиолдолд ч байнга мөшгин хянахаар заналхийлэх нь хүний эрхийн зөрчил юм. Мөшгин хяналтын тухай хууль тогтоомж, практик нь гэр бүл, нийгэмд ихээхэн сөрөг үр дагавар авчирдаг бөгөөд хүний эрхийн хамгаалагчдыг айдас хүйдсээс үүдэн өөрсөддөө хязгаарлалт тогтоох, үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхээс татгалзахад хүргэдэг. Дээрээс нь эдгээр эрхээ хэрэгжүүлснээс үүдэн мөрдлөг хавчилгад өртөх аюул занал нэмэгдэж хүний эрхийн хамгаалагчид эрч хүч, нөөц бололцоогоо хууль шүүхийн байгууллагатай тэмцэхэд зарцуулахад хүрдэг.

Эрх мэдэлтнүүд хүний эрхийг уландаа гишгэх хор хөнөөлтэй үг яриаг улам бүр түгээх болсон дэлхий ертөнцөд хувийн нууцтай байх эрх, эвлэлдэн нэгдэх эрх юу юунаас илүү чухал билээ. Мөшгин хяналт бол хүмүүсийг эрхээ хэрэгжүүлэхэд саад тотгор учруулдаг нэгэн арга хэрэгсэл юм.

**Их Британи, АНУ** төдийгүй бүх улсад бол хүний эрхийн хамгаалагчид болон бусад хүмүүсийг тусгайлан онилж, мөшгин хянах явдал гарсаар байна. **Их Британи** улсад цагдаагийн байгууллага сэтгүүлчдийн эх сурвалжийг илрүүлэхийн тулд мөшгин хянаж байгаа бол гадаадад байгаа **Бахрейны** идэвхтнүүдийг тус улсын Засгийн газар тагнуулын хэрэгсэл ашиглан тагнаж, **Колумбын** үндэсний цагдаа радио сэтгүүлчдийг электрон мөшгин хяналтын золиос болгож байна. **Этиоп** улсын Засгийн газар гадаад, дотооддоо сөрөг хүчний идэвхтнүүдийн эсрэг электрон мөшгин хяналт ашигладаг.<sup>43</sup>

<sup>43</sup> Amnesty International, *Encryption: A Matter of Human Rights* (Index: POL 40/3682/2016)

Хэд хэдэн улс хувийн харилцаа холбоогоо мөшгин хяналтаас хамгаалах шифрийн нууцлалын арга хэрэгсэл болон үйлчилгээ авах, хэрэглэхээс сэргийлэх хууль тогтоомж баталжээ. **Пакистан, Энэтхэг** зэрэг улс шифрийн нууцлалыг хориглох буюу Засгийн газраас зөвшөөрсөн хууль ёсны шифрийн нууцлалын түвшинг хязгаарлах, эсхүл хувь хүмүүс шифрийн нууцлал хэрэглэхийн тулд зохих байгууллагын зөвшөөрөл авахыг шаарддаг.

**Турк** улс шифрийн нууцлалын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас хэрэгчлэгчдэд шифрийн нууцлалын хэрэгслийг санал болгохоосоо өмнө Засгийн газрын зохицуулагч байгууллагуудад нууцлалын түлхүүрээ өгөхийг шаарддаг бол **Их Британи, Франц** зэрэг улс компаниудад нууцлалын түлхүүрээ өгөх, өгөгдлийн шифрийн нууцлалыг тайлахыг тушаах эрхтэй юм. 2015 онд батлагдсан **Хятадын** Терроризмын эсрэг хуулиар харилцаа холбооны технологийн үйлчилгээ үзүүлэгчдээс “Засгийн газрын мөрдөн байцаагчдад терроризмээс урьдчилан сэргийлэх, мөрдөн байцаах ажиллагаанд техникийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, түүний дотор хууль сахиулах болон үндэсний аюулгүй байдлын эрх бүхий байгууллагад техникийн холболт, шифрийн нууцлал задлах түлхүүр хүлээлгэн өгөх” (18-р зүйл); “терроризм, экстермизмтэй холбоотой агуулга тараахаас сэргийлэх, устгах, Хятад улсын цагдаад нэн даруй мэдэгдэхэд зориулсан сүлжээний аюулгүй байдал, мэдээллийн агуулгад хяналт тавих систем, арга хэмжээг хэрэгжүүлэх” -ийг шаарддаг.<sup>44</sup>



## БЕЛАРУСЬ УЛС ДАХЬ МӨШГИН ХЯНАЛТ

Беларусийн иргэний нийгмийн идэвхтнүүд төрийн мөшгин хяналтаас айдаг. Эрх зүйн зохицуулалт, сул, мөшгин хяналтын эсрэг арга хэмжээ авах бололцоогүйн улмаас идэвхтнүүд, хүний эрхийн хамгаалагчдад хяналтад байгаагаа мэдэхээс өөр юу ч хийх сонголт үлддэггүй. 2010 оны сонгуулийн дараа сөрөг хүчний улс төрчид, бусад идэвхтнүүдийн эсрэг улс төрийн зорилготой мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хувийн харилцаа холбоо, байршил тогтоох өгөгдлүүд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн нь айдсыг улам нэмсэн юм.

Эмнести Интернэшнл 2015-2016 онд Беларусь улс иргэдээ удаан хугацаагаар, ямарваа нэг хяналтгүйгээр мөшгин хянах, ТББ-ын идэвхтнүүдийн үндсэн ажил, тухайлбал утсаар уулзах цаг товлох хүртэл эрсдэлтэй болсныг баримтжуулжээ. Беларусийн иргэний нийгмийн идэвхтнүүд өөрсдийг нь тайван үйл ажиллагаа явуулсных төлөө ямар нэг хэлбэрээр мөшгин хянадаг гэж үзэж байгаагаа илэрхийлсэн. Иргэний нийгмийн гишүүдийг эрхээ эдлэснийх нь төлөө хязгаарлалт тогтоосон хууль тогтоомжийн дагуу шийтгэж байгаа нь айдсыг нэмэгдүүлж байгаа юм.

Сөрөг хүчнээс Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшсэн Микалай Статкевичийг 2010 оны сонгуулийн үеэр болсон тайван жагсаал цуглаанд гүйцэтгэсэн үүргийнх нь төлөө шоронд хорьсон бөгөөд 2015 оны 8-р сард суллагдах хүртэл нь түүнийг Эмнести Интернэшнл үзэл санааны хоригдол хэмээн үзжээ. Тэрээр мөрдөн байцаалтын үеэр найз нөхөд, хамтран ажилладаг хүмүүсийн утасны яриа, Skype чаатны бичлэгийг мөрдөн байцаагчид өөрт нь үзүүлсэн тухай Эмнести Интернэшнлд ярьсан. Тэрээр тэрхүү бичлэгүүдийг хууль бусаар олж авсан хэмээн үзэж байна.

2011 онд Хүний эрхийн Виасна төвийн дарга Алес Биалиацкиг татвараас зугтсан хэргээр баривчлав. Тэрээр сонгуулийн дараах хэлмэгдүүлэлтэд өртсөн хохирогчдод туслалцаа үзүүлж байсан ч үүсгэсэн хэрэг улс төрийн сэдэлтэй болох нь харагдсан. Тэрээр Эмнести Интернэшнлд “Польшийн ТББ-ын түншүүдтэйгээ Skype-р ярьсан ярианы зарим хэсэг төрийн мэдлийн сонинд хэвлэгдсэн... Тэд нар намайг тус улсын дэглэмийг нураахын тулд санхүүжилт хайдаг мэтээр харуулахыг оролдсон. Гэтэл би үнэндээ улс төрийн хэлмэгдүүлэлтийн хохирогчдод туслалцаа үзүүлэх талаар ярилцаж байсан юм” хэмээн мэдэгдсэн билээ. Тэдгээр ярианы бичлэгийг баривчлагдсан даруйд нь нийтэлжээ.

<sup>44</sup> Amnesty International, *Encryption: A Matter of Human Rights* (Index: POL 40/3682/2016)

Беларусь улсад идэвхтнүүдийг өргөн хүрээтэй мөшгин хянадаг үр нөлөөг дутуу үнэлж болохгүй. Хэд хэдэн идэвхтнүүд Эмнести Интернэшнлд “Мөшгин хянадаг эсэх нь тодорхойгүй байгаа нь сэтгэл зүй, амьдралын хэв маягт хүртэл нөлөөлж байна.” Санхүүжилт буюу олон нийтийн үйл ажиллагаатай холбоотой эмзэг мэдээллийн шифрийн нууцлалыг хэрхэн хамгаалах нь тэдний гол ажил” гэж хэлжээ. Хэд хэдэн хүн нууц мөшгин хяналтын улмаас олж авсан хувийн мэдээллийг эрүүгийн хэрэгт холбогдуулахын тулд биш харин хувийн амьдралыг нь бусниулахын тулд хэрэглэж магадгүй гэж айж байгаагаа илэрхийлэв.

Беларусь улсын хууль бараг бүх шалтгаанаар өргөн хүрээтэй мөшгин хяналт явуулах эрхийг эрх баригчдад олгодог. Энэ байдал нь тайван жагсаалд оролцох гэх мэт хүний эрхээ хэрэгжүүлснийхээ төлөө эрүүгийн болон захиргааны шийтгэл хүлээх заналхийлэлд өртдөг иргэний нийгэмд асар их сөрөг үр дагавар авчирч байгаа юм.<sup>45</sup>

## 3.2 ИНТЕРНЭТИЙН ХЯНАЛТ

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг “Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 19-р зүйлээр хүлээн зөвшөөрдөг.<sup>46</sup> 2016 оны 6-р сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “Интернэт дэх хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэх тухай”<sup>47</sup> тогтоол баталсан бөгөөд хүмүүс онлайнаар болон офлайнаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх адилхан эрхтэйг нотлож, улс орнууд “олон улсын хүний эрхийн эрх зүйг зөрчин онлайнаар мэдээлэл олж авах, түгээх явдлыг санаатайгаар тасалдуулах арга хэмжээ авах”-ыг буруушаасан. 2011 онд хэвлэгдсэн НҮБ-ын Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах асуудлаарх Тусгай илтгэгчийн тайланд “олон улсын хүний эрхийн эрх зүйн хүрээ, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй холбоотой заалтууд интернэтэд нэгэн адил хамаарна ” хэмээн дурдсан.<sup>48</sup>

Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19-р зүйлийн 3-р заалтад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зарим талаар хязгаарлаж болох ч тэр нь хуульд заасан, мөн бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зэрэг зорилгыг хамгаалахад зохих ёсоор нийцэх ёстой. Интернэтээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд аливаа хязгаарлалт тавихдаа эдгээр шалгуурыг мөрдөх ёстой.<sup>49</sup>

Интернэтийн хяналтыг янз бүрийн хэлбэрээр тавьдаг. Зарим тохиолдолд улс орнууд эрүүгийн хуулийн тогтолцоо болон захиргааны шийтгэлийг онлайнаар үзэл бодлоо илэрхийлсэн хувь хүмүүсийг мөрдөн шалгахдаа ашигладаг. Тухайлбал: **Казакстан** улсад олон нийтийн жагсаалд оролцох сонирхлоо нийгмийн сүлжээнд илэрхийлснийх нь төлөө олон хүнийг баричлан хорьсон.<sup>50</sup> Түүнчлэн шинэ технологийн хөгжил нь хувь хүмүүсийн мэдээлэл, хайх, олж авах, түгээх чадварыг хязгаарлах зорилготой улс орнуудын чадавхийг нэмэгдүүлж байна.

*Mamfakinch* (Би бууж өгөхгүй) хэмээх **Мароккогийн** нэгэн хараат бус мэдээллийн вэб сайт нэг жишээ юм. 2011 онд уг сайт Арабын хаврын хүрээнд Мароккогийн төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргахыг зөвшөөрөөгүй өөрөөр сэтгэгчдийн дуу хоолойг хүргэхийг зорьж байв. 2012 онд *Mamfakinch* сайтыг Италийн Hacking Team компаний хийсэн “Алсын удирдлагын систем” хэмээх маш хүчтэй тагнуулын программ хангамж ашиглан халдаж, харилцаа холбоог нь бусниулахыг зорьсон юм. Энэ бол Европт үйлдвэрлэсэн технологийг ашиглан хүний эрхийн идэвхтнүүд, сэтгүүлчдийг онилж, нухчин дарах зорилгоор компьютерийн халдлага хийсэн анхны тохиолдол аж.

<sup>45</sup> Amnesty International, *Belarus: “It’s enough for people to feel it exists”: Civil society, secrecy and surveillance in Belarus* (Index: EUR 49/4306/2016)

<sup>46</sup> For more on states’ duties to uphold the right to freedom of expression under the ICCPR, see: Human Rights Committee General Comment 34

<sup>47</sup> Human Rights Council, *The promotion, protection and enjoyment of human rights on the Internet*, UN Doc. A/HRC/32/L20 (2016)

<sup>48</sup> UN General Assembly, *Report of the Special Rapporteur on the promotion and protection of the rights to freedom of opinion and of expression*, UN Doc. A/66/290 (2011)

<sup>49</sup> Restrictions must also be in line with the legitimate grounds for restriction specified in Article 19 of the ICCPR, that is: i. respect for the rights or reputation of others; or, ii. the protection of national security or of public order, or of public health or morals. See: UN General Assembly, *Report of the Special Rapporteur*, UN Doc. A/66/290 (2011), pp. 6-7

<sup>50</sup> Amnesty International, *Think before you post: Closing down social media space in Kazakhstan*, p. 13 (Index: EUR 57/5644/2017)

Мөн онд *Mamfakinch* сайт жагсагчдын эсрэг цагдаа хүч хэтрүүлэн хэрэглэсэн, засгийн газрын нэгэн сайдын авлига авсан, танил талаа дээш нь татсан хэргийг олонд илчилсэн. Халдлагаас хойш уг вэб сайтад байнга мэдээлэл өгдөг 30 хүн сайтаа хаалгачихгүйн төлөө ажилладаг 3 хүн болж буурсан. *Mamfakinch's* сайтын **Жишам Алмираат**, түүний хамтран зүтгэгчид хожим нь *Association des Droits Numériques* (ADN) хэмээх цахим эрх чөлөөний байгууллагыг байгуулж, 2015 онд Их Британид байрладаг Privacy International байгууллагатай хамтран Мароккогийн эрдэмтэд, сэтгүүлчид, хүний эрхийн идэвхтнүүдийг хууль бусаар мөшгин хянаж байгаа талаар тайлан гаргасан байна. Түүнээс 3 хоногийн дараа Засгийн газар түүний болон ADN-ийн дэд ерөнхийлөгчийн эсрэг “Засгийн газрыг аймшиггүйгээр гүтгэсэн”, “худал тайлан бэлтгэсэн”, төрийн албан хаагчдыг доромжилсон” зэрэг үндэслэлээр 5 жил хүртэл хоригдох ялтай эрүүгийн хэрэг үүсгэсэн<sup>51</sup> нь өнөөдрийг хүртэл хаагдаагүй байна.

**Тайланд** улс маш бүрхэг заалттай “Компьютерийн гэмт хэргийн тухай хууль”-ийг өөрөөр сэтгэгчдийн материал нийтэлсэн, түүний дотор хүний эрхийн зөрчлийн талаар онлайнаар мэдээлсэн гэсэн үндэслэлээр хувь хүмүүсийг шийтгэх, эрүүгийн хэрэг үүсгэхэд ашигладаг. Хуулийн оюутан, хүний эрхийн хамгаалагч **Жатупат Бүүнпаттараракса** энэ тайланг бичиж байх үед Компьютерийн гэмт хэргийн тухай хууль, Эрүүгийн хуулийн 112-р зүйлийн дагуу (Эзэн хааныг гутаан доромжлохын эсрэг) 2016 оны 12-р сард ВВС-гийн мэдээг фэйсбүүкээр тараасан хэргээр хоригдоод байв. Эрх баригчид 2016 оны 12-р сарын 22-нд түүнийг постоо устгаагүй, фэйсбүүкт төрийн эрх мэдэлтнүүдийг егөөдсөн утгатай бусад материал тавьсаар байсан гэдэг шалтгаанаар батлан даалтыг нь цуцалсан.<sup>52</sup>

Зарим улс хүний эрхийн хамгаалагчдын цуглуулж, тараадаг мэдээллийг ноцтой, улс төрийн аюултай гэж үзсэн тохиолдолд хааж байгаа нь хүний эрхийн үүргээ үл тоомсорлосон хэрэг юм. Онлайн мэдээллийг чөлөөтэй солилцох явдлыг хязгаарласан хууль тогтоомж дэлгэрсэн нь иргэний нийгмийн харилцаа холбоо барих чадварыг хязгаарлаж байна.

Тухайлбал интернэт, нийгмийн сүлжээг үе үе хязгаарлах явдал **Баруун, Төв Африкт** үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг нухчин дарах зорилгоор улам ихэсчээ. 2016 онд **Габон, Гамби, Конго** зэрэг улсын Ерөнхийлөгчийн сонгуулиас 2-5 хоногийн өмнө, хойно интернэтэд нэвтрэх боломжийг бүрмөсөн хаасан. Мөн 2016 оны 4-р сард Ерөнхийлөгчийн сонгууль явагдсан Гамби, **Чад** улсын аль алинд фэйсбүүк, WhatsApp, твиттер зэрэг сайтууд жилийн турш зөвхөн VPN-ээр нэвтрэх боломжтой байсан бол Чад улсад олон тооны блог, мэдээллийн сайт 2017 он хүртэл хаалттай хэвээр байв. Өнөөдрийн байдлаар хамгийн ноцтой хязгаарлалт нь **Камерун** улсын англи хэлээр ярьдаг нутагт шүүх, сургуульд франц хэл ашиглах, бие даасан байдлыг нэмэгдүүлэхийг шаардсан жагсаал цуглааны дараа 2017 оны 1-р сард интернэтийг бүрмөсөн тасалсан явдал юм.



## ЭТИОП УЛС ДАХЬ ИНТЕРНЭТИЙН ХЯНАЛТ

Этиоп улсын эрх баригчид онлайн харилцаа холбоонд хатуу хяналт тавьдаг төдийгүй цахим харилцаа холбоог хааж, цахим үйл ажиллагаанд хэрэг үүсгэдэг хууль тогтоомжийг ашигладаг нь тайван жагсаал цуглаан хийх боломжийг хязгаарладаг.<sup>53</sup>

Этиоп улсын хүний эрх идэвхтнүүд Эмнести Интернэшнлд 2016 оны 3-р сард тус улсын хэмжээнд болон ялангуяа нийслэл Аддис Абаба хотоос Орамиа мужид засаг захиргааны хяналт тогтоох төлөвлөгөөг эсэргүүцсэн, дур зоргоор баривчлах, үндэстний цөөнхийг ялгаварлан гадуурхах явдлыг буруушаасан жагсаал цуглаан өрнөсний дараа фэйсбүүк, WhatsApp, твиттер зэрэг нийгмийн сүлжээг хаасан талаар мэдээлжээ. Түүнчлэн 2016 оны 8-р сард улс төрийн идэвхтнүүд бүс нутаг даяар жагсаал цуглаан өрнүүлэх уриалга гаргасны дараа Амхара, Аддис Абаба хот, Орамиа мужид интернэтийн үйлчилгээг тэр чигээр нь хаасан байна. Засгийн газрын аюулгүйн хүчнийхэн жагсагчдын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэсний улмаас дор хаяж 100 хүн алагджээ.

<sup>51</sup> Amnesty International, How a hacking campaign helped shut down an award-winning news site, 2016, available at [www.amnesty.org/en/latest/research/2016/12/how-a-hacking-campaign-helped-shut-down-an-award-winning-news-site/](http://www.amnesty.org/en/latest/research/2016/12/how-a-hacking-campaign-helped-shut-down-an-award-winning-news-site/)

<sup>52</sup> Amnesty International, *Thailand: Activist's Bail revoked for Commenting on Facebook* (Index: ASA 39/5412/2016)

<sup>53</sup> Amnesty International, *Ethiopia: Government blocking of websites during protests widespread, systematic and illegal* (Index: AFR 25/5312/2016)

Улс төрийн болон бусад идэвхтнүүд нийгмийн сүлжээн дэх үйл ажиллагаа, Засгийн газрын бодлогыг шүүмжилсний хариуд 2009 оны Терроризмын эсрэг тунхаглалын дагуу баривчилж, ял тулгасны фэйсбүүкийн талаарх Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг шүүмжилснийхээ төлөө 2015 оны 12-р сард үндэслэлгүйгээр баривчлагдаж, 5 сарын дараа терроризмтэй холбоотой хэргээр ял сонссон Хөх намын гишүүн асан **Ёнатан Тесфае**<sup>54</sup>; харилцаа холбооны аюулгүй байдлаа хангахын тулд шифрийн нууцлалтай программ хангамж ашигласныхаа төлөө терроризмын хэрэгт холбогдон 2014-2015 оны хооронд 500 өдөр хоригдсон **Zone 9 сайтын бологчид**<sup>55</sup>; цахим шифрийн нууцлалын аргын талаар сургалт явуулсан хэргээр 2016 оны 5-р сард 5 жил хоригдох ял сонссон **Зелалем Воркалемаху**<sup>56</sup> нар багтжээ.

2016 оны 6-р сард батлагдсан Компьютерийн гэмт хэргийн тухай хуулиар Хууль зүйн яаманд цахим хэрэгт сэжиглэгдсэн хүмүүсийг тагнах чагнах, мөшгин хянах, 4 сар хүртэл хугацаагаар хэрэг үүсгэлгүйгээр хорих эрх олгосон.

Эрх баригчдын хөндлөнгийн оролцоо, интернэтийг хааж байгаа үйлдэл нь хүний эрхийн хамгаалагчдыг тайван замаар эсэргүүцэх, үзэл бодлоо илэрхийлэхэд саад учруулж байгаагийн зэрэгцээ эсэргүүцлийг хүчээр нухчин дарах боломжийг эрх баригчдад олгодог.

---

54 Amnesty International, Ethiopia: Release opposition politician held for Facebook posts (Press release, 6 May 2016)

55 Amnesty International, *Report 2015/2016: The State of the World's Human Rights* (Index: POL 10/2552/2016)

56 Amnesty International and OONI, *Ethiopia offline: Evidence of social media blocking and internet censorship in Ethiopia* (Index: AFR 25/5312/2016)

# 4. ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХУМИГДАЖ БҮЙ ОРОН ЗАЙ

## 4.1 ТАЙВАН ЗАМААР ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХЭД ХАЛДАХ

**«...[2015] он эсэргүүцлийн хөдөлгөөн дэлхий даяар үргэлжилсэн жил боллоо. Цөөнгүй оронд идэвхтнүүд дотооддоо болон гадаадад олон нийтийн бүхимдлыг амжилттай зохион байгуулалтад оруулж, сая хүмүүсийг жагсаал цуглаанд татан оролцуулж, анхаарлыг татаж чадлаа.**

*Тайван замаар жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн 2015 оны тайлан<sup>57</sup>*

Тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх бол хүний эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэх чухал урьдач нөхцөл юм. Улс орнууд энэ эрхийг хүндэтгэх, ялгаварлахгүйгээр хэрэгжүүлэхийг шаардсан олон улсын бүс нутгийн арга хэрэгслийн<sup>58</sup> хүрээнд хамгаалдаг. Тайван замаар эвлэлдэн нэгдэхэд тавьсан аливаа хязгаарлалтыг хуулиар тогтоож энэ нь хууль ёсны зорилготой, түүнтэйгээ дүйх шаардлагатай.

Хүний эрхийн хамгаалагчдын хувьд олон нийтийн эвлэлдэн нэгдэх, нийгмийн өөрчлөлтөд нөлөөлөх арга хэрэгсэл удаан хугацааны турш байсаар ирсэн бөгөөд цахим хэлбэрээр нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нь нэмэгдэж байгаа ч тайван замаар жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь эрх баригчдад дургүйцсэн, сэтгэл ханамжгүй байдлаа илэрхийлэх арга хэвээр. “Арабын хавар” бол урьд өмнө байгаагүй иргэд-төрийн хоорондын харилцааны хамгийн идэвхтэй жишээний нэг юм. Энэ нь гудамжинд жирийн иргэд өнөөгийн байдлыг хүлээн зөвшөөрөхгүйгээ хэлж, өөрчлөлт авчирч болдгийг дэлхий нийтэд харууллаа.

<sup>57</sup> The Special Rapporteur on the rights to freedom of peaceful assembly and of association, *2015: The Year in Assembly and Association Rights*, 2016, available at <http://freeassembly.net/reports/2015-year-in-review/>

<sup>58</sup> The Universal Declaration of Human Rights (Art. 20(1)); The International Covenant on Civil and Political Rights (Art. 21); The International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination (Art. 5 (d) (ix)); The Convention on the Rights of the Child (Art. 15); The European Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms (Art. 11); The African Charter on Human and Peoples' Rights (Art. 11); The African Charter on the Rights and Welfare of the Child (Art. 8); The Arab Charter on Human Rights (Art. 28); The American Convention on Human Rights (Art. 15); The HRDs Declaration (Art. 5 and 12)



Олон улс “Арабын хавар”-ыг хэрцгий аргаар нухчин дарсан байдаг. Бослого хөдөлгөөн тааварлах боломжгүй, ихэндээ албан бусаар хурдан өрнөдөг, асуудлыг дэлхийн олон нийтийн анхааралд хурдан оруулах боломжтой учраас Засгийн газрууд улс төр, эдийн засгийн эрх мэдэлд аюул учруулна хэмээн үздэг. Үр дүнд нь эвлэлдэн нэгдэхийн эсрэг аюулгүй байдал, цагдаагийн хүчийг хэтрүүлэн хэрэглэх, хянаж шалгах, дур зоргоор баривчлан хорих, эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр зүй бусаар харьцах, цаазаар авах ял ногдуулах, тайван замаар жагсаал, цуглаан зохион байгуулах иргэдийн боломжийг хязгаарласан үзлэг шалгалтын дүрэм журам батлах явдал нэмэгдэж байна.<sup>59</sup>

Нийтийн болон үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх асуудал үүсээгүй тохиолдолд ч тайван замаар эвлэлдэн нэгдэх, хурал цуглаан, ажил хаялт, жагсаал, суултыг хууль бусаар тараах явдал олширлоо. Олон оронд эрх баригчид арилжааны үйл ажиллагаа, замын хөдөлгөөнд саад учруулсан гэдэг шалтгаанаар тайван замаар жагсаал цуглаан хийгчдийг тарааж, интернэт, мэдээллийн сайтуудыг хаах буюу хандахад саад хийх болов.

Нийтлэг ашиг сонирхол, улс төрийн санал бодлоо хамтаар илэрхийлэх, түүнийг дэмжих хувь хүмүүсийн чадавхийг хязгаарлах хууль тогтоомжийг улс орнууд батлаж байна. Тухайлбал, **Өмнөд Солонгост** Үндсэн хуулиар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг баталгаажуулсан ч эвлэлдэн нэгдэхийг зохицуулдаг дотоодын хууль тогтоомж, практик үйл ажиллагаа нь чирэгдэлтэй хурдан хугацаанд эвлэлдэн нэгдэхэд хүндрэл учруулах, тодорхой цуглааныг бүхэлд нь хориглох боломж эрх баригчдад олгож байна.<sup>60</sup>

**Казахстанд** 2016 оны 5-р сард 10-аас 15 хоногийн хугацаанд наад зах нь 32 хүнийг захиргааны журмаар баривчилсны ихэнх нь жагсаал цуглаанд оролцохоо нийгмийн сүлжээгээр илэрхийлсэн хүмүүс байв. 2017 оны 1-р сард Казахстаны баруун хэсгийн бүсийн шүүх хүний эрхийн 2 хамгаалагчид 5 жил хорих ял ногдуулсныг баталгаажуулжээ. Нийгмийн сүлжээ ашиглан, “хууль бус” жагсаал цуглаан зохион байгуулах талаар нийтэлж, оролцохыг уриалж, төр засгийн үйл ажиллагааг шүүмжилсэн гэх ялыг тэдэнд тулгажээ. Гэрээс нь 1500 километрийн зайд Казахстаны умард хэсэгт байрлах эрүүгийн хэрэгтнийг хорих ангид ял эдлүүлэхээр шийтгэсэн явдал “хууль бус” жагсаал цуглаанд оролцож, зохион байгуулахгүй байхыг бусдад анхааруулсан хэрэг болов.<sup>61</sup>



## АНУ-ЫН “STANDING ROCK” УС ХАМГААЛАГЧИД

Армийн инженерийн корпусын гадаа Dakota Access хоолойг барихыг эсэргүүцэн жагсаж буй идэвхтнүүд, 2017 оны 3 дугаар сарын 10

“Standing Rock” ус хамгаалагчдын хөдөлгөөн нь уугуул иргэд болон тэдний холбоотнууд Standing Rock Sioux хамгаалалтын газар, ойр орчмын цэвэр усны гол эх үүсвэр Миссури голын урсацын доогуур Dakota Access газрын тосны хоолой тавихыг эсэргүүцсэнээр 2016 оны 4-р сард үүссэн байна. Уг хоолойг барьснаар ариун нандин булш бунхны газрыг устгаж, цэвэр усны эх үүсвэрийг сүйрэлд хүргэх эрсдэл учруулж байгаа юм.

“Standing Rock” хөдөлгөөний гишүүд тус хөдөлгөөн нь хүчирхийллийн бус, бүх хүний эрхийг хүндэтгэсэн гэдгийг олон нийтэд хандан удаа дараа мэдэгдэж байсан АНУ-ын хүчний байгууллагынхан шаардлагагүй үед хүч хэтрүүлэн хэрэглэжээ.

<sup>59</sup> Amnesty International, *The Arab Spring: Five years on*, 2016, available at [www.amnesty.org/en/latest/campaigns/2016/01/arab-spring-five-years-on/](http://www.amnesty.org/en/latest/campaigns/2016/01/arab-spring-five-years-on/)

<sup>60</sup> Amnesty International, *Freedom of peaceful assembly in South Korea and international human rights standards* (Index: ASA 25/5099/2016)

<sup>61</sup> Amnesty International, *Kazakhstan: Prisoners of conscience conviction upheld: Maks Bokaev and Talgat Ayan* (Index: EUR 57/5599/2017)

Тухайлбал, 2016 оны 10-р сарын 26-ны өдөр наад зах нь 140 хүнийг баривчлан, хувцсыг нь тайлж нэгжлэг хийхээсээ өмнө эрх баригчид химийн өдөөгч бодисыг хэнд ч хамаагүй, урьдчилан анхааруулалгүй хэрэглэсэн, 11-р сард хэт цэрэгжсэн хүчний байгууллагынхан хасах температурт тайван жагсааж байсан хүмүүсийг хэдэн цагийн турш усаар шүршсэн нь гэмтэж бэртэх ноцтой эрсдэлд оруулжээ.

Эмнести Интернэшнл нөхцөл байдлыг баримтжуулах, тайван жагсаал хөдөлгөөн өрнүүлэх эрхийг дэмжих олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг эрх баригчдад уриалах зорилгоор Standing Rock руу ажиглагчдаа 4 удаа илгээсэн юм.

Тус байгууллага Standing Rock-ийн цуглааны эсрэг цагдаагийн хүч хэрэглэснийг шалгах мөрдлөг явуулахыг уриалсан ч үл тоомсорлов.

2017 онд Ерөнхийлөгч Дональд Трамп Dakota Access-ийн хоолойн ажлыг хурдан хугацаанд дуусгах үүргийг холбогдох бүх агентлагт өгсөн меморандум гаргав. Эмнести Интернэшнл уг хоолойг барих ажлаа зогсоож, байгаль орчны нөлөөлөл, отог омгийн эрхийг зөрчих эсэхэд бүрэн үнэлгээ хийх, цаашид ийм төсөл хэрэгжүүлэхдээ юуны өмнө уугуул иргэдээс чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авсны үндсэн дээр зөвшөөрөл авч байхыг АНУ-ын Засгийн газарт уриалж байна.

## 4.2. ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХЭД СААД УЧРУУЛАХ

Эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөө нь хамтран үйл ажиллагаа явуулах зорилгоор албан, албан бүс бүлгийг үүсгэх, нэгдэх боломжийг хувь хүмүүст олгох хүний эрхийн хамгаалагчдын ажлын чухал хэсэг юм. Эвлэлдэн нэгдэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж олгох, хязгаарлах зорилготой нөхцөл тавихгүй байхыг улс орнуудад үүрэгдсэн олон улсын болон бүс нутгийн арга хэмжээний<sup>62</sup> дагуу энэ эрхийг хамгаалдаг.

Улс орнууд нийгэмлэг холбоо байгуулах эрх зүйн хүрээг тодорхойлох, эрхээ эдлэхэд нь хэт хязгаарлалт тавихгүй байх, гуравдагч этгээд хөндлөнгөөс оролцохоос хамгаалах, нийгэмлэг холбоодын үйл ажиллагаа явуулах аюулгүй, боломжит орчныг бүрдүүлэх үүрэг хүлээхийн зэрэгцээ тэдний болон гишүүдийнх нь нууцыг хүндэтгэнэ. Эвлэлдэн нэгдэх эрхэд бүлгүүдийн санхүүжилт авах, хөрөнгөтэй байх эрх мөн хамаарна.

### 4.2.1. ГАДААДЫН САНХҮҮЖИЛТЭД ТАВЬСАН ХЯЗГААРЛАЛТ

Хүний эрхийг дэмжих, хамгаалах зорилгоор “бусдаас санхүүгийн тусламж хүсэх, хүлээн авах, хэрэглэх” эрхийг Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглал<sup>63</sup>-ын 13-р зүйлд заасан байдаг. Тайван замаар эвлэлдэн нэгдэх, эвсэл холбоонд элсэх эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн мэдэгдсэнчлэн

**«Санхүүгийн тусламж эрэх, баталгаажуулах, хэрэглэх чадамжтай байх явдал оршин тогтнох, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад нь ямар ч жижиг эвсэл холбоонд нэн чухал юм. Эвлэлдэн нэгдэх эрх нь зөвхөн хувь хүмүүс эвсэл хуулийн этгээдүүдийн эвсэл холбоо байгуулах, нэгдэх чадавх агуулах төдийгүй дотоод, гадаад, олон улсын эх сурвалжаас санхүүгийн тусламж эрэх, хүлээн авах, хэрэглэх эрхийг багтаадаг.»<sup>63</sup>**

Гэвч олон бүс нутагт иргэний нийгмийн байгууллагуудад, олон улсын эх сурвалжаас санхүүжилт авахыг хязгаарласан хууль тогтоомж олноор баталж, хэрэгжүүлснээр зөрчил ихсэв. Иргэний нийгмийн үйл ажиллагаа, санхүүжилт авах бололцоог хязгаарласан хуулийг 90 гаруй орон батлаад байна.<sup>64</sup>

<sup>62</sup> The Universal Declaration of Human Rights (Art. 17); The International Covenant on Civil and Political Rights (Art. 22); The International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination (Art. 5 (d) (ix)); The Convention on the Rights of the Child (Art. 15); The European Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms (Art. 11); The African Charter on Human and Peoples' Rights (Art. 10); The Arab Charter on Human Rights (Art. 28); The American Convention on Human Rights (Art. 16); The HRDs Declaration (Art. 5 and 13)

<sup>63</sup> United Nations General Assembly, Report of the Special Rapporteur on the rights to freedom of peaceful assembly and of association, Maina Kiai, UN Doc. A/HRC/23/39 (2013)

<sup>64</sup> CIVICUS, quoted in UN Special Rapporteur on HRDs, 2016, Report of the Special Rapporteur on the situation of human rights defenders, UN Doc. A/HRC/31/55 (2016), para. 28

**Бахрейн, Беларусь** зэрэг зарим оронд бүрэн хориглосон.<sup>65</sup> Тухайлбал **Алжир** зэрэг олон оронд<sup>66</sup> урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гадаадаас санхүүжихийг хориглож санхүүжилтыг тусгайлан заасан санхүүгийн байгууллагаар дамжуулах, эсхүл төрөөс тусгай зөвшөөрөл авахыг шаардах болов. “Гадаадын” гэгдэх байгууллагууд ийм арга хэмжээнд өртөж байна.<sup>67</sup>

2016 оны 6-р сард Хуульчдын нийгэмлэг хэмээх **Энэтхэгийн** нэр хүндтэй хүний эрхийн байгууллагын гадаадаас санхүүжилт авах зөвшөөрлийг 180 хоногийн хугацаатай түгэлзүүлсэн явдал тодорхой байгууллагуудыг сонгож онилох болсныг харуулж байна. Дотоод хэргийн яамнаас тус ТББ-ыг Гадаадын хандивын тухай (журам) хуулийн хэд хэдэн заалтыг илэрхий зөрчсөн хэмээн мэдэгджээ. Уг нийгэмлэг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, лесби, гей, бисексуал, транжендэр, интерсекс хүмүүсийн эрх, эрүүл мэндийн эрхийн төлөөх ажлуудыг бусдаас түрүүнд хийж байснаараа олонд танигдсан юм.<sup>68</sup>

2016 оны 7-р сард **Израйлийн** парламент Ил тод байдлын тухай хуулийг баталж, гадаадын Засгийн газруудаас санхүүжилтынхаа 50-аас дээш хувийг авдаг байгууллагуудад мэдээлэх шаардлагыг шинээр тавих болсон.

Бараг бүгд Израйлийн Засгийн газрын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй ханддаг хүний эрхийн бүлгүүд буюу бусад чиглэлийн ТББ-ууд байсан юм.<sup>69</sup>

**Египетэд** хүний эрхийн байгууллагуудын гадаадаас авсан санхүүжилт, үйл ажиллагаанд нь эрүүгийн хэрэг үүсгэн шалгасны улмаас 17 хүнийг хилээр гарахыг хориглож, 7 байгууллагын хөрөнгийг царцаасан. Ингэснээр үйл ажиллагаа явуулах боломжийг нь хязгаарласан бол 2016 оны 11-р сард баталсан шинэ хууль хэрэгжвэл ТББ-уудын үйл ажиллагаа, хууль ёсны бүртгэлд бүртгүүлэх, гадаадаас санхүүжилт авах эрх нэлээд хязгаарлагдах юм. Учир нь эдгээр заалтыг зөрчсөн тохиолдолд их хэмжээний торгууль ногдуулах заалт оржээ. Энэ хуулинд Ерөнхийлөгч гарын үсэг зураагүй байгаа тул хараахан хүчин төгөлдөр болоогүй юм.<sup>70</sup>

Хүний эрхийн хамгаалагч, иргэний нийгмийн байгууллагууд үйл ажиллагаагаа зогсоох юм уу эсхүл хязгаарлахаас өөр аргагүйд хүргэх бүртгэл, санхүүгийн чирэгдэлтэй журам бий батлах, татварын нарийвчилсан тайлан гаргахыг шаардах зэрэг захиргааны аргыг зарим улсад ашигладаг.

**Их Британид** “тогтворгүй” гэгдэх улсуудад үйл ажиллагаа явуулдаг исламын шашны байгууллагууд, бусад хандивлагчид санхүүжилтээ шилжүүлэх, зарцуулах нь маш хүндрэлтэй. Түүнчлэн хэлсэн үг нь буруугаар ойлгогдох, улс төрийн намын хориглосон үйл ажиллагаанд оролцсон гэх нотолгоо болохоос эмээсэн олон буяны байгууллага ярихаас цааргалах болсон зэрэг нь Ил тод байдал, лоббигийн тухай хууль, Намын бус кампанит ажил, Үйлдвэрчний эвлэлийн хууль сөргөөр нөлөөлснийг харуулж байна.<sup>71</sup>

Иргэний нийгмийн байгууллагууд гадаадаас санхүүжилт авахыг хуулиар хүлээн зөвшөөрсөн ч “гадаадын агент” гэж нэрлэн, гутаан доромжлох болсноор тэдэнд учрах эрсдэл ихээхэн нэмэгдэв.



## ОХУ-ЫН “ГАДААДЫН АГЕНТ”-ЫН ТУХАЙ ХУУЛЬ

2012 оны 7-р сард ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин гадаадын санхүүжилт авсан буюу “улс төрийн үйл ажиллагаа” гэж бүрхэгдүүлэн тодорхойлсон үйл ажиллагаанд оролцсон ТББ-уудыг “гадаадын агент” хэмээн үзэх хуулийг батлаж, Хууль зүйн яамнаас гаргадаг “гадаадын агентууд”-ын бүртгэлийн жагсаалтад оруулахаар заажээ.

<sup>65</sup> See World Organisation Against Torture (OMCT), *Violations of the Right of NGOs to Funding: From Harassment to Criminalization: Annual Report 2013*, available at [www.omct.org/files/2013/02/22162/obs\\_annual\\_report\\_2013\\_uk\\_web.pdf](http://www.omct.org/files/2013/02/22162/obs_annual_report_2013_uk_web.pdf), p. 42

<sup>66</sup> For example, Bangladesh, Egypt, India. See World Organisation Against Torture (OMCT), *Violations of the right of NGOs to funding: From harassment to criminalization: Annual Report 2013*, available at [www.omct.org/files/2013/02/22162/obs\\_annual\\_report\\_2013\\_uk\\_web.pdf](http://www.omct.org/files/2013/02/22162/obs_annual_report_2013_uk_web.pdf), p. 42

<sup>67</sup> Amnesty International, Algeria, New law on associations used to stifle civil society (Press release, 7 May 2013)

<sup>68</sup> Amnesty International, India: Suspension of human rights NGO's foreign funding license must be revoked (News story, 3 June 2016)

<sup>69</sup> Amnesty International, *Report 2016/2017: The State of the World's Human Rights* (Index: POL 10/4800/2017)

<sup>70</sup> Amnesty International, Egypt: *Signing new NGO Bill would be a “death warrant” for Egyptian Rights Groups* (Index: MDE 12/5171/2016)

<sup>71</sup> Special Rapporteur on the rights to freedom of peaceful assembly and of association, April 2016, available at <http://freeassembly.net/news/statement-united-kingdom-follow-up/>

2016 оны 6-р сард Ерөнхийлөгч В.Путин “улс төрийн үйл ажиллагаа”-ны тодорхойлолтыг нэмэлтээр оруулсан хуулийг батлав. “Арилжааны бус байгууллагуудын тухай” хуулийн нэмэлт хэсэг нийгмийн амьдралын маш өргөн хүрээг хамарч, түүнд оролцох бараг бүх хэлбэрийг багтаасан байна.

Нэмэлт хэсэгт шинжлэх ухаан, соёл, урлаг, эрүүл мэндийн халамж, нийгмийн дэмжлэг, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг багтаагүй ч эдгээр салбарт идэвхтэй ажилладаг байгууллагуудыг “гадаадын агент” хэмээн бүртгэхийг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов. Гадаадаас санхүүжилт авдаг бол үйл ажиллагааны шинж чанараас нь үл хамааран бараг бүх ТББ-ыг “гадаад агент”-ын бүртгэлд оруулж болзошгүй ажээ.

Жагсаалтад орсон байгууллагууд гадаадаас санхүүжилтээ үргэлжлүүлэн авч, “гадаадын агент” гэж нэрлэгдэх эсхүл гадаадын санхүүжилтээс татгалзан, Ерөнхийлөгчийн буюу орон нутгийн дэмжлэг авах зэргээр зөвхөн ОХУ-ын дотоодын санхүүгийн эх үүсвэрт найдах хүнд сонголттой тулгардаг. Энэ нь гаднаас санхүүжилт авч болох ч зохих төлөөс төлөх ёстой гэдгийг Оросын эрх баригчид ТББ-уудад анхааруулсан сануулга юм. 2016 оны 11-р сарын байдлаар “гадаадын агент”-ын бүртгэлд орсны улмаас наад зах нь 27 байгууллага үйл ажиллагаагаа зогсоожээ.<sup>72</sup> Энэхүү хууль нь ТББ-уудын үйл ажиллагааны хүрээг хязгаарлах, үл итгэх, сэжиглэх, үл тэвчих уур амьсгал бүрэлдүүлэхэд нөлөөлж байна.

## 4.2.2. БҮРТГЭЛИЙН ХЯЗГААРЛАЛ

“Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглал”-д хүний эрхийг дэмжих, хамгаалахад ТББ, холбоо, бүлэг байгуулах, нэгдэх, оролцох хувь хүмүүсийн эрхийг тодорхойлсон.<sup>73</sup> Энэ бол эвлэлдэн нэгдэх эрхийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Байгууллагуудыг бүртгэхийг хориглох эсвэл цуцлах явдал хувь хүмүүсийг өөр хоорондоо эвлэлдэн нэгдэхэд саад учруулах харьцангуй хялбар арга юм. **Арабын Нэгдсэн Эмират** улсад иргэний нийгмийн байгууллагуудыг бүртгэх журмыг чангатгасан нь “түвэг учруулагч” гэж үзсэн байгууллагуудтай харьцах нэг арга болов.

**Бахрейн**д ТББ-ууд төрийн оролцооноос ангид үйл ажиллагаа явуулах боломжгүй бөгөөд дотоод асуудал, үйл ажиллагаанд нь шууд оролцох боломжийг эрх баригчдад олгосон, хэт хязгаарласан хууль үйлчилдэгээс олон ТББ бүртгэлгүй ажиллаж байна. Тус улсын хүний эрхийн голлох ТББ болох Бахрейны Хүний эрхийн төвийн үйл ажиллагааг 2004 онд хориглосон.

**Ангол** улс бүртгүүлэх хүсэлт тавьсан байгууллагуудаас санхүүгийн тайлан өгөхийг шаардах зэргээр чирэгдэлтэй хязгаарлалт бүхий хуулийг 2015 онд баталсан.<sup>74</sup> 2015 онд **Хятадын** Үндэсний Ардын Их хурал гадаадын ТББ-ууд, тэдгээрийн дотоодын түнш байгууллагуудыг зохицуулах хууль баталж, Нийгмийг аюулаас хамгаалах яам ТББ-ын бүртгэл, үйл ажиллагааг хянах үүрэгтэй болов. Ингэснээр эрх баригчид хүний эрхийн хамгаалагчид, ТББ-ын ажилчдыг сүрдүүлэх, мөрдөн шалгахад тус яамыг ашиглах вий гэх айдас нэмэгдэв.

**Өмнөд Суданы** 2016 оны ТББ-ын тухай хуулийн төслөөр бүртгүүлэх буюу бүртгэлээ шинэчлэх тохиолдолд ТББ-ууд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан, аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, хөрөнгийн жагсаалт, дараа жилийн санхүүгийн төлөвлөгөө, төсөв, дотоодын болон олон улсын ажилтнууд, албан тушаалын жагсаалтыг гаргаж өгөх шаардлагатай болов.<sup>75</sup>

2016 онд баталсан **Уганда** улсын ТББ-ын тухай хуулинд тус улсын хууль тогтоомжтой зорилго нь “зөрчилдсөн” гэх байгууллагуудыг бүртгэхээс татгалзаж болно гэж заажээ. Энэхүү заалт нь лесби, гей, бисексуал, транжендэр, интерсекс хүмүүс, бие үнэлэгч, мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүсийн эрх, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал, аюулгүй үр хөндөлт хийлгэх эрхийн төлөө ажилладаг байгууллагуудад тусгайлан чиглэсэн байх магадлал өндөртэй.<sup>76</sup>

<sup>72</sup> Amnesty International, *Russia: Agents of the people: Four years of “Foreign Agents” law in Russia: Consequences for society* (Index: EUR 46/5147/2016)

<sup>73</sup> Declaration on the Right and Responsibility of Individuals, Groups and Organs of Society to Promote and Protect Universally Recognized Human Rights and Fundamental Freedoms, 1998, Art. 5

<sup>74</sup> Amnesty International, *Report 2015/2016: The State of the World’s Human Rights* (Index: POL 10/2552/2016)

<sup>75</sup> Radio Tamazuj, S Sudan MPs pass law restricting aid groups, available at <https://radiotamazuj.org/en/article/s-sudan-mps-pass-law-restricting-aid-groups>, 2016

<sup>76</sup> Position Paper on the Non-Governmental Organisations Act 2016, 20 March 2016, Human Rights Awareness and Promotion Forum, available from <http://hrapf.org/publications/legal-analyses/>, p. 4

2006 оны ТББ-ын бүртгэлийн тухай (нэмэлт өөрчлөлт оруулсан) хуулиар бүртгэлгүй ТББ үйл ажиллагаа явуулахыг хориглосон байна.<sup>77</sup>

**Туркт** онц байдал зарлах үед 2016 оны 11-р сард гаргасан 677 тоот зарлигийн дагуух арга хэмжээний хүрээнд 375 холбоо, ТББ-ыг бүрэн хааж, хөрөнгийг нь хураасан юм. Тэднийг террорист байгууллагуудтай холбоотой, “үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулдаг бүтэц, байгууллага буюу бүлэглэл” хэмээн үзжээ. Хаагдсан ТББ-уудад үндэсний болон орон нутгийн хүний эрхийн, эмэгтэйчүүдийн, соёлын, тусламжийн байгууллагууд, оюутны болон бизнесийн холбоод, тэр бүү хэл спортын клубууд багтаж байна.<sup>78</sup>

## 4.3. ЧӨЛӨӨТЭЙ ЗОРЧИХ ЭРХ ЧӨЛӨӨНД ТАВЬСАН ХЯЗГААРЛАЛТ

Олон улс орон хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагаа, олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн механизмуудтай хамтран ажиллах, тусламж, дэмжлэг авах боломжийг хязгаарлах эсвэл саад учруулах зорилгоор хүний эрхийн хамгаалагчдын чөлөөтэй зорчих эрх, эрх чөлөөг хасдаг.

Ихэнх тохиолдолд хүний эрхийн хамгаалагчдын эсрэг гаргасан шүүхийн үндэслэлгүй шийдвэрийг ашиглан чөлөөтэй зорчих эрх чөлөөг олон янзаар хязгаарладаг бөгөөд үүнд хилээр нэвтрэхийг хориглох арга хэмжээ багтана. Виз өгөхөөс татгалзах, виз мэдүүлэх үйл явцыг чирэгдэлтэй болгох зэргээр хүлээн авагч улс чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлах нь бий.

Зарим төрлийн арга хэмжээ нь хүний эрхийн хамгаалагчид гадны дэмжлэг үзүүлэгч байгууллагуудаас олгосон боломжийг ашиглан өөр улсад зорчихыг хязгаарлаж, чадавхаа бэхжүүлэхэд саад учруулдаг. Эмнести Интернэшнлийн судалгааны ажилтнуудыг улс орнуудад нэвтрэхийг хориглох, судалгааны ажлаа хийж байхад нь албадан гаргах явдал олонтаа тохиолддог.

**Ахмед Мансуур** нь Мартин Энналсын Хүний эрхийн хамгаалагчийн шагналыг 2015 онд хүртэхээр болсон ч **Арабын Нэгдсэн Эмират** улс шагнал гардуулах ёслолд оролцохоор Швейцарь явахыг хориглосон.<sup>79</sup> 2011 онд эрх баригчид түүнийг болон өөр 4 хүнийг дур мэдэн баривчлахдаа паспортыг нь хураан авчээ. Энэ тайланд дурдсан олон арга тактикийг хэрэглэн чөлөөтэй зорчиход хязгаарлалт тавьснаар цаашид илүү ноцтой зөрчил үүсэх нөхцөл бүрдүүлдэг. 2017 онд Ахмед Мансуурыг гэрийн хорионд оруулсан бөгөөд энэхүү тайланг бичих үед түүний талаарх мэдээлэл тодорхойгүй байв.<sup>80</sup>

2016 онд **Пакистаны** Ерөнхий сайдын Ажлын албанаас *Dawn* сонины туслах редактор **Сирил Алмейдагийн** Засгийн газар, цэргийнхний хооронд үүссэн зөрчлийн талаар сонины эхний нүүрэнд нийтлүүлсэн мэдээг эсэргүүцсэн мэдэгдэл гарган тус улсын хилээр гарах хяналтын жагсаалтад оруулжээ.<sup>81</sup>

Хэд хоногийн дараа Сирил Алмейдаг жагсаалтаас хассан.<sup>82</sup> Ийм төрлийн айлгах тактикийг сэтгүүлчдийг дуугүй болгох, ажлыг нь зогсооход хэрэглэдэг.

Хүний эрхийн хамгаалагч **Абдул Фатоумаг** 2017 оны 1-р сарын сүүлээр **Сьерра Леоны** нийслэл Фриитаун хотод баривчилсны дараа гадаадад зорчихыг нь хориглосон. Абдул Фатоума Засгийн газар, Авлигатай тэмцэх комиссын үйл ажиллагааны хариуцлагагүй байдлын талаар тэмцэл явуулсныхаа төлөө ийнхүү баривчлагджээ. Ямар нэг ял тулгалгүй түүнийг сулласан ч паспортыг нь 45 хоног хураан авсан байна.<sup>83</sup>

<sup>77</sup> Position Paper on the Non-Governmental Organisations Act 2016, 20 March 2016, Human Rights Awareness and Promotion Forum, available from <http://hrapf.org/publications/legal-analyses/>, p. 2

<sup>78</sup> Amnesty International, *Turkey: Further information – Turkey permanently closes hundreds of NGOs* (Index: EUR 44/5208/2016)

<sup>79</sup> Amnesty International, *Human rights defender banned from travel* (Index: MDE 25/2464/2015)

<sup>80</sup> Amnesty International, *Human rights defender's whereabouts unknown* (Index: MDE 25/5923/2017)

<sup>81</sup> Amnesty International, *Pakistan: Drop travel ban on Dawn journalist*, 2016 (Press release, 11 October 2016)

<sup>82</sup> The Guardian, *Pakistan lifts travel ban on journalist whose scoop angered army*, available at [www.theguardian.com/world/2016/oct/14/pakistan-journalist-cyril-almeida-travel-ban-lifted](http://www.theguardian.com/world/2016/oct/14/pakistan-journalist-cyril-almeida-travel-ban-lifted)

<sup>83</sup> Amnesty International, *Sierra Leone anti-corruption activist's detention an attempt to stifle freedom of expression* (Press release, 1 February 2017)

**Малайзад** эрх баригчдын зүгээс шог зураач, улс төрийн идэвхтэн, Засгийн газрыг илт шүүмжлэгч **Зулкифли Анвар Улхааг (Зунар)** зэрэг хүний эрхийн хамгаалагчдыг хилээр гарахыг хориглосон арга хэмжээг дур мэдэн авч 2016 оны 10-р сард хувийн форумд оролцохоор Сингапур руу зорчих үед нь цагаачлалын албаны ажилтнууд хил нэвтрэхийг нь хориглосон болохыг мэдэгдэхдээ эрх зүйн үндэслэлтэй шалтгаан хэлээгүй байна.<sup>84</sup>



## **ЕГИПЕТ ДЭХ ХИЛ НЭВТРЭХ ХОРИГ, ХӨРӨНГӨ ЦАРЦААХ, ТББ-УУДЫН БАЙРАНД ДАЙРАН ОРОХ АЖИЛЛАГАА**

Сүүлийн 2 жилийн хугацаанд Египетийн эрх баригчдын зүгээс иргэний нийгмийн байгууллагуудын эсрэг явуулах үйл ажиллагаа урьд өмнөхөөс нэмэгдсэн. Хүний эрхийн байгууллага, тэдгээрийн санхүүжилтэнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгах болсноор эрх баригчдын зүгээс хүний эрхийн 17 хамгаалагчийг гадаадад зорчихыг нь хориглож, 7 байгууллага, 10 иргэний хөрөнгийг царцаан, мөрдөн шалгах үүрэгтэй шүүгчид байцаасан байна.

2017 оны 2-р сард хүний эрхийн хүчирхийлэл, эрүүдэн шүүлтээс амьд үлдсэн хүмүүст дэмжлэг үзүүлснийх нь төлөө Аль-Надимын Хүчирхийлэлд өртөгсдийн нөхөн сэргээх төвд цагдаагийн ажилтнууд дайран орж, үйл ажиллагааг нь хаав.<sup>85</sup> Аль Надим төвийн Гүйцэтгэх захирал Др. Айда Сейф Аль-Давлаг 2016 оны 11-р сараас эхлэн гадаадад зорчихыг нь хориглосон бол мөн сард Хүний эрх, хуулийн үндэсний нийгэмлэгийн Ахмед Рагнев, Египетийн Эдийн засаг, нийгмийн эрхийн төвийн Малик Адли зэрэг өөр 4 хүний эрхийг хамгаалагчийг хилээр гарахыг хориглосон байна.

2016 оны 12-р сард хүчний байгууллагынхан Эмэгтэйчүүдийн эрх зүйн тусламжийн төвийн дарга Азза Солиманыг гэрээс нь баривчилж, Засгийн газрын зөвшөөрөлгүй гадаадын санхүүжилт авсан гэх ял тулган, мөрдөн шалгах үүрэгтэй шүүгч түүнийг байцааж, хэдэн цагийн дараа сулласан.<sup>86</sup> Олон нийтийн анхаарлыг татсан гадаадын санхүүжилтын хэрэгтэй холбогдуулан хилээр нэвтрэхийг нь хориглосны дараа түүнийг 3 долоо хоногийн турш гэрийн хорионд байлгажээ. Түүнчлэн 2016 оны 6-р сард феминист судалгааны Назра байгууллагын Мозн Хассаныг Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах бүс нутгийн эвсэл болох МЕНА-гийн Гүйцэтгэх хорооны уулзалтад оролцохоор Бейрут руу явахыг хориглов.

Энэ бүх тохиолдолд эрх баригчдын зүгээс ямар шалтгаанаар нисэх онгоцонд оруулаагүй, хилээр гарахыг хориглох болсон үндэслэлийг тайлбарласан албан ёсны баримт бичгийг өгдөггүй байна. Заримдаа Дотоод хэргийн яамны Үндэсний аюулгүй байдлын агентлагийн ажилтнууд хүний эрхийн хамгаалагчдыг байцаах, ачаа тээш, утсанд нь нэгжлэг хийх, паспортыг нь үндэслэлгүйгээр хураан авах нь бий. Ихэнх тохиолдолд тэдэнд хэзээ эсвэл ямар тохиолдолд хилээр нэвтрэх хориг дуусах тухай мэдээлэл өгдөггүй. Иймэрхүү хилээр нэвтрэхийг хориглосон хориг олон улсын хүний эрхийн хууль тогтоомж, Египетийн Үндсэн хуультай зөрчилддөг. Хилээр нэвтрэх хориг чөлөөтэй зорчих, эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчиж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг боомилж байгаагаас хүний эрхийг хамгаалах нь хүсүүштэй биш гэх ойлголт төрүүлж байна.

84 Amnesty International, *Malaysia: Drop travel ban on Zunar and other government critics* (Index: ASA 28/5013/2016)

85 Amnesty International, *Shutdown of renowned torture rehabilitation centre in Egypt* (Press release, 9 February 2017)

86 Amnesty International, *Egypt: Prominent women's rights activist arrested in worrying escalation* (Press release, 7 December 2016)

# 5. ТӨР БУС ТОГЛОГЧДЫН ӨДҮҮЛСЭН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ

## 5.1. БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГУУД

Компаниуд хүний эрхийг хүндэтгэх үүрэг хүлээдэг. Энэ үүргийн хүрээ, утга учрын талаар Бизнес болон Хүний эрхийн тухай НҮБ-ын баримтлах зарчим (НҮБ-ын баримтлах зарчим)-д тодорхой заажээ.<sup>87</sup> Хүний эрхийг хүндэтгэх үүргийн хүрээнд компаниуд

**«[Ө]өрийн үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхэд сөргөөр нөлөөлөх эсвэл оролцохоос зайлсхийх, нөлөө үүссэн тохиолдолд шийдвэрлэх» үүрэгтэй.**

Мөн компаниуд

**«[Х]үний эрхийн сөрөг нөлөөлөл үүсэхэд оролцоогүй ч бизнесийн харилцаагаараа дамжуулан үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй нь шууд холбогдох хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх буюу бууруулах» үүрэг хүлээнэ.**

НҮБ-ын баримтлах зарчимд бизнесийн үйл ажиллагаанаас үүсэх хүний эрхийн сөрөг нөлөөллийг үнэлэхэд хүний эрхийн хамгаалагчид чухал үүрэг гүйцэтгэх тухай заажээ. Мөн уг баримт бичиг нь хүний эрхийн хамгаалагчдын хуулийн хүрээнд, тайван замаар үйл ажиллагаа явуулахад хязгаарлалт тавьж болохгүй гэдгийг улс орнуудад сануулсан.

Гэсэн хэдий ч хүний эрхийн хамгаалагчид бизнесийн байгууллагуудын гарт өртөх юмуу эсвэл ноцтой аюул занал, халдлагатай нүүр тулгарсаар байна. Ажлыг нь эсэргүүцсний төлөө хариугаа авах зорилгоор Засгийн газрууд, хувийн байгууллагуудын зүгээс халдлага, хязгаарлах арга хэмжээтэй тулгарах явдал нэмэгдэх болсон талаар сүүлийн үед гарсан олон илтгэл тайлан баримтжуулжээ.<sup>88</sup>

2014 онд Хүний эрх, үндэстэн дамнасан корпорацууд, бусад бизнесийн аж ахуйн нэгжүүдийн асуудлаарх НҮБ-ын Ажлын хэсэг тайландаа хүний эрхийн хамгаалагчдад нүүрлэсэн аюул занал, халдлагын талаар сэтгэл түгшээсэн олон мэдээг дурджээ:

**«Олборлох компаний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн эсрэг уул уурхай, усан цахилгаан станцын төслүүдийн уугуул иргэдэд үзүүлэх нөлөөллийн талаар кампанит ажил явуулсан хүний эрхийн хамгаалагчдын амь насыг хөнөөж, халдаж, айлган сүрдүүлсэн талаар олон мэдээг авч үзсэн болно. Төрийн болон төр бус тоглогчид бизнесийн үйл ажиллагаа, томоохон хөгжлийн төслүүдийн бодит болон болзошгүй сөрөг нөлөөллийг эсэргүүцсэн хүмүүсийн эсрэг халдлага, айлган сүрдүүлэг үйлдэх явдал ихээхэн нэмэгдэж буйд Ажлын хэсэг туйлаас санаа зовниж байна.»<sup>89</sup>**

<sup>87</sup> UN Guiding Principles on Business and Human Rights: Implementing the United Nations “Protect, Respect and Remedy” Framework, UN Doc. HR/PUB/11/04 (2011)

<sup>88</sup> Global Witness, Honduras: The deadliest country in the world for environmental activism, 2017, available at [www.globalwitness.org/en/campaigns/environmental-activists/honduras-deadliest-country-world-environmental-activism/](http://www.globalwitness.org/en/campaigns/environmental-activists/honduras-deadliest-country-world-environmental-activism/); Report of the Special Rapporteur on the rights to freedom of peaceful assembly and of association, Maina Kiai, UN Doc. A/HRC/29/25 (2015); Report of the Special Rapporteur on the situation of HRDs, Michel Forst, UN Doc. A/71/281 (2016)

<sup>89</sup> United Nations General Assembly, Report of the Working Group on the Issue of Human Rights and Transnational Corporations and other Business Enterprises, UN Doc. A/HRC/26/25 (2014), p. 18

**«Бизнесийн байгууллагууд, томоохон дэд бүтэц, үйлдвэрлэлийн төслүүдийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхээр ажиллаж буй хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах, хүндэтгэх шаардлагатай талаар нь бизнесийн аж ахуйн нэгжүүдэд таниулах»<sup>90</sup> -ийг уриалав.**

Газар, байгаль орчинтой холбоотой хүний эрхийн хамгаалагчдад тулгарсан аймшигт байдал нь улс орнууд, бизнесийн байгууллагуудын “байгалийн баялгийг бүтээгдэхүүн болгон хувиргахад явцад үүссэн хүчний тэнцвэрт бус байдал”<sup>91</sup>-тай шууд хамааралтай. Эдгээр асуудлаар ажилладаг хүний эрхийн хамгаалагчдын эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийн түвшин өндөр байгааг Эмнести Интернэшнлийн судалгаа нотолдог. Тус байгууллагын баримтжуулсан хэргүүдийн дийлэнх нь компаниуд байгалийн баялгийг олборлох төслүүдтэй холбоотой байв.<sup>92</sup>

Жишээлбэл, 2016 оны 3-р сард газрын эрхийг хамгаалагч Сикосифи **Базуука Рхадебе**<sup>93</sup> **Өмнөд Африкийн** Зүүн Кейф мужийн Лурхолвени дахь гэртээ цагдаагийн ажилтнууд байж болзошгүй 2 хүнд буудуулан амь насаа алдсан. Тэрээр Австралид төвтэй Mineral Commodities Limited-ийн харьяа орон нутгийн компани Солобенигийн нийтийн эзэмшлийн газарт титан, бусад хүнд металлын ил уурхай байгуулахыг олон арван жилийн турш эсэргүүцэж иржээ. Энэ хэсэгт амьдардаг иргэдийн зарим нь уурхай ажиллаж эхэлбэл орон гэрээ алдан, усны бохирдолтой холбоотой өвчинд нэрвэгдэхээс айдаг. Бусад иргэд энэ санаачилга ажлын байр бий болгоно гэж үздэг. Сикосифи Базуука Рхадебегийн аллагад хэн ч хариуцлага хүлээгээгүй байна.

2016 оны 6-р сард **Мьянмарын** төв хэсгийн Сагайн бүсийн Тхон тосгоны **Дав Мар Чо, Дав Ма Санда** нарт бусдын нэр төрд халдсан хэргээр ял тулгасан тухай Салинги хотын шүүхийн мэдэгдэл иржээ. Сарын өмнө Летпадуангийн уурхайд зэс боловсруулахыг эсэргүүцсэн жагсаалд тосгоны бусад иргэдийн хамт оролцсоных нь төлөө тэдэнд ял тулгасан байна. Энэ тайланг бичих үед шүүхээс ямар нэг мэдээлэл ирээгүй ч буруутайд тооцогдсон тохиолдолд 4 хүртэл жилийн хорих ял оноож болзошгүй. Тхон тосгоны иргэд уурхайд алдсан газрынхаа оронд хангалттай нөхөн олговор аваагүй гэж үзсэн учраас жагсааж цуглаасан хийсэн байна.<sup>94</sup>

Нэгдүгээр сард Махан Соал компаниас нэхэмжилсэн нэр төрд нь халдсан гэх эрүүгийн ялыг эсэргүүцсэн **Энэтхэгийн** Грийнпийс байгууллагын идэвхтэн **Прия Пиллайгийн** гомдлыг Энэтхэгийн Дээд шүүх хэрэгсэхгүй болгожээ. Тус компаний зүгээс түүнийг сөрөг мэдээлэл олон нийтэд цацаж, уурхайн үйл ажиллагааг доголдуулах зорилготой жагсаал цуглаан явуулсан гэж үзэж байгаа юм. Шүүхийн гаргасан энэхүү шийдвэр түүний эсрэг тулгасан ялыг хэвээр үлдээсэн хэрэг боллоо. Энэ нь уг ажилтны төдийгүй Грийнпийс байгууллагын эсрэг авсан хэд хэдэн арга хэмжээний зөвхөн нэг нь юм.<sup>95</sup>

Хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай Илтгэгчийн хамгийн сүүлд гаргасан тайланд дараах байдлаар дурджээ. Үүнд:

**«Байгаль орчны хүний эрхийн хамгаалагчдын эрхийг хүндэтгэх компаниудын үүргийн талаар үйлчилж буй дэглэм сул байгаа нь тэднийг эрсдэлд оруулах суурь шалтгааны нэг болж байна. Тайлангуудаас үзэхэд бизнесийн байгууллагуудын холбогдсон хүний эрхийн зөрчлүүдэд хуулийн дагуу зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг хязгаарлах, эрхээ эдлэхэд нь саад учруулах, компаниудын нэрийн өмнөөс хувийн хамгаалалтын албад халдлага зохион байгуулах зэрэг багтана. Улс орнууд үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө батлахдаа ийм зөрчилд холбогдсон корпорацудын эсрэг хэрхэн арга хэмжээ авах талаар зөвлөмж оруулаагүй байх нь түгээмэл.»<sup>96</sup>**

<sup>90</sup> United Nations General Assembly, Report of the Working Group on the Issue of Human Rights and Transnational Corporations and other Business Enterprises, UN Doc. A/HRC/26/25 (2014), p. 22

<sup>91</sup> United Nations Special Rapporteur on HRDs, They spoke truth to power and were murdered in cold blood: Analysis of the situation of environmental human rights defenders and concrete recommendations to better protect them, adaptation of UN Doc. A/71/281 (2016)

<sup>92</sup> Amnesty International, *We are defending the land with our blood: Defenders of the land, territory and environment in Honduras and Guatemala*, (Index: AMR 01/4562/2016)

<sup>93</sup> Amnesty International, *South Africa: Human rights defenders under attack* (Index: AFR 53/4058/2016)

<sup>94</sup> Amnesty International, *Mountain of trouble – human rights abuses continue at Myanmar's Letpadaung mine* (Index: ASA 16/5564/2017)

<sup>95</sup> Frontline Defenders, Environmental campaigner faces criminal defamation, available at [www.frontlinedefenders.org/en/case/environmental-campaigner-faces-criminal-defamation-case](http://www.frontlinedefenders.org/en/case/environmental-campaigner-faces-criminal-defamation-case)

<sup>96</sup> United Nations Special Rapporteur on HRDs, They spoke truth to power and were murdered in cold blood: Analysis of the situation of environmental human rights defenders and concrete recommendations to better protect them, adaptation of UN Doc. A/71/281 (2016),



Хөгжил, эдийн засгийн өсөлтийг зогсоохыг оролдсон гэх шалтгааны улмаас байгалийн баялгийг ашиглахыг эсэргүүцсэн тэмцэл, хөдөлгөөн өрнүүлсэн бүлгүүдийн эсрэг үйлдсэн гэмт үйлдлийг олон орны Засгийн газар зөвтгөсөөр байна.



## ПЕРУ УЛСЫН ИРГЭН МАКСИМА АКУНА

*Máxima Acuña in Cajamarca, Peru, 20 May 2016*

© Raúl García Pereira/Amnesty International

Максима Акуна бол алтны уурхайн болзошгүй нөлөөллөөс үүдэн аюулд орсон орон нутагтаа аюулгүй орчин бүрдүүлэхийн төлөө хийсэн ажлаараа 2016 оны Голдманы байгаль орчны шагнал хүртсэн эмэгтэй юм. Тэрээр Перугийн умард хэсгийн Кажамарма бүсийн Сорочуко дүүрэгт газар тариалан эрхлэн, амьдралаа залгуулдаг. 2011 оноос эхлэн энэ эмэгтэй газрынхаа өмч, өмчлөлийн асуудлаар Яанакоча уул уурхайн компанитай хуулийн маргаан үүсгэн, тэмцэл өрнүүлж байна. Уул уурхайн компани тэднийг уг газраас нүүхийг шаардсан төдийгүй ургацыг нь авах, газрын эзэмшлийг шилжүүлэхийн тулд эрүү, иргэний хуулиудаар далайлгажээ.

Максима Акунад болон гэр бүлд нь үндэслэлгүйгээр “usurpación” буюу газрыг хууль бусаар, хүчээр булаан авахтай холбоотой эрүүгийн хэрэг тулгасан. 2012 онд шүүхээс буруутай гэж үзэн, 3 жилийн хугацаанд шоронд хорих ял ногдуулжээ. 2014 оны 12-р сард Кажармаркагийн шүүх дээрх шийдвэрийг албажуулан, компаний нэхэмжилсэн газрыг хууль бусаар булаан авсан хэрэгт буруугүй гэж үзсэн. Уул уурхайн компани уг шийдвэрийг давж заалдсан бөгөөд Дээд шүүх эцсийн шийдвэрийг 2017 оны 4-р сард гаргах юм.

Мөрдөн шалгасан явдал Максима Акунаг болон хүний эрхийг хамгаалах ажлыг ихээр гутаан доромжилж, хүний эрхийг ашиглан ашиг, хонжоо хайж байна гэх худал цуурхлыг ойр орчимд нь тараасан. Түүнчлэн шүүхээс газар эзэмшлийн асуудлыг тогтоогоогүй байхад Яанакочагийн уурхайнхан “хүний газарт дураараа суугч” хэмээн олон удаа буруутгаж байв.

Амьдарч буй газраасаа нүүхээс татгалзсныхаа төлөө Максима гэр бүлтэйгээ цагдаагийн байнгын хүчирхийлэл, дарамтад өртсөөр байна. 2014 оны 5-р сард Хүний эрхийн Америк хоорондын комиссоос хийж буй ажлаасаа үүдэн аюул занал, дарамт, хүчирхийлэлд өртсөн Максима Акуна, Кажамаркагийн тариачин 45 хүний эрхийн хамгаалагчдад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авчээ. Энэ дагуу Перу улс эдгээр хүний эрхийн хамгаалагчийн амь нас, бие махбодийн бүрэн бүтэн байдлыг хангахад шаардлагатай арга хэмжээг авах үүрэг хүлээнэ.<sup>97</sup>

## 5.2. ЗЭВСЭГТ БҮЛЭГЛЭЛҮҮД

Зэвсэгт мөргөлдөөнтэй газрын хүний эрхийн хамгаалагчид тодорхой аюул, сорилттой нүүр тулгардаг. Хүний эрхийн хамгаалагчдыг болзошгүй дайснаа гэж үздэг мөргөлдөөнд оролцогч янз бүрийн талууд мөргөлдөөний бүсэд ажиллан, хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлдэг хүний эрхийн хамгаалагчдад халдах нь олонтаа. Ихэнх тохиолдолд хүчний байгууллагууд, зэвсэгт бүлэглэлүүд, бусад зэвсэглэсэн байгууллага халдлага үйлдэж болзошгүй байдаг.<sup>98</sup>

<sup>97</sup> Peru: Human rights defender Máxima Acuña criminalized by unsubstantiated criminal prosecution for land invasion (Index: AMR 46/5879/2017)

<sup>98</sup> United Nations General Assembly, Report of the Special Rapporteur on human rights defenders, Situation of human rights defenders, UN Doc. A/70/217 (2015)

Мөргөлдөөний бүсэд ажиллаж буй хүний эрхийн хамгаалагчдад нийтлэг тохиолддог хүний эрхийн зөрчилд хууль бусаар амь насыг нь хөнөөх, хулгайлах, барьцаалах, эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр зүй бусаар харьцах (түүний дотор бэлгийн хүчирхийлэл), хүчээр өөр газарт аваачих зэрэг хамаардаг.

2014 оны 9-р сард Хуттичууд холбоотнуудтайгаа Сана хотод орж, нийслэл, **Йемений** умард хэсгийн бусад газарт хяналтаа тогтоосноос хойш хяналтын хэсэгтээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд ноцтой саад учруулах болов. Шүүмжлэгч, эсэргүүцэгчид, сэтгүүлчид, хүний эрхийн хамгаалагчид, Баха'и үндэстний төлөөллийг дур мэдэн баривчилснаар хүчээр сураггүй болгох, ТББ-уудыг хаах явдал нэмэгдсэн. 2015 оны эцсийн байдлаар Сана хотод наад зах нь 27 ТББ хаагдсан байна. 2015 оны 6-р сард Сана хотод явуулсан нэг удаагийн ажиллагаагаар 9 сэтгүүлчийг баривчилсан. Энэ тайланг бичих үед тэд хоригдсон хэвээр байв. Тэдний зарим нь Хуттичуудын тогтоосон хяналтыг эсэргүүцдэг Аль-Исла намд харъяалагдах цахим мэдээний сайтын сэтгүүлчид байв.<sup>99</sup>

**Колумбид** 2016 онд энхийн гэрээ байгуулагдсан хүний эрхийн хамгаалагчдын амь насыг хөнөөх явдал нэмэгдсээр байна. 10 гаруй жилийн өмнө цэргээ тараасан гэж байгаа ч хагас цэрэгжсэн бүлэглэлүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн, дангаараа эсхүл Засгийн газрын хүчинтэй сүлбэлдэн хүний эрхийн хамгаалагчид, бусад хүмүүсийн эсрэг халдлага, дайралт үйлдсэн байж болзошгүй. 2016 он турш, 2017 оны эхэнд орон нутгийн ТББ-уудын мэдээлснээр Колумбийн Гайтанистагийн өөрийгөө хамгаалах хүчний хагас цэрэгжсэн дайчид Чоко бүсийн Какармка хүмүүнлэгийн бүс, хамтын газар нутаг болон Антиок хэсгийн Сан Хосе дэ Апартадогийн энхийн бүсэд халдлага, дайралт хийжээ.<sup>100</sup>

## 5.3. ЗОХИОН БАЙГУУЛАЛТАЙ ГЭМТ ХЭРГИЙН БҮЛЭГЛЭЛҮҮД

Ялангуяа төрийн институцууд сулаас нутаг дэвсгэртээ бүрэн хяналт тогтоож чаддаггүй, гэмт хэрэг, хүний эрхийн зөрчилд хариуцлага хүлээлгэдэггүй улс орнуудад зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд хүний эрхийн хамгаалагчдад аюул учруулдаг.<sup>101</sup> Дэлхийн хэд хэдэн оронд олон нийтийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой үүрэг, зорилтуудыг биелүүлэхэд зэвсэгт хүчинд тулгуурлах эсхүл гэмт хэргийн бүлэглэлүүдтэй тэмцэхэд цагдаа, хууль сахиулах агентлагуудын хэрэгслийг ашигласаар байна.

Олон тохиолдолд зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд төр засагтай сүлбэлдэх буюу тэдний заавраар ажилладаг. Гэмт хэргийн бүлэглэлүүдийн үйлдлийг илчилж, хариуцлага хүлээлгэхээр ажилладаг хүний эрхийн хамгаалагчид хүчирхийлэл, халдлагатай тулгарах нь элбэг. Хүний эрхийн хамгаалагчид эсрэг талаа хэн болохыг нь мэдэх эсвэл ямар аюул нүүрлэх магадлалтайг үнэлэхэд түвэгтэй, төрөөс хамгаалах механизм хангалтгүй нөхцөлд тэдэнд өөрийгөө хамгаалах нь бараг боломжгүй.

**Гондурас** эрх баригчид гэмт хэргийн бүлэглэлтэй холбоотой хүчирхийллийг зогсоох чадваргүйгээ харуулсан. Хууль сахиулах, хүчний байгууллагуудад авлига, хээл хахууль, хүний эрхийн зөрчил даамжирсан өнөөгийн нөхцөлд хүний эрхийн хамгаалагчдыг ямар ч хамгаалалтгүй орхижээ. Ялангуяа хүний эрхийн зөрчлийн хохирогч, гэрчийн хамаатан садангууд эрсдэлтэй тулгардаг. **Алекса** (жинхэнэ нэр нь биш) бол орон нутгийн бүлэглэлийн 5 гишүүн эгнээндээ элсүүлэхээр дарамтлахдаа 2 залуугийн амь насыг хөнөөсөн хэргийн гэрч болсны улмаас хамгаалалтад орсон эмэгтэй юм.

99 Amnesty International, "Where is my father?": Detention and disappearance in Huthi-controlled Yemen, 2016 (Index: MDE 31/4006/2016)

100 Amnesty International, *Annual Report 2016-2017, The State of the World's Human Rights* (Index POL 10/4800/2017);

Amnesty International, Colombia: Spike in killings as activists targeted amid peace process, (Press release 7 February 2017)

101 Insight Crime: Investigation and analysis of organized crime, criminal evolution and violence in Latin America and the Caribbean, 2014, available at [www.insightcrime.org/news-analysis/evolution-crime-violence-latin-america-caribbean](http://www.insightcrime.org/news-analysis/evolution-crime-violence-latin-america-caribbean)

Амьдардаг газраасаа явахгүй бол гэр бүлийг нь бүгдийг нь ална гэж заналхийлсэн тодорхой нэр хаяггүй мессэжийг Алексагийн хүү **Маурисиод** явуулсан байна. Алекса 2 хүүтэйгээ Мексик рүү зугтан гарсан.<sup>102</sup>

Ерөнхийдөө хүний эрхийн хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөхгүй байх нь зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд эсвэл олон нийтийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангадаг газарт илүү тодорхой харагддаг. Ялангуяа эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг илүү гадуурхах, үйл ажиллагааг нь хууль бусад тооцох явдал их байдаг.

**Мексикт** 2006 оноос хойш 30 мянга гаруй хүн ор сураггүй алга болсон. Тэдний хэд нь төр засгийн байгууллагуудын хүчээр ор сураггүй алга болгох ажиллагаанд өртсөн, хэд нь бусад тоглогчдын гарт байгаа нь өнөөг хүртэл тодорхойгүй. Мексикийн умард хэсгийн Чуаутомок хотод хайртай хүмүүсээ хайсан хүмүүс үнэн, шударга ёсыг шаардсныхаа төлөө халдлага, аюул, дарамтад өртсөөр байна. Төрийн байгууллагын ажилтнууд гэмт хэрэгтнүүдтэй сүлбэлддэг, хийсэн хэрэгтээ ямар ч хариуцлага хүлээдэггүй учраас хамаатан садан, найз нөхөд нь ор сураггүй болсон тохиолдолд гэр бүлүүд засаг захиргаандаа мэдэгдэхээс айх явдал нэмэгджээ.<sup>103</sup>

---

<sup>102</sup> Amnesty International, *Home sweet home? Honduras, Guatemala and El Salvador's role in a deepening refugee crisis* (Index: AMR 01/4865/2016)

<sup>103</sup> Amnesty International, *Treated with indolence: The state's response to disappearances in Mexico* (Index: AMR 41/3150/2016),

# 6. ДАВХАР АЛАГЧЛАЛЫН НӨЛӨӨ

Хүйс, үндэс угсаа, шашин, каст, анги, бэлгийн чиг хандлага, жендэрийн онцлог шинж, нас, үндэс угсаа, уугуул иргэдийн бүлгийн гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй зэргээс шалтгаалан шоовдорлогдсон хүмүүс, бүлгүүдээс гаралтай байх юмуу эсвэл тэдэнтэй ажилладаг хүний эрхийн хамгаалагчид тодорхой сорилтуудтай тулгардаг. Тэдэнд тулгардаг хүний эрхийн зөрчлүүд нь олон талтай төдийгүй ялгаварлан гадуурхалтын давхацсан хэлбэрүүдийн золиос болдог. Өөрсдийг нь тодорхойлдог онцлог шинжүүдээс шалтгаалан дээрх хүмүүс буюу тэднийг төлөөлж буй ялгаварлан гадуурхалтад өртдөг.

## 6.1. ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД

Дэлхийн бүс нутаг бүрт эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид бусад хүний эрхийн хамгаалагчдад тулгардаг халдлага, сүрдүүлэгтэй нүүр тулахын зэрэгцээ эмэгтэй хүний хувьд жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд, гүтгэлэг доромжлолын кампанит ажлын баг болдог.

Идэвхтэй үйл ажиллагааныхаа төдийгүй жендэрийнхээ улмаас эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид бурангуй нөхцөлд орох нь цөөнгүй. Тэдний олонх нь ашиг сонирхлынх нь эсрэг илэрхий дайсагнасан орчинд ажиллах хэрэгтэй болдог. Жендэрийн тогтсон ойлголтыг өөрчлөх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх зэрэг асуудлаар ажилладаг буюу эмэгтэйчүүд, охидын эрхийг илүү өргөн хүрээнд хамгаалдаг эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид жендэрт суурилсан халдлага, аюулд илүү эмзэг байх нь түгээмэл.

НҮБ-ын Хүний эрхийн дээд Коммиссаратын мэдэгдснээр эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид бусад хүний эрхийн хамгаалагчдад тохиолддог эрсдлүүдтэй нүүр тулгарахын зэрэгцээ жендэрт суурилсан аюул заналын бай болж хүчирхийлэлд өртдөг байна. Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид руу дайрах шалтгаан нь олон талтай, ярвигтай бөгөөд ихэнх тохиолдолд тухайн орчин нөхцлөөс хамаардаг. Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдын ажил нь гэр бүлийн болон нийгэмд гүйцэтгэх жендэрийн уламжлалт ойлголтуудыг өөрчилж байгаагаар ойлгогддог учраас нийт хүн ам, эрх баригчид дайсагнаж ханддаг. Үүнээс үүдэн ажлаараа дамжуулан шашин, нэр хүнд эсвэл соёлд заналхийлж байна гэж үздэг орон нутгийн удирдагчид, итгэл үнэмшилд суурилсан бүлгүүд, гэр бүл, орон нутгийнхнаас үзүүлэх гутаан доромжлол, шоовдорлох хандлагад эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид өртдөг.<sup>104</sup>

Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдын олон улсын эвслийн<sup>105</sup> цохон тэмдэглэснээр “албан ёсны шашин”-аар нөхцөлдсөн эсвэл эмэгтэйчүүдэд тодорхой эрхүүдийг олгохгүй байх буюу тодорхой шийтгэлийг эмэгтэйчүүдэд шударга бусаар ногдуулах замаар ялгаварлан гадуурхалт үүсгэсэн шашны эрх зүйн тогтолцоотой нөхцөлд эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдын явуулах ёстой үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцож болзошгүй байдаг.

<sup>104</sup> Office of the High Commissioner for Human Rights, Women Human Rights Defenders, available at [www.ohchr.org/EN/Issues/Women/WRGS/Pages/HRDefenders.aspx](http://www.ohchr.org/EN/Issues/Women/WRGS/Pages/HRDefenders.aspx)

<sup>105</sup> The Women HRDs International Coalition (WHRDIC) is a network that supports and protects women HRDs worldwide in their defence of human rights, [www.defendingwomen-defendingrights.org](http://www.defendingwomen-defendingrights.org)

Тухайлбал, үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцсоноор үр хөндөлт үйлдэгчдийг хуулиас гадуур ажиллахад хүргэж, халдлагыг зохих байгууллагуудад мэдээлэх нь багасах, цаашлаад мөрдөн шалгах, шийтгэх магадлалыг бууруулдаг.<sup>106</sup>

Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдыг тухайн бүлгээс тусгаарлахын тулд тэднийг бэлгийн замбараагүй байдалтайгаар дүрслэх, гутаан доромжлох кампанит ажлыг зохион байгуулдаг. Хүүхдүүд, хувь хүмүүс рүү халдах зэргээр эмэгтэйчүүдийг хүүхдийн сайн сайхны төлөө хийх ажлаас нь хөндийрүүлэхийг зорьдог.

**Бразилийн** Рио де Жанеро мужийн Нитерой хотод биеэ үнэлдэг **Изабель** (жинхэнэ нэр нь биш) биеэ үнэлэгчдийн эсрэг үйлдэгддэг хүчирхийлэл, цагдаагийн сүрдүүлэг, дарамт, хүчээр хөөн гаргах зэргийн талаар 2014 оны 6-р сард олон нийтэд ил болгожээ. 2 долоо хоногийн дараа Изабеллийг 4 эрэгтэй автомашинд хүчээр суулган 30 гаруй минутын турш авч яван гарыг нь сахлын хутгаар зүсч, сургуульд орж буй хүүхдийнх нь зургийг үзүүлэн цагдаа нарыг буруутгаж, сэтгүүлчдэд ярихгүй байхыг тулгасан. Ингэж хулгайлагдсныхаа дараа Изабель холбогдох байгууллагуудад нь мэдэгдэхээс туйлаас айж, гэр бүлийнхээ төлөө санаа зовнин амьдрах болсон. Тэр бүү хэл гэртээ очихоосоо түгшдэг.<sup>107</sup>

**Энэтхэгийн** Чхаттисгарх дахь хүчний байгууллагынхан Маоист зэвсэглэсэн бүлэглэлүүдийн үйлдсэн хүний эрхийн зөрчлүүдийг илэрхий шүүмжилдэг **Сони Соригийн** биед 2016 оны 2-р сарын 20-ны өдөр халджээ. Гурван үл мэдэгдэх хүн нүүр рүү нь химийн бодис цацаж, хэсэг зуур хараагүй болгосон. Сони Сори шүүхээс гадуур цаазын ял гүйцэтгэх хэрэгт холбогдсон цагдаагийн өндөр тушаалын албан хаагчийн эсрэг гомдол гаргахаар ажиллаж байсан юм. 2011-2014 онд Сони Сорид улс төрийн зохиомол шалтгаантай ял тулган, хорьж байв.<sup>108</sup>

**Филиппинд** 2017 оны 2-р сард Филиппиний Хууль зүйн сайд, Хүний эрхийн комиссын дарга асан, хүний эрхийн хамгаалагч **Лейла де Лимаг** улс төрийн шалтгаанаар ял тулган, баривчлав. Энэхүү тайланг бичих үед тэрээр Манила хот дахь Филиппиний Үндэсний цагдаагийн газрын төв байранд хоригдож байсан бөгөөд буруутай гэж үзсэн тохиолдолд түүнд 12 хүртэл жилийн ял ногдуулахаар байна. 2016 оны 7-р сараас эхэлсэн 7000 гаруй хүний амь насыг хөнөөсөн гэгддэг Ерөнхийлөгч Дутертегийн балмад “хар тамхины дайн”-ы талаарх Сенатын мөрдөн шалгах ажиллагааг тэргүүлж эхэлснээс нь хойш Лейла де Лима Ерөнхийлөгч, нөхдийнх нь эмэгтэйчүүдийг үзэн ядах халдлага, нэр төрийг нь гутаан доромжлох кампанит ажлын золиос болжээ.<sup>109</sup>

**Азербайжаны** эрэн сурвалжлах сэтгүүлч, нэр хүндтэй шагналын зээн, Засгийн газрыг илт шүүмжлэгч **Хадиджа Исмаиловад** зохиомол хэрэг тулган 2015-2016 оны хооронд 8 сарын хугацаанд дур мэдэн хорих зэргээр урт хугацаанд үргэлжилсэн гутаан доромжлох кампанит ажлын золиос болгосоор байна. 2012 онд хувийн амьдралыг нь харуулсан, гэрт нь нууцаар суурилуулсан камераар авсан дүрс бичлэгээс таслан авсан зургийн хамт “ажлаа орхихгүй бол харамсах болно” гэх заналхийлсэн зурвас явуулсан. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр “ээжийг нь охиных нь ‘ичгүүргүй амьдралынх нь хэв маяг’-т буруутгасан, түүнийг болон эгчийг нь насанд хүрэгчдийн кинонд тоглосон гэх мэдээллүүд нийтлэсэн байна.<sup>110</sup>

**Ираны** хүний эрхийн хамгаалагч, шог зураач **Атена Фархаданиг** 2014 оны 12-р сард баривчлан, сайн дураар үрийн сувгаа боолгохыг гэмт хэрэгт тооцох, жирэмсэлтээс хамгаалах хэрэгсэл хэрэглэх, гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээг хязгаарласан хуулийн төслийг эсэргүүцсэн шог зураг зурсных нь төлөө анхан шатны шүүхээс 13 жил хорих ял оноожээ.

Тэрээр 18 сар хоригдсныхоо дараа 2016 оны 5-р сард суллагдсан юм. 2015 онд Атена Фархаданиг эрэгтэй хуульчтайгаа гар барьсных нь төлөө “садар самууны зорилгоор богино хугацаанд хууль бус бэлгийн харилцаа”-нд орсон хэмээн яллаж, “онгон байгаа эсэх болон жирэмсний үзлэг”-т хүчээр оруулсан.<sup>111</sup>

<sup>106</sup> Women Human Rights Defenders International Coalition, *Global Report on the Situation of Women Human Rights Defenders*, 2012, p. 21, available at [www.defendingwomen-defendingrights.org/wp-content/uploads/2014/03/WHRD\\_IC\\_Global-Report\\_2012.pdf](http://www.defendingwomen-defendingrights.org/wp-content/uploads/2014/03/WHRD_IC_Global-Report_2012.pdf)

<sup>107</sup> Amnesty International, *Brazil: Sex workers evicted and abused by police* (Index: AMR 19/006/2014)

<sup>108</sup> Amnesty International, *Blackout in Bastar, Human Rights Defenders under threat*, 2016, available at [www.amnesty.org.in/images/uploads/articles/Chhattisgarh\\_Campaign\\_Digest.pdf](http://www.amnesty.org.in/images/uploads/articles/Chhattisgarh_Campaign_Digest.pdf)

<sup>109</sup> Amnesty International, *Philippines: Impending arrest of senator politically motivated* (Index: ASA 35/5772/2017)

<sup>110</sup> Amnesty International, *Guilty of defending rights: Azerbaijan's human rights defenders and activists behind bars* (Index: EUR 55/1077/2015)

<sup>111</sup> Iran: Imprisoned cartoonist subjected to forced “virginity test” (News story, 9 October 2015)

**Эль Сальвадор**т бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн талаар кампанит ажил явуулдаг эмэгтэй хүний эрхийн идэвхтнүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд “ичгүүргүй”, “үхлийг хүсэгчид”, “аль хэдийн цусан далайд живсэн оронд нэрмээс бологчид”, “Эль Сальвадорыг шившигт хутгасан эх оронч бус урвагчид”, “эмзэг эмэгтэйчүүдийн толгой эргүүлэгчид” гэж буруутган бичжээ.<sup>112</sup>

Түүнчлэн эрх баригчид эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдын хувийн нууцтай байх эрхийг сулруулах, цахим гутаан доромжлолын бай болгохыг зорьдог. Зарим тохиолдолд хувийн үйл ажил, гэрэл зураг эсвэл дүрс бичлэгийг нь олон нийтэд ил болгох зорилгоор хувийн цахим хаягийг нь хакерддаг. Баримт бичиг, гэрэл зураг, дүрс бичлэгийг хуурамчаар үйлдэн эмэгтэйчүүдийг соёлын хувьд зохисгүй байдлаар харагдуулахыг хичээдэг. Хаана үйлдэгдсэнээс үл хамааран эдгээр материал эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг гутаан доромжлох зорилготой.<sup>113</sup>



## АФГАНИСТАН УЛСЫН ИРГЭН МАЛАЛАЙ

**«Би ажлаасаа автомашинаар гэр рүү харьж явахад бөмбөг идэвхжиж, манай нөхөр нүүр, гартаа хүнд гэмтэл авсан. Азаар би хүүхдүүдтэй зугтан гарч, хөнгөн гэмтэл авсан ч машин тэр чигтээ сүйдсэн.»**

*Афганистаны охидын сургуулийн захирал асан Малалай (жинхэнэ нэр нь биш)  
2012 оны 2-р сард болсон явдлын талаар*

Сурган хүмүүжүүлэгчийн нь ажлаас үүдэлтэй Малалай болон гэр бүлд нь хэд хэдэн удаа халджээ. Малалай Европт цагаачлал эрэхээсээ өмнө буюу 2014 он хүртэл Афганистаны охидын сургуулийн захирлаар ажиллаж байсан Паштун үндэстэн эмэгтэй юм.

Оршиж суугаа газартаа охидын ахлах сургууль байгуулахаар кампанит ажил эхлүүлсэн үе буюу 2015 оноос Малалайг заналхийлж сүрдүүлсээр байв. Кампанит ажлынхаа зэрэгцээ эцэг эхчүүдэд охидоо боловсрол эзэмшихийг нь зөвшөөрөхийг ухуулан дэмжиж байв. Кампанит ажил олон нийтэд хүрэхийн хэрээр заналхийлэл нэмэгдсэн.

**«Мулла нар намайг буруу номтон, барууны үзэлтэн хэмээн буруутгаж, шашнаас татгалзсан гэж хэлж байв. Энэ бол суурь үзэлтэй уламжлалт нийгэмд хүмүүсийг эсрэг эргүүлэхэд хангалттай ...»**

Хэдэн жилийн дараа Малалай гэр бүлтэйгээ дахин халдлагад өртөв.

**«Гэрт зочидтой байхад манай байшинд халдсан. Шөнө дундын үед том дэлбэрэлт болохыг сонссон... Бид гүйж гараад, тоос, шороо харсан бөгөөд тэд манайхыг онилсон байсныг мэдсэн. Пуужин ариун цэврийн өрөөг сүйрүүлж, өөр нэг өрөөг эвдсэн. Бүх цонх, хаалга бутарсан. [Эрх баригчид энэ хэргийн талаар ямар ч арга хэмжээ аваагүй] Тэд зөвхөн «Тийм ээ тийм, бид нар мөрдөж байна, гэхдээ битгий хүндээр хүлээн аваарай» гэж хэлсэн.**

Малалай Афганистаны охидын боловсрол эзэмших эрхийн төлөөх тэмцлээ үргэлжлүүлсээр “Би боловсролын тугийг цэрэг хүн шиг үхэхээ хүртэл авч явсаар байх болно” гэж хэлжээ.<sup>114</sup>

## 6.2. ЛГБТИ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД

Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдын адил ЛГБТИ хүний эрхийн хамгаалагчид эрх баригчид, төрийн бус тоглогчдын зүгээс ажилд нь саад болох зорилготой олон арга хэмжээтэй тулгардаг. Эдгээр нь гүн гүнзгий ялгаварлан гадуурхах, шоовдорлох хандлагаас үүдэлтэй цахим, цахим бус хэлбэртэй байдаг.

<sup>112</sup> Amnesty International, *Defenders under attack! Promoting sexual and reproductive rights in the Americas* (Index: AMR 01/2775/2015).

<sup>113</sup> Amnesty International, *Defenders under attack! Promoting sexual and reproductive rights in the Americas* (Index: AMR 01/2775/2015)

<sup>114</sup> Amnesty International, *Their lives on the line: human rights defenders under attack in Afghanistan*, (ASA 11/1279/2015)

ЛГБТИ хүний эрхийн хамгаалагчид давхцсан ялгаварлан гадуурхалтыг даван туулах шаардлагатай. Хүний эрхийн хамгаалагчийн ажил, ЛГБТИ, трансжендэр, гей хүмүүсийг үзэн ядах айдсаас үүдсэн ялгаварлан гадуурхалт түгээмэл.

Эмнести Интернэшнл дэлхий даяар тэмдэглэн “Бахархлын жагсаал”-ыг хориглох буюу шаардлагагүй үед цагдаагийн хүч хэрэглэн тайван жагсааж, цуглаах, эрхийг олон удаа зөрчигдсөн, ЛГБТИ хүмүүс, түүний дотор хүний эрхийн хамгаалагчдын эсрэг халдлага, аллага үйлдсэн хэргүүдийг баримтжуулж аваад байна.

**Турк** улсад алдартай трансжендэр эрхийг хамгаалагч **Ханде Кадер** 2016 оны 8-р сард алагдсан. Түүний цогцос Истанбул хотын замын хажуугаас олдсон бөгөөд хүчирхийлж, зэрэмдэглэж, шатаасан байжээ.<sup>115</sup> Загвар зохион бүтээгч, ЛГБТИ хүмүүсийн эрхийн талаар идэвхтэй ажилладаг **Барбарос Сансалыг**<sup>116</sup> шинэ жилийн өмнөх үдшийн дүрс бичлэгт хийсэн тайлбар, твитерт бичсэн 2 бичлэгийнх нь төлөө “олон нийтийг үзэн ядалт, дайсагнасан хандлагад турхирсан” гэх үндэслэлээр урьдчилсан саатуулах газарт 2017 оны 1-р сарын 3-нд хорив. Түүнийг 3-р сарын 2-ны өдөр тодорхой нөхцөлтэйгээр сулласан ч үргэлжлүүлэн мөрдөн шалгасаар байна.

ЛГБТИ хүмүүс дэмжигчдийнхээ хамтдаа тэмдэглэдэг чухал арга хэмжээ болох “Бахархлын жагсаал”-ыг **Турк** улсад шударга бус, хуулиас гадуур аргаар улам бүр хориглосоор байна. 2015 онд жагсаалыг нэг өдрийн өмнө хориглосон бөгөөд цагдаа нар жагсагчдыг усаар шүршин, нулимс асгаруулагч хэрэглэн, чинжүүтэй сумаар буудсан байна. 2016 онд “Бахархлын жагсаал”-ыг мөн цуцалсан.<sup>117</sup>

**Индонезид** Исламын хамгаалагч фронтын гомдлыг хүлээн аваад Ментенг Жакартагийн цагдаагийн газар Арус **Пелани** хэмээх ЛГБТИ хүмүүсийн эрхийн байгууллагын зохион байгуулсан семинарыг 2016 оны 2-р сард тараав. Мөн сард урьдчилан мэдэгдээгүй гэх шалтгаанаар Ёгьякартад ЛГБТИ хүмүүсийг дэмжсэн тайван жагсаалыг зохион байгуулахад саад хийсэн. Үүнийг эс харгалзан зарим хүмүүс жагсаалд оролцсон ч ЛГБТИ хүмүүсийг эсэргүүцэгчидтэй мөргөлдсөн.<sup>118</sup>

2015 онд **Украины** Киев хотод “Бахархлын жагсаал” гей хүмүүсийг үзэн ядах хүчирхийлэлд хувирч дууссан бөгөөд олон арван хүн бэртэж гэмтсний дотор 10 жагсагч, наад зах нь 5 цагдаагийн ажилтан багтжээ. Төрийн байгууллагууд үйл ажиллагааг зохион байгуулагчидтай хамтран ажиллаагүй, эрх баригчдын зүгээс нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө авч хэрэгжүүлээгүй зэргээс хүмүүс бэртэж гэмтжээ.<sup>119</sup>

ЛГБТИ хүмүүсийн байгууллагууд хууль бус цахим хоригт өртдөг. АНУ, Канадын ЛГБТИ хүмүүсийн эрхийн тухай цахим хуудсуудыг **Этиопын** эрх баригчдын зүгээс 2016 онд хэдэн долоо хоногоор хаажээ. Трансжендэр хүмүүсийн нийгэмд хүлээн зөвшөөрөхийг дэмждэг АНУ-д төвтэй боловсролын байгууллага болох **Жендэрийн боловсролын олон улсын сан**, ижил хүйстний гэрлэлтийг дэмждэг Канадын вэбсайт **samesexmarriage.ca**, дижитал эрхийн талаар онлайн бодлогын судалгаа явуулах зорилготой, ЛГБТИ хүмүүсийг цахим шуудан, цахим хуудас, шуудангийн жагсаалт зэрэг төлбөргүй онлайн үйлчилгээгээр хангадаг ашгийн бус байгууллага болох Онлайн бодлогын бүлгийн цахим хуудсанд тус улсаас өргөн хүрээг хамарсан, хууль бус хяналт тогтоосны улмаас нэвтэрч болохгүй болов.<sup>120</sup>

<sup>115</sup> Profile from Frontline Defenders, see <https://www.frontlinedefenders.org/en/profile/hande-kader>

<sup>116</sup> Amnesty International, *Turkey: LGBTI activist held in pre-trial detention: Barbaros Şansal* (Index: EU 44/5431/2017)

<sup>117</sup> Amnesty International, *Turkey: Lift ban and protect Istanbul Pride* (Index: EUR 44/4283/2016)

<sup>118</sup> Amnesty International, *Indonesia: Stop inflammatory and discriminatory statements that put the LGBTI community at risk* (Index: ASA 21/3648/2016)

<sup>119</sup> Amnesty International, *Ukraine, Homophobic violence mars gay rally in Kyiv* (News story, 6 June 2015)

<sup>120</sup> Amnesty International, *Ethiopia: Government blocking of websites during protests widespread, systematic and illegal* (Index: AFR 25/5312/2016)

## 6.3. ЗАЛУУ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧИД

Залуу хүний эрхийн хамгаалагчид олон шатлалтай захирах ёсны хамгийн доод талд нь байж, насанд суурилсан ялгаварлан гадуурхалт бусад төрлийн дарамт шахалттай нүүр тулдаг. Хэрэг таригч, идеалист, төлөвшөөгүй гэх хэвшмэл ерөнхий ойлголтоос үүдэн олон залуу хүний эрхийг хамгаалагч бусдад үл итгэгдэх, дуу хоолойгоо гаргах боломжгүй байдаг. Залуучуудын тэргүүлдэг иргэний нийгмийн бүлгүүд өөрчлөлтийн гол хөдөлгөгч хүч байж, хүний эрхэд чухал хувь нэмэр оруулдаг ч хэт хязгаарлалт, дарамт шахалтаас болж амжилтанд хүрэх боломжгүй.

**Гяас Ибрахимод, Баярам Маммадов**<sup>121</sup> нар бол Азербайжаны Баку хотод амьдардаг оюутнууд, залуу идэвхтнүүд юм. **Азербайжаны** Ерөнхийлөгч асан Гейдар Алиевын хөшөөн дээр улс төрийн агуулгатай граффит зураг зурсны төлөө хилс хэрэг тулган баривчилсан бөгөөд 10 жилийн хорих ял ногдуулсан байна. Цагдаагийн байцаалтын үеэр дүрс бичлэг хийн бэлгийн хүчирхийлэлээр заналхийлж, зодож, цагдаагийн хэсгийн бие засах газрыг хүчээр цэвэрлүүлжээ.

**Lutte pour le Changement (LUCHA)** бол Ардчилсан Конго улсын залуучуудын тэргүүлдэг иргэний эрхийн хөдөлгөөн бөгөөд ардчилал, хариуцлага, хүний эрхийг дэмжих, хүндэтгэхтэй холбоотой асуудлаар ажилладаг. 2016 оны 12 дугаар сард мужийн захиргааны албан ажлын урд тайван суулт хийж, “хэн ч хуулиас дээгүүр биш”, “баяртай Кабила”, “Үндсэн хуулийг хамгаалах явдал гэмт хэрэг биш” гэх уриа лоозон барьсны төлөө LUCHA хөдөлгөөний 20 идэвхтэнг Гомад баривчлан, дараа нь суллажээ. 2016 оны 12-р сараас гянданд хоригдсоны дараа идэвхтнүүдийн нэг болох **Мусаса Цибанда** 2017 оны 2-р сард суллагджээ.<sup>122</sup>



### МЬЯНМАР УЛСЫН ИРГЭН ФЁО ФЁО АУНГ

Фёо Фёо Аунг бол залуу оюутны идэвхтэн бөгөөд Бүх Бирмийн оюутны холбооны ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж 2015 онд сургуулийн академик эрх чөлөөг хязгаарласан гэгддэг 2014 оны 9-р сард батлагдсан боловсролын шинэ хуулийг эсэргүүцсэн бослого хөдөлгөөнийг тэргүүлсэн. 2015 оны 3-р сард цагдаа нарт зодуулж, тайван жагсаал хийснийхээ төлөө жил гаруй хугацаанд хоригдсон Фёо Фёо Аунг болон тайван жагсаал хийсэн бусад залуучууд эрүүгийн ялаар шийтгүүлсэн бөгөөд олонх нь 9 жилийн ял авсан.

Фёо Фёо Аунг болон бусад оюутны удирдагчид тус улсын гол хот Янгунд нийлж уулзахаар товлон жагсаалыг 4 газарт зэрэг зохион байгуулжээ. Эрх баригчид оюутнуудыг жагсаалаа зогсохыг тушаасан. Түүний зэрэгцээ оюутны удирдагчид, парламентын төлөөлөлтэй хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар яриа хэлэлцээгээ үргэлжлүүлж, жагсаалаа түр хугацаанд зогсоогоод байв.

3-р сарын эхээр тохиролцоонд хүрээгүй учраас Летпадан, Баго муж дахь босогчид Янгун хүрэх жагсаалаа сэргээхээ мэдэгдсэн. Цагдаа нар хашиж, 8 өдрийн туршид бүслэн хаав. Энэ явдал 3-р сарын 10-нд дээд цэгтэй хүрч, цагдаа нар тайван жагсаалыг хүчээр тараажээ. Нүдээр үзсэн гэрчийн Эмнести Интернэшнлд мэдээлснээр цагдаагийн хаалтыг давахад нь зарим жагсаагчдыг цагдаа нар бороохойдсон.

Хаалтыг тайван замаар буулгахаар өмнө нь ярьж хэлэлцэхийг оролдож байсан Фёо Фёо Аунг бусад оюутны хамт цагдаа нарын бүслэн ойролцоох хийд рүү зугтан оржээ. Фёо Фёо Аунг хүчирхийлэл хэрэглэхгүй гэсэн баталгаатайгаар бууж өгөхийг санал болгоход нь цагдаа нар оюутнуудыг гавлан, цувруулан суулгаж, бороохойдон, эмэгтэй оюутнуудыг хүчиндэнэ гэж заналхийлсэн.

Мьянмарт шинэ Засгийн газар байгуулагдсаны дараа буюу 2016 оны 4-р сард Фёо Фёо Аунгийн суллаж, шүүхээс оюутнууд, жагсаагчдад тулгасан ялыг хүчингүй болгосон юм.<sup>123</sup>

<sup>121</sup> Amnesty International, *Azerbaijan: Youth activists detained, speak of ill-treatment* (Index EUR 55/4039/2016)

<sup>122</sup> Amnesty International, *Democratic Republic of Congo: Further Information: LUCHA activist released without charge: Musasa Tshibanda* (Index: AFR 62/5660/2017)

<sup>123</sup> Amnesty International, *Going back to the old ways: A new generation of prisoners of conscience in Myanmar* (Index: ASA 16/2457/2016), 8 October 2016; Amnesty International, *Myanmar: Student leaders released* (Index: ASA 16/3836/2016)



# 7. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЭРХ

**«Хүн бүр бие даан болон бусадтай эвлэлдэн нэгдэж, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэн биелүүлэх явдлыг дэмжих, түүний төлөө тэмцэх эрхтэй.»**

*Хүний эрхийн хамгаалагчдын тухай НҮБ-ын тунхаглал, 1-р зүйл*

Олон улсын хүний эрхийн эрх зүй, хэм хэмжээ нь хүний эрхийг хамгаалах эрхийг хараат бус, бие даасан байдлаар, хамгаалдаг. Хүний эрхийн хамгаалагчдын тунхаглалд энэ эрхийг тунхаглан зааж, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт”, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт” зэрэгт орсон заалтуудыг боловсронгуй болгосон.

Хүний эрхийн хамгаалагчдын тунхаглалд шинэ эрх, үүргийн талаар заагаагүй ч одоо байгаа эрх, үүргийг тодорхой болгож, хамааруулан хэрэглэсэн. Тунхаглалд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд хүний эрхийн хамгаалагчид чухал үүрэгтэй бөгөөд энэ нь давхар эрсдэлд оруулдаг тул ямар арга хэмжээ авах хэрэгтэйг тодорхой заажээ.

Хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, тэдгээрийг үр дүнтэй шийдвэрлэх, аюулгүй, боломжит орчинд ажлаа явуулах нөхцлөөр хангахад улс орнууд эцсийн хариуцлага хүлээнэ гэдгийг “Хүний эрхийн хамгаалагчдын тунхаглал”-д заажээ.<sup>124</sup>

## **ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ҮНДСЭН ҮҮРЭГ**

1. Оролцогч улс бүр, хүн бүр бие даан болон бусадтай эвлэлдэн нэгдэж өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд бүх эрх, эрх чөлөөгөө бодитойгоор эдлэхэд шаардагдах нийгэм, эдийн засаг, улс төрийн болон мөн хууль эрх зүйн баталгааг бүрдүүлж өгөхөд шаардагдах бүхий л нөхцөл байдлуудыг бий болгоход шаардлагатай алхмуудыг батлах замаар хүний бүхий л эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих болон хэрэгжүүлэх эн тэргүүний үүргийг хүлээнэ.
2. Оролцогч улс бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг үр дүнтэйгээр баталгаажуулсан байхад шаардлагатай хууль тогтоомж, захиргааны болон бусад алхамуудыг батлана.

*(Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглал, 2-р зүйл)*

<sup>124</sup> Declaration on the Right and Responsibility of Individuals, Groups and Organs of Society to Promote and Protect Universally Recognized Human Rights and Fundamental Freedoms, 1998, Art. 2.

Түүнчлэн, 2014 онд Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдын талаар тусгайлан гаргасан 68/181 тоот тогтоолд дараах байдлаар заажээ. Үүнд:

**«Хүний түгээмэл эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалахад хувь хүмүүс, бүлэг, нийгмийн байгууллагуудын талаарх тунхаглалд нийцүүлэн хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад бие даан болон бусадтай эвлэлдэн нэгдэх замаар хүний бүх эрх, суурь эрх чөлөөг дэмжин, хамгаалахад оролцож буй бүх насны эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлыг хамгаалахад оролцож буй бүх хүмүүс орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд чухал үүрэг гүйцэтгэдэг» гэжээ.**<sup>125</sup>

Энэхүү тогтоол эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдын гүйцэтгэж буй үүргийг хүлээн зөвшөөрч, хамгаалах үүрэг, хариуцлагаа биелүүлэхийг олон улс, бүс нутаг, үндэсний түвшинд ажиллаж буй бүх байгууллага, хамгаалалтын механизмд уриалжээ.

Олон төрлийн эрсдэл, хүний эрхийн зөрчлөөс хамгаалах, нөхөн төлбөр нэхэмжлэх, хариуцлага тооцуулахад нь хүний эрхийн хамгаалагчдыг дэмжих, арга хэрэгслээр хангах олон тооны байгууллага, механизм **бүс нутгийн түвшинд** ажилладаг. Ийм механизмд бүрэн дүн шинжилгээ хийх нь тайлангийн зорилго биш ч онцлох шаардлагатай тодорхой механизмууд бий.

Гуравдагч (буюу **Европын Холбооны** бус) орнуудад хүний эрхийн хамгаалагчдыг дэмжин, хамгаалах үйл ажиллагааг чиглүүлэхэд ЕХ болон түүний гишүүн орнууд олон тооны чухал амлалт авч, хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлээд байна.<sup>126</sup> Эдгээр нь улс төр, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх замаар хүний эрхийн хамгаалагчдын ажлыг хамгаалах, тэдэнтэй хамтран ажиллах, дэвшүүлсэн асуудлуудад нь хууль ёсны ач холбогдол өгөхөд ЕХ-ны гишүүн орнуудад боломж, бүрэн эрх олгох зорилготой. ЕХ-ны бус орнуудтай хүний эрхийн талаар яриа хэлэлцээ явуулах зэрэг ЕХ-ны журам нь хүний эрхийн хамгаалагчдад чухал орон зай олгож байна.<sup>127</sup>

**Европын зөвлөлийн** хувьд Хүний эрхийн комиссар нь хүний эрхийн хамгаалагчдын ажлыг дэмжих, хамгаалах үүрэгтэй бөгөөд ингэхдээ энэ талаарх хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь улс орнуудад тусладаг.<sup>128</sup> **Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага** (ЕАБХАБ) бүс нутагт тулгарч буй сорилтуудыг хянах, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор хүний эрхийн хамгаалагчдад зориулсан төвийг 2007 онд байгуулжээ. Тус байгууллага нь хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах тухай тусгай журмыг 2014 онд баталсан.<sup>129</sup>

**Хүний эрхийн Америк хоорондын комисс**, Хүний эрхийн Америк хоорондын шүүхээс бүрдэх Хүний эрхийн Америк хоорондын систем нь Америк тивд хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах явдлыг хөхиүлэн дэмжих, баталгаажуулах чухал үүрэгтэй. Дээрх хоёр байгууллагын аль аль нь хувь хүн эсвэл бүлэг хүмүүст нөхөж болзошгүй гарз учрах эрсдэл үүсгэж буй ноцтой, хойшлуулшгүй нөхцөлд арга хэмжээ авах боломжтой юм. Эдгээр арга хэмжээ нь хүний эрхийн хамгаалагчдын амь нас, бие махбодийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, халдлага, аюулгүй байдалтай холбоотой хэргийг сайтар мөрдөх арга хэмжээ авахыг улс орнуудад уриалдаг. Америк хоорондын комисс нь бүс нутагт хүний эрхийг хамгаалдаг бүх хүний нөхцөл байдлыг нарийвчлан ажиглах Тусгай илтгэгч ажиллуулдаг. Хүн болон хүмүүсийн эрхийн талаарх Африкийн комисс нь хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах тухай олон тооны тогтоол<sup>130</sup> гаргаснаас өөр иж бүрэн, цогц заавар, журам хараахан боловсруулж гаргаагүй байна.

2004 онд тус комисс Африк тивд хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах тухай тогтоол гаргаж, ингэхдээ илүү сайн хамгаалах үр дүнтэй стратеги боловсруулах, санал болгох үүргийг Хүний эрхийн хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчид ногдуулсан байна.<sup>131</sup>

<sup>125</sup> United Nations General Assembly, Promotion of the Declaration on the Right and Responsibility of Individuals, Groups and Organs of Society to Promote and Protect Universally Recognised Human Rights and Fundamental Freedoms: Protecting Women Human Rights Defenders, UN Doc. A/RES/68/181.

<sup>126</sup> European Union, EU Guidelines on Human Rights Defenders, available at <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=URISERV%3A133601>

<sup>127</sup> European Union, EU Guidelines on Human Rights Dialogues with non-EU Countries, available at [eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=URISERV%3Ar10115](http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=URISERV%3Ar10115)

<sup>128</sup> Council of Europe, Human Rights Defenders, available at [www.coe.int/en/web/commissioner/human-rights-defenders](http://www.coe.int/en/web/commissioner/human-rights-defenders)

<sup>129</sup> Organization for Security and Co-operation in Europe, Human Rights Defenders in the OSCE Region: Our Collective Conscience, 2007, available at [www.osce.org/odihr/29714](http://www.osce.org/odihr/29714); Organization for Security and Co-operation in Europe, Guidelines on the Protection of Human Rights Defenders, 2014, available at [www.osce.org/odihr/guidelines-on-the-protection-of-human-rights-defenders](http://www.osce.org/odihr/guidelines-on-the-protection-of-human-rights-defenders)

<sup>130</sup> African Commission on Human and Peoples' Rights, Resolution 336 on Measures to Protect and Promote the Work of Women HRDs, ACHPR/Res. 336 (EXT.OS/XIX) 2016, available at [www.achpr.org/sessions/19th-20th/resolutions/336/](http://www.achpr.org/sessions/19th-20th/resolutions/336/); African Commission on Human and Peoples' Rights, Resolution 119 on the Situation of HRDs in Africa, available at [www.achpr.org/sessions/42nd/resolutions/119/](http://www.achpr.org/sessions/42nd/resolutions/119/); African Commission on Human and Peoples' Rights, Resolution 69 on the Protection of HRDs in Africa, available at [www.achpr.org/sessions/35th/resolutions/69/](http://www.achpr.org/sessions/35th/resolutions/69/)

<sup>131</sup> African Commission on Human and Peoples' Rights, Resolution on the Appointment of a Special Rapporteur on Human Rights Defenders in Africa, 2010, available at <http://www.achpr.org/sessions/48th/resolutions/171/>

2016 онд хамгийн сүүлд гаргасан тогтоолдоо Хүний болон ард түмнүүдийн эрхийн асуудлаарх Африкийн комисс хүний эрхийн хамгаалагчдыг дэмжих, хамгаалах хууль тогтоомж, арга хэмжээг батлах, эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тусгай хэрэгцээ шаардлагыг харгалзах, эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийг шийдвэрлэх хүчин чармайлтыг тэдэнтэй зөвлөлдсөний үндсэн дээр тогтоох, хянах, эрсдэл, хамгааллын тусгай хэрэгцээ шаардлагын талаар холбогдох бүх байгууллагад сургалт явуулахыг улс орнуудад уриалсан.<sup>132</sup>

Хүний эрхийн хамгаалагчдын ажлыг илүү сайн хамгаалах, дэмжихээр **үндэсний түвшинд** хэд хэдэн улс арга хэмжээ авчээ. Латин Америкт **Колумби**<sup>133</sup>, **Гондурас**<sup>134</sup>, **Гватемал**<sup>135</sup>, **Мексик**<sup>136</sup>, **Бразил**<sup>137</sup> зэрэг олон орон хүний эрхийн хамгаалагчид болон бусад эрсдэлд орсон бүлгүүдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээгээр хангах үндэсний хамгаалалтын механизм байгуулсан. Гэсэн хэдий ч ийм механизмуудын бүрдүүлсэн нөөц, үр дүнтэй хэрэгжүүлэх бололцоо дутмаг байгаад тухайн орны иргэний нийгмийн байгууллагууд санаа зовниж буйгаа илэрхийлсэн.<sup>138</sup> **Зааны ясан эрэг**<sup>139</sup>, **Ардчилсан Бүгд найрамдах Конго**<sup>140</sup>, **Монгол** зэрэг бусад оронд хүний эрхийн хамгаалагчдын хамгаалах зорилготой хууль тогтоомжийн талаар хэлэлцэж байна. Норвеги<sup>141</sup>, Швейцарь<sup>142</sup>, Канад<sup>143</sup> зэрэг зарим улс гуравдагч орнуудад хэрхэн хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах, хүлээн зөвшөөрүүлэх талаар дипломат ажилтнуудад заавар, зөвлөмж өгөх зорилготой журам батлан гаргав.

“Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглал” батлагдснаас хойш 20 жилийн хугацаанд хамгаалалтын тогтолцоо бэхжээгүй, бүрэлдэх төдий байна. Энд хэд хэдэн гол зарчмыг бүрдүүлэх хэрэгтэй бөгөөд үүнд “... нутгийн иргэдийг өөрчлөлтийн гол хөдөлгөгч гэж үзэх, иргэний нийгмийн орон зайг дэмжих, хамгаалахын ач холбогдол, хувь хүмүүс, бүлгүүд, орон нутгийнхны тусгай хэрэгцээ шаардлагад нийцсэн хамгаалалтыг авах, хөндлөнгөөс оролцох, хариу үйлдэл үзүүлэх, арга хэмжээ авах зэргээр хүний эрхийг хамгаалах “аюулгүй, боломжит орчин”-г бүрдүүлэх хүчин чармайлтыг тусгах шаардлагатай байна.<sup>144</sup>

## **ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ХАМГААЛАХ ЗАГВАР ХУУЛЬ: «ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН ТУХАЙ ТУНХАГЛАЛ»-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ПРАКТИК УДИРДАМЖ**

Хүний эрхийн олон улсын үйлчилгээний байгууллагаас ( International Service for Human Rights) “Хүний эрхийн хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах загвар хууль”-ийг боловсруулах ажлыг 2016 оны 6-р сард эхлүүлсэн. Энэ нь хүний эрхийн хамгаалагчдын ажлыг дэмжих, заналхийлэл, халдлагаас хамгаалах зохистой хууль, бодлого, институтууд боловсруулах талаар техникийн зөвлөгөө өгөх замаар “Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглал”-ыг хэрэгжүүлэх удирдамжаар улс орнуудыг хангадаг. Загвар хуулийг бүс нутаг бүрийг төлөөлсөн 500 гаруй хуульч боловсруулсан бөгөөд хүний эрхийн шилдэг өмгөөлөгчид, хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч нар санал нэгдэн баталжээ.<sup>145</sup>

<sup>132</sup> African Commission on Human and Peoples' Rights, Resolution on Measures to Protect and Promote the Work of Women Human Rights Defenders, ACHPR/Res. 336 (EXT.OS/XIX) 2016, available at [www.achpr.org/sessions/19th-ec/resolutions/336/](http://www.achpr.org/sessions/19th-ec/resolutions/336/)

<sup>133</sup> The National Protection Unit (Unidad Nacional de Protección – UNP)

<sup>134</sup> The Law to Protect HRDs, Journalists, Social Commentators and Justice Officials (Protection Law)

<sup>135</sup> Internal Agreement 11-2004 of the Presidential Commission on Human Rights in Guatemala (COPREDEH)

<sup>136</sup> Law for the Protection of HRDs and Journalists

<sup>137</sup> National Programme for the Protection of HRDs

<sup>138</sup> Protection International, Focus 2014, available at <http://protectioninternational.org/publication/focus-2014/>

<sup>139</sup> Law 2014-388 on the Promotion and Protection of Human Rights Defenders

<sup>140</sup> Following consultation with NGOs, law no. 13/011 was promulgated on 21 March 2013 to create a National Commission on Human Rights (CNDH). The CNDH is yet to receive a budget and Commissioners yet to sit. Taken from [www.ishr.ch/sites/default/files/article/files/drc\\_-\\_ishr\\_briefing\\_on\\_hrds.pdf](http://www.ishr.ch/sites/default/files/article/files/drc_-_ishr_briefing_on_hrds.pdf)

<sup>141</sup> Government of Norway, Norway's efforts to support HRDs: Guide for the foreign service, 2010, available at [www.regjeringen.no/contentassets/b7384abb48db487885e216bf53d30a3c/veiledningmrforkjengelskfin.pdf](http://www.regjeringen.no/contentassets/b7384abb48db487885e216bf53d30a3c/veiledningmrforkjengelskfin.pdf)

<sup>142</sup> Government of Switzerland, The Swiss Guidelines on the Protection of HRDs, 2013, available at [www.eda.admin.ch/dam/eda/en/documents/publications/MenschenrechtshumanitaerePolitikundMigration/Leitlinien-zum-Schutz-von-HRD\\_en](http://www.eda.admin.ch/dam/eda/en/documents/publications/MenschenrechtshumanitaerePolitikundMigration/Leitlinien-zum-Schutz-von-HRD_en)

<sup>143</sup> Government of Canada, Human Rights Defenders, available at [international.gc.ca/world-monde/world\\_issues-enjeux-mondiaux/rights\\_defenders-defenseurs\\_droits.aspx?lang=eng](http://international.gc.ca/world-monde/world_issues-enjeux-mondiaux/rights_defenders-defenseurs_droits.aspx?lang=eng)

<sup>144</sup> Bennet, K. et al, Critical perspectives on the security and protection of HRDs, *International Journal of Human Rights*, Volume 18, number 7, 2015

<sup>145</sup> International Service for Human Rights, Model law for the recognition and protection of human rights defenders, available at [www.ishr.ch/sites/default/files/documents/model\\_law\\_full\\_digital\\_updated\\_15june2016.pdf](http://www.ishr.ch/sites/default/files/documents/model_law_full_digital_updated_15june2016.pdf)

# 8. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дэлхий даяар улс орнууд хүний эрхийн хамгаалагчдын эрхийг хүндэтгэн, хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаагийн дотор эрсдэлд учирсан хүний эрхийн хамгаалагчдад зориулсан үр дүнтэй хамгаалалтын механизм хэрэгжүүлэхгүй буюу тэдэнд халдсан этгээдүүдэд хариуцлага хүлээлгэхгүй байна. Эмнести Интернэшнл хүний эрхийн хамгаалагчдын болон ажлынх нь хууль ёсны байдлыг улс орнуудаар ил тод, олон нийтийн өмнө хүлээн зөвшөөрүүлэх, үр дүнтэй хамгаалалт тогтоох хууль тогтоомж батлуулах, хэрэгжүүлэх чиглэлээр кампанит ажил өрнүүлж байна. Үүнд хүний эрхийг урагшлуулахад хувь нэмэр оруулж буй хүмүүсийг хүлээн зөвшөөрөх асуудал хамаарах ёстой. Ажлаа явуулахад нь шаардлагатай чадавх, арга хэрэгсэл, сургалтгүйгээр хүний эрхийн хамгаалагчид дэлхий ертөнцийг илүү аюулгүй, шударга болгохоор үр дүнтэй ажиллах боломжгүй юм. Цаашлаад улс орнууд өөр хоорондоо, бусад оронд үйл ажиллагаа явуулж буй хүний эрхийн хамгаалагчидтай холбогдож, нухчин даруулах айдасгүйгээр үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд шийдвэр гаргагчдад хүрч ажиллах бололцоогоор хүний эрхийн хамгаалагчдыг хангах шаардлагатай.

Дэлхий бүх улс эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид, эмэгтэйчүүдийн эсвэл жендэртэй холбоотой эрхийн асуудлаар ажиллаж буй хүмүүсийн гүйцэтгэдэг үүргийн ач холбогдлыг анхаарах шаардлагатай байна. Эдгээр хүний эрхийн хамгаалагчид ажлынхаа явцад өөрийн онцлог шинжээс үүдэн онцгой эрсдэлтэй тулгардаг. Тиймээс тэдэнд хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас хамгаалагдах үр дүнтэй хамгаалалт чухал юм.

Хүний эрхийн хамгаалагчдын эсрэг үйлдсэн халдлага хямралт хэмжээнд хүрлээ. Эмнести Интернэшнл хүний эрхийн хамгаалагчид, иргэний нийгмийг аюулгүй, боломжит орчноор хангахын эхлэл болгон улс орнууд, компаниуд, бүс нутаг, олон улсын хүний эрхийн байгууллагуудад дараах зөвлөмж өгч байна. Хувь хүмүүс шударга бус явдлыг мэдэрсэн, тэмцэхдээ халдлага, заналхийлэл, бусад хэлбэрийн айлган сүрдүүлэг амсалгүй ажиллах боломжтой байхын тулд дараах арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай.

## **ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ УЛС ОРНУУДАД УРИАЛЖ БАЙНА. ҮҮНД:**

**ХҮНИЙ ЭРХИЙГ УРАГШЛУУЛАХАД ОРУУЛЖ ХУВЬ НЭМРИЙГ ҮНЭЛЭН ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН ХУУЛЬ ЁСНЫ БАЙДЛЫГ ТОДОРХОЙ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, АЖЛЫГ НЬ ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙГЭЭР ДЭМЖИХ. ЯЛАНГУЯА:**

- Хүний эрхийн хамгаалагчдын ажлын талаар олон нийтэд таниулах кампанит ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, өргөн олонд түгээх;
- Хүний эрхийн хамгаалагчдын тухай НҮБ-ын тунхаглалыг дэмжих, олон нийтэд түгээх, үр дүнтэй хэрэгжүүлэх үндэсний хууль тогтоомж батлах;

- Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид, эмэгтэйчүүдийн эсвэл жендэртэй холбоотой эрхийн асуудлаар ажиллаж буй хүмүүсийн гүйцэтгэдэг тусгай, үүргийн ач холбогдлыг олон нийтийн өмнө хүлээн зөвшөөрөх, хүчирхийлэл, аливаа төрлийн гадуурхалтаас ангид орчинд ажиллах боломжоор хангах;
- Хүний эрхийн хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах хууль тогтоомжийг батлах, хэрэгжүүлэх, хүний эрх, тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөг дэмжих, хамгаалах зорилготой хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанд саад учруулсан хууль тогтоомжийг хүчингүй болгох, өөрчлөх;
- Хүний эрхийн хамгаалагчдын эсрэг үйлдсэн халдлага, айдас, сүрдүүлгийг ил тод зэмлэн буруушаах;
- Гэмт хэрэгтэн, “гадаадын агент”, террорист, сэжигтэй этгээд, ёс суртахуунгүй этгээд, аюулгүй байдал, хөгжил дэвшил, уламжлалт үнэт зүйлд аюул учруулагч гэх зэргээр хүний эрхийн хамгаалагчдыг гутаан доромжлох, эрхийг нь зөрчих, ялгаварлан гадуурхах үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх.

### **ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫГ ҮР ДҮНТЭЙ ХАМГААЛАХ, ЯЛ ШИЙТГЭЛ, НҮХЧИН ДАРАХ, СҮРДҮҮЛЭГТ ӨРТӨХ АЙДАСГҮЙГЭЭР ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ АЮУЛГҮЙ, ҮР ДҮНТЭЙ ОРЧНООР ХАНГАХ. ЯЛАНГУЯА:**

- Хүний эрхийн хамгаалагчдад учирсан аюул, халдлага, дарамт, сүрдүүлгийг үр дүнтэй шийдвэрлэх, хүний эрхийн зөрчлийг нухацтай, шуурхай, бие даасан байдлаар мөрдөн шалгах, гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдүүдэд цаазын ял оноолгүйгээр шударга шүүхээр шүүх, хохирогчдод үр дүнтэй нөхөн олговор олгож, хохирлыг нь зохистойгоор барагдуулах;
- Хүний эрхийн хамгаалагчид, иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөн хүний эрхийн хамгаалагчдад чиглэсэн урьдчилан сэргийлэх, хамтын, жендэрийн мэдрэмжтэй арга хэрэгсэл нэгтгэсэн үндэсний хамгааллын механизм бий болгох;
- Учирч болох тодорхой сорилт, эрсдэл, хүчирхийллийн хэлбэрүүдийг тодорхойлсны үндсэн дээр ажлын онцлогийн улмаас нүүрлэж болзошгүй жендэрт суурилсан аюул, хүчирхийллээс эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тодорхой хамгаалалт бүрдүүлэх;
- Хүний эрхийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд оролцож буй залуу хүний эрхийн хамгаалагчид, залуучуудын тэргүүлсэн байгууллагуудыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах зохистой арга хэмжээ авах, олон нийтийн шийдвэр гаргах үйл явцад залуу хүмүүс оролцохыг хязгаарласан насанд суурилсан ялгаварлан гадуурхах практикийг устгах, залуу хүний эрхийн хамгаалагчид, залуучуудын тэргүүлсэн байгууллагуудын шаардлагатай нөөцөөр хангах;
- Хууль шүүхийн тогтолцоог хүний эрхийн хамгаалагчдын эсрэг эсвэл дарамтлахад ашиглахгүй байх, зөвхөн эрхээ тайван замаар эдэлснээс нь үүдэн эрүүгийн болон бусд төрлийн хэрэг үүсгэх, захиргааны арга хэмжээ авахаас зайлсхийх.

### **ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫГ АЖЛАА ЯВУУЛАХ БОЛОЛЦОО, ЧАДАВХТАЙ БОЛОХОД НЬ ШААРДЛАГАТАЙ, АРГА ХЭРЭГСЭЛ, СУРГАЛТААР ХАНГАГДАХ ЯВДЛЫГ ХӨНГӨВЧЛӨХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ. ЯЛАНГУЯА:**

- Хүний эрхийн хамгаалагчдын мэдлэг, чадвар, эрхээ хамгаалах, аюулгүй байдлаа хангах чадавхыг бэхжүүлэх бодитой арга замуудыг тогтоох;
- Үндэсний хүний эрхийн байгууллагуудыг бэхжүүлэх, тэднийг ажил, үүргээ үр дүнтэй биелүүлэхэд нь шаардлагатай хүний болон санхүүгийн нөөц, хамгаалал, дэмжлэг багтаасан тодорхой эрх мэдлээр хангах.

## **ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД АЖИЛЛАЖ БҮЙ ГАЗАРТАА ӨӨР ХООРОНДОО ХОЛБОГДОХ АРГА ЗАМААР ХАНГАХ, ҮНДЭСНИЙ, БҮС НУТГИЙН, ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ШИЙДВЭР ГАРГАГЧДАД АЮУЛГҮЙ АРГА ЗАМААР ХҮРЧ АЖИЛЛАХ БОЛОМЖТОЙ БАЙХ. ЯЛАНГУЯА:**

- Хүний эрхийн хамгаалагчдыг дэмжих, хамгаалахад чиглэсэн үндэсний болон бүс нутгийн сүлжээ үүсгэх;
- Хүний эрхийн хамгаалагчдад чиглэсэн хууль тогтоомж, механизм батлахдаа хөдөө орон нутаг буюу тухайн газар оронд ажиллаж буй хүний эрхийн хамгаалагчдыг хамруулсан оролцоог төлөвшүүлэх;
- Харилцаа холбоог мөшгин хянадаг ажиллагааг олон улсын эрх зүй, хэм хэмжээнд нийцүүлэх, олон нийтийг ялгалгүйгээр нийтээр нь мөшгин хянахын эсрэг үр дүнтэй хамгаалалттай байх, шифрийн нууцлал зэрэг харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэрэгслийг хүний эрхийн хамгаалагчид ашиглах боломжоор хангах;

## **ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ КОМПАНИУДАД УРИАЛЖ БАЙНА. ҮҮНД:**

- Компаниуд, түүний салбар аж ахуйн нэгж, гэрээт компаниуд эсвэл ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн хувь хүн, орон нутгийнхан, хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалахад чиглэсэн хүний эрхийн зохистой арга хэмжээ, журам хэрэгжүүлэх;
- Хүний эрхийн хамгаалагчдыг гутаах, гүтгэх, доромжлох мэдэгдэл гаргах, тийм үзэл бодол илэрхийлэхээс зайлсхийх;
- Төслийн төлөвлөгөө, хэрэгжилтийн чухал үе шатуудад хүний эрхийн хамгаалагчидтай үр дүнтэй зөвлөгөөн, уулзалт зохион байгуулах, бизнесийн төслүүдийн талаарх холбогдох бүх мэдээлэл, хүний эрхэд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаарх мэдээллийг олон нийтэд шуурхай өгч байх;
- Компаний төслүүдийг эсэргүүцсэн эсвэл тэдгээрийн талаар үзэл бодлоо илэрхийлсэн хүний эрхийн хамгаалагчдын эсрэг халдлага, аюул занал, сүрдүүлгийг үл тэвчих бодлого хэрэгжүүлэх;
- Компаний төслүүдийг эсэргүүцсэн эсхүл тэдгээрийн талаар үзэл бодлоо илэрхийлснийх нь улмаас хүний эрхийн хамгаалагчдын эсрэг халдлага, аюул занал, сүрдүүлэг үйлдсэн талаар мөрдөхөд төрийн байгууллагуудтай хамтран ажиллах.

## **ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ОЛОН УЛСЫН БОЛОН БҮС НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД УРИАЛЖ БАЙНА. ҮҮНД:**

- “Хүний эрхийн хамгаалагчдын тунхаглал”-д заасны дагуу хүний эрхийг хамгаалан, дэмжих зорилгоор хүн бүр бие даан ажиллах юмуу эсвэл бусадтай нэгдэх эрхийг баталгаажуулах;
- Хүний эрхийн хамгаалагчдын ажлын чухал ач холбогдол, хууль ёсны байдлын талаар олон нийтэд хандсан мэдэгдлийг цаашид ч үргэлжлүүлэн хийж байх;
- Хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах үүргээ улс орнууд хэрэгжүүлж байгаад, түүний дотор эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдад тодорхой анхаарч буй эсэхийг хянах;
- Олон улсын болон бүс нутгийн механизмуудтай харилцдаг хүний эрхийн хамгаалагчдын эсрэг айлган сүрдүүлэх, нухчин дарах үйлдэл гарахаас сэргийлэх, тэмцэх бодлого боловсруулах, механизмыг бэхжүүлэх, тэднээс хүлээн авсан мэдээлэл эрсдэлд оруулахгүй нөхцлийг хангах.

**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ БОЛ  
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ  
ДАЯН ДЭЛХИЙН ХӨДӨЛГӨӨН.  
НЭГ Л ХҮНИЙ ЭРХ  
ЗӨРЧИГДВӨЛ ЭНЭ НЬ БИД  
БҮГДЭД ХАМААТАЙ.**

Холбоо барих



[info@amnesty.org](mailto:info@amnesty.org)  
[mongolia.amnesty@gmail.com](mailto:mongolia.amnesty@gmail.com)



+44 (0)20 7413 5500  
+976 7000 4708



[www.facebook.com/AmnestyGlobal](http://www.facebook.com/AmnestyGlobal)  
[www.facebook.com/Amnesty International](http://www.facebook.com/AmnestyInternational)  
Mongolia - Монголын Эмнести Интернэшнл



@AmnestyOnline

# АЮУЛ ДУНДАХ ХҮНИЙ ЭРХИЙН

## ХАМГААЛАГЧИД

### ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОН ЗАЙ ХУМИГДАЖ БАЙНА

Дэлхийн эрх мэдэлтэй хэсэг айдас, хуваагдлыг өөгшүүлсэн үг хэллэг хэрэглэн нийгмийн сөрөг үзэгдэл бүхэнд цөөнх хэсгийг буруутгаж байгаа энэ үед шударга бус явдлын эсрэг, хүний эрхийг хамгаалдаг хүмүүс аюулд өртсөөр байна.

Дэлхий даяарх хүний эрхийн хамгаалагчид дарамт, заналхийлэл, гутаан доромжлол, зүй бусаар харьцах, хууль бусаар хорих зэрэгтэй нүүр тулгарч, тэр ч бүү хэл амь насаа алдах явдал нэмэгдсээр байна. 2016 онд удаан хугацааны турш эдийн засгийн ашиг сонирхлыг сөрж, байгаль орчныг хамгаалж, цөөнхийг өмгөөлсөн буюу эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эрхэд учирдаг уламжлалт хориг саадыг эсэргүүцсэнийнхээ төлөө наад зах нь 281 хүний эрхийн хамгаалагч 22 улсад амь насаа алдлаа.

Хүний эрхээс өөрсдийн эрх ашгийг дээгүүрт тавин хамгаалахын тулд Засгийн газрууд, зэвсэгт бүлэглэлүүд, бизнесийн байгууллагууд болон бусад эрх мэдэлтэй хэсэг ихэнх оронд шүүмжлэлийг дуугүй болгох арга хэмжээгээ идэвхжүүлж байна. Үүний зэрэгцээ хүний эрхийн хамгаалагчдыг гэмт хэрэгтэн, сэжигтэй этгээд, террорист, хөгжлийг эсэргүүцэгч байдлаар дүрслэн газар сайгүй ярих боллоо.

Ийм нөхцөлд энэ тайлан нь хүний эрхийн хамгаалагчдад заналхийлэх, халдах, иргэний нийгмийн ажиллах орон зайг хумих зорилготой эрх мэдэлтнүүдийн үйлдэлтэй тэмцэхээр эхлүүлсэн Эмнести Интернэшнлийн дэлхий даяарх: “Зоригтон” кампанит ажлын нэг хэсэг билээ. Уг тайланд хүний эрхийн хамгаалагчдад тулгарч буй аюулын талаар тоймлон дүгнэсэн бөгөөд хүний эрхийн хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах, аюулгүй орчинд ажлаа хийх арга хэрэгслээр хангахад чиглэсэн арга хэмжээг хойшлуулалгүй авахыг эрх мэдэлтнүүдэд уриалсан болно.